



ШҮҮХИЙН СУРГАЛТ, СУДАЛГАА
МЭДЭЭЛЛИЙН ХҮРЭЭЛЭН



ХАННС-ЗАЙДЕЛИЙН САН

МОНГОЛЫН ТӨР, ЭРХ ЗҮЙ

ДОТООДЫН МЭРГЭЖЛИЙН, ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ
УЛИРАЛ ТУТМЫН СЭТГҮҮЛ

2022 № 4 (102)

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

ЭРХЛЭГЧ:

Д.ЭРДЭНЭЧИМЭГ

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/
Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн захирал

ГИШҮҮД:

Ж.АМАРСАНАА

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D/

С.НАРАНГЭРЭЛ

Академич, Хууль зүйн шинжлэх ухааны доктор /Sc.D/

Ж.БЯМБАА

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

Ч.ХОСБАЯР

Улсын Дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын тэргүүн

Г.БАНЗРАГЧ

Улсын Дээд шүүхийн шүүгч, Хууль зүйн ухааны доктор /Ph.D/,

Д.ЦОЛМОН

Улсын дээд шүүхийн шүүгч

Н.БАЯРМАА

Улсын дээд шүүхийн шүүгч

Д.ГАНГАБААТАР

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

Б.ӨЛЗИЙСАЙХАН

Хууль зүйн ухааны доктор /Ph.D/

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:

О.ТЭНХЛҮҮН

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн
Захиргааны эрх зүйн судлаач

ӨМНӨХ ҮГ

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэн Монголын төр, эрх зүй сэтгүүлийн 102 дугаар цувралаар Монголын Хуульчдын холбооны Шүүгчдийн хорооноос бүх шатны шүүгчдийн дунд зарласан “Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Тулгамдаж буй асуудал” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд шалгарсан шүүгч нарын өгүүлийг хүргэж байгаадаа баяртай байна.

Тус уралдаан нь шүүгчийн бүтээлч сэтгэлгээ, шинжлэх ухаанч хандлагыг нэмэгдүүлэх, онол-практикийн мэдлэгийг гүнзгийрүүлэх, шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй тодорхойлох, хуулийн хэрэглээ, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгоход шүүгч нарын үзэл бодлыг сонсох зорилготой байсан тул шүүгч нарын бүтээлийг олон нийтэд хүргэхээр хэвлэн нийтэлж байгаа нь ач холбогдолтой байна.

Түүнчлэн энэ удаагийн дугаарт бид Жексон эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байгууллагын нэхэмжлэлтэй Миссиссипи мужийн эрүүл мэндийн газрын ажилтан Томас Доббс-т холбогдох үр хөндөлт хууль

бус эсэх талаарх хэргийг шийдвэрлэсэн АНУ-ын дээд шүүхийн шийдвэрийн орчуулгыг хэвлэн нийтлэхээр бэлдлээ.

Энэ дугаарт нийтлэгдэж буй өгүүлэлд хянан магадалгаа хийж, сэтгүүлийн чанарыг дээшлүүлэхэд хамтран ажилласан редакцын зөвлөлийн гишүүн, хууль зүйн доктор, профессор Ж.Бямбаа, Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимын тэргүүн шүүгч Ч.Хосбаяр, шүүгч Б.Батцэрэн, Д.Цолмон, Г.Банзрагч /Ph.D/, Н.Баярмаа /Ph.D/, нарт талархал илэрхийлж байна.

Эцэст нь шүүгчийн бүтээлч сэтгэлгээг хөгжүүлэх, шинжлэх ухаанч хандлагыг нэмэгдүүлэх зорилгоор хамтран ажилласан Монголын хуульчдын холбооны Шүүгчдийн хорооны тэргүүн, шүүгч Ц.Оч болон хамтран ажилласан бусад гишүүдэд мөн талархал илэрхийлье.

Цаашид бид сэтгүүлийн чанарыг дээшлүүлэхэд ямагт анхаарч эрх зүйн тулгамдсан асуудлыг хөндсөн, шийдэл эрэлхийлсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй, онол, практикийн судалгааг хянан магадалгаа хийлгэсний дараа хэвлэн нийтлэхдээ үргэлж нээлттэй байх болно.

СЭТГҮҮЛИЙН ЭРХЛЭГЧ

Д.ЭРДЭНЭЧИМЭГ /Хууль зүйн доктор, дэд профессор/

АГУУЛГА

I ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭ, СУДАЛГАА

- Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач Б.Батбаяр
Хэлбэрийн шаардлага зөрчсөн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг хадгалах онол, практикийн асуудал: харьцуулсан судалгаа 7
- Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач З.Янжинлхам
Restorative Justice Concept буюу Шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлал ба эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага 17
- Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч А.Түвшинтулга
Шүүгчийн туслах Г.Цэрэндэжид
Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудал 31
- Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн Ерөнхий шүүгч Д.Азжаргал
Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: Баривчлах, цагдан хорих ажиллагаанд анхаарах зарим асуудал 53
- Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Б.Мандалбаяр
Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль дахь арбитрын ажиллагаатай холбоотой анхаарах асуудал 71
- ## II ҮЗЭЛ БОДОЛ /СЭДЭМЖ, ЯРИЛЦЛАГА, ШҮҮМЖ/ СЭДЭМЖ
- Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.Галбадар
Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ ба хүний эрх 84
- Хэнтий аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч Б.Марина
Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд тулгамдаж буй асуудал 93
- Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч Т.Ариунболд
Шүүгчийн ёс зүй ба зан суртал 99
- Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Ж.Байгалмаа
Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Т.Энхтуяа
Хэргийн оролцогчдын хүсэлт гаргах эрх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлж байгаа байдал 106

III МЭДЭЭ МЭДЭЭЛЭЛ /ЭХ СУРВАЛЖ, ОРЧУУЛГА/ ОРЧУУЛГА

Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач А.Нэмүүлэн
Америкийн нэгдсэн улсын дээд шүүхийн шийдвэрийн хураангуй

115



**ХЭЛБЭРИЙН ШААРДЛАГА ЗӨРЧСӨН ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН
ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭХ ХЭЛЦЛИЙН ХҮЧИН ТӨГӨЛДӨР
БАЙДЛЫГ ХАДГАЛАХ ОНОЛ, ПРАКТИКИЙН АСУУДАЛ:
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

**ISSUE OF THEORETICAL AND PRACTICAL ON CURING LACK
OF FORMALITIES RELATED TO CONVEYANCING CONTRACT:
COMPARATIVE STUDY**

Баасандоржийн БАТБАЯР¹

- I. Оршил
- II. Хэлбэрийн шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэх хэлцэл практикт их хэмжээгээр байгуулагдаж буй шалтгаан, хуулиар тогтоосон хэлбэрийн шаардлага
- III. Хэлбэрийн шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгийн хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг хадгалж буй дотоодын шүүхийн практик
- IV. Хэлбэрийн шаардлага зөрчсөн хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг хадгалах онолын үндэс, гадаад орнуудын шүүхийн практик
- V. Санал, дүгнэлт
- VI. Ном зүй

¹ УДШ-ийн дэргэдэх ШССМХ-ийн Эрүүгийн эрх зүйн секторын судлаач, МУИС-ийн ХЗС-ийн магистрант



**ХЭЛБЭРИЙН ШААРДЛАГА ЗӨРЧСӨН ҮЛ ХӨДЛӨХ
ХӨРӨНГИЙН ӨМЧЛӨХ ЭРХИЙГ ШИЛЖҮҮЛЭХ
ХЭЛЦЛИЙН ХҮЧИН ТӨГӨЛДӨР БАЙДЛЫГ
ХАДГАЛАХ ОНОЛ, ПРАКТИКЫН АСУУДАЛ:
ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА**

Б.БАТБАЯР. УДШ-ийн дэргэдэх ШССМХ-ийн Эрүүгийн эрх зүйн
секторын судлаач, МУИС-ийн ХЗС-ийн магистрант

Түлхүүр үг

Хүчин төгөлдөр бус байдал, шүүхийн практик, харилцан итгэлцэл, шударга ёсны зарчим, өмчийн эрх зүйн амлалтаа үл зөрчих зарчим, эрхээ урвуулах.

Хураангуй

Энэхүү өгүүллээр хэлбэрийн шаардлага зөрчсөн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх хэлцэл дийлэнх тохиолдолд практикт ямар шалтгаанаас үүдэж байгуулагдаж байгааг хууль тогтоомжийн хүрээнд судалж, нэгэнт байгуулагдсан хэлбэрийн шаардлага хангаагүй хэлцлийг талуудын ашиг сонирхлын дагуу хүчин төгөлдөр байдлыг нь хадгалах онолын үндэслэл, шүүхийн практикийг гадаад орнуудтай харьцуулан судалж, танилцуулсан.

I. Оршил

Дийлэнх хүмүүс бүхий л амьдралынхаа туршид маш өндөр үнийн дүнтэй, чухал ач холбогдол бүхий хэлцэлд цөөн удаа ордог байна. Эдгээр цөөн тохиолдлуудаас тэргүүн эгнээнд бичигдэх хэлцэл нь “үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх” юм. Учир нь хүн амын тоо өсөхийн хэрээр газар нутаг, дэд бүтцийн хязгаарлагдмал байдлаас шалтгаалж, үл хөдлөх хөрөнгийн үнэ цэн өдөр ирэх тусам өсөх зүй тогтолтой байдаг. Нөгөөтээгүүр хүний оршин тогтнох суурь хэрэгцээ нь байр, орон

сууц билээ. Иймд энэ төрлийн хэлцлийн үнэ, ач холбогдлыг харгалзан хэлцлийн талуудыг алдаа гаргахаас сэргийлж, хууль тогтоогч хэлбэрийн шаардлагуудыг хуулиар тогтоосон байдаг. Энэ нь хэлцлийн бүхий л үе шатанд хэлцлийн талууд өөрсдөө болон төрийн нэрийн өмнөөс хөндлөнгийн гэрчийн үүргийг гүйцэтгэх нотариатын оролцоотойгоор үүсэж болох бүхий л эрсдэлт алдаанаас сэргийлэх ач холбогдолтой юм.

Гэвч практикт энэ төрлийн хэлцлүүд хуульд заасан хэлбэрийн шаардлагыг хангахгүй байх нь их бөгөөд үүнээс хамаарч хэлцлийн талууд, ялангуяа энгийн иргэд хохирол амсах, эсвэл шударга ёсны зарчмын дагуу тодорхой тохиолдолд үйлчлэх хэлбэрийн шаардлагыг огоорч болох дүрмийн бус зохицуулалтыг хэрэглэхдээ шүүхээс хангалттай үндэслэл бүхий тайлбар хийхгүйгээр шийдвэрлэх нь ердийн нүдээр хуулийн илэрхий заалтыг зөрчиж буй мэт харагдаж, олон нийтийн хувьд хууль дээдлэх зарчим ганхаж, эрх зүйн нигилизм тогтож буй мэт хор уршиг ихтэй хийсвэр ойлголтыг төрүүлж байна. Үүний шалтгаан нөхцөлд дүн шинжилгээ хийж, уг тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх арга замын талаар гадаад орнуудын туршлагыг харьцуулан судалж, судлаачийн хувьд өөрийн санал, дүгнэлтийг танилцуулж байна.



II. Хэлбэрийн шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэх хэлцэл практикт их хэмжээгээр байгуулагдаж буй шалтгаан, хуулиар тогтоосон хэлбэрийн шаардлага

Үл хөдлөх эд хөрөнгө шилжүүлэх хэлцлийг Иргэний хуульд гэрээний тусгай төрөл болгож хуульчлаагүй. Харин зээлийн гэрээг эс тооцвол бусдын өмчлөлд шилжүүлэх аль ч хэлцлийн хувьд гэрээний зүйл нь үл хөдлөх хөрөнгө, түүний өмчлөх эрх байж болох бөгөөд эдгээр бүх хэлцэлд тавигдах нийтлэг хэлбэрийн шаардлагыг Иргэний хуулийн 109 дүгээр зүйлд тодорхой хуульчилсан байна.

Тус зохицуулалтын гарчгаас харвал үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжих процессыг чухалчилсан байх агаад процесс хэрхэн хэрэгжих дарааллыг тоочихдоо, өмчлөх эрхийн шилжүүлгийн үндэслэл болох хэлцэл нь заавал нотариатаар гэрчлэгдсэн байх шаардлагын талаар тусгажээ. (Иргэний хуулийн 109 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг)

Худалдах, худалдан авах гэрээний дагуу үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх шилжих тохиолдолд уг хэлбэрийн шаардлагыг хангаагүй хэлцлийг эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл бүртгэдэггүй. Харин ажил гүйцэтгэх гэрээ буюу практикт хэрэглэгдэж хэвшсэнээр “орон сууц захиалгаар барьж, байгуулах” гэрээний үндсэн дээр баригдаж дууссан барилгыг худалдаж авсан иргэд өмчлөх эрхийг барилгын төслийг хэрэгжүүлэгчээс шилжүүлэн авахдаа анх удаа улсын бүртгэлд бүртгэгдэж буй хөрөнгө гэх агуулгаар өмчлөх эрхээ бүртгүүлдэг бөгөөд ийнхүү бүртгүүлэхэд ашиглагддаг гэрээнд нотариатаар гэрчлүүлэх шаардлага тавигддаггүй.

Гэтэл шүүхээр шийдвэрлэгдэж буй ажил гүйцэтгэх гэрээ нэршилтэй гэрээнүүдийн дийлэнхийг шүүхээс Иргэний хуулийн 243 дугаар зүйлд заасан “худалдах, худалдан авах гэрээ” гэж дүгнэж байна. Шалтгаан нь бүрэн баригдаж дууссан, бүтэц, материал, зураг төсөлд ямар нэгэн өөрчлөлт оруулж, санал тусгах боломжгүй, бэлэн болсон хөрөнгөд үнэ төлж авч буйг ажил гүйцэтгэх гэрээ гэж үзэхгүй гэх үндэслэл юм.

Барилга барьсан, төслийг хэрэгжүүлсэн этгээдээс иргэдэд худалдан авсан орон сууцных нь өмчлөх эрхийг бүртгүүлж өгөхдөө худалдах, худалдан авах бус ажил гүйцэтгэх гэрээний төрлийг ашигласнаар үл хөдлөх хөрөнгө худалдан борлуулсан 2 хувийн албан татвар төлөх үндэслэлгүй болно. Нөгөөтээгүүр үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг анх удаа улсын бүртгэлд бүртгүүлэх процесст худалдан авагч өмчлөх эрхээ дангаар мэдүүлэг гаргах замаар бүртгүүлж олж авах боломжгүй тул барилгын төсөл хэрэгжүүлэгчээс шууд хараат байдал үүсэж байна.

Түүнчлэн үл хөдлөх эд хөрөнгө анх удаа улсын бүртгэлд бүртгүүлэхэд ашиглагдах гэрээг нотариатаар гэрчлүүлээгүйгээс үүсэх хариуцлагыг гэрээний талууд өөрсдөө хариуцах талаар “Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн тухай” хуулийн 7 дугаар зүйлийн 7.9 дэх хэсэгт хуульчилсан тул өөрсдийн буруугүйгээр хэлбэрийн шаардлага зөрчсөн гэрээ байгуулсан иргэдэд шударга бус байдал бий болж байгаа юм.

Учир нь ийм төрлийн маргааны дийлэнх тохиолдлыг барилгын компани хуваарийн дагуу хийх төлбөрийн зөрчилтэй худалдан авагчийг гэрээ цуцлах үндэслэл бүрдэхийг хүлээхийг



хүсээгүй эсхүл илүү дээр санал гаргасан талд анхны худалдан авагч буюу захиалагчид өмчлөх эрх үүсээгүй байдлыг далимдуулан гуравдагч этгээдэд өмчлөх эрхийг шилжүүлсэн тухай маргаан эзэлдэг. Ингэхдээ худалдан авагчтай анх байгуулсан гэрээг Иргэний хуулийн 343.1 дэх хэсэгт заасан “ажил гүйцэтгэх” бус тус хуулийн 243.1 дэх хэсэгт заасан “худалдах, худалдан авах” гэрээ байсан болохыг шүүхээр тогтоолгох замаар нотариатаар гэрчлүүлэх хэлбэрийн шаардлагыг зөрчсөн үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгож, наймаа буцаж, эдийн засгийн давуу байдал олж авахыг эрмэлзэх болсон нь шүүхээр шийдвэрлэгдэж буй энэ төрлийн маргаануудын агуулгаас тодорхой харагдаж байна.

III. Хэлбэрийн шаардлага хангаагүй үл хөдлөх эд хөрөнгийн хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг хадгалж буй дотоодын шүүхийн практик

Энэ төрлийн маргааныг шийдвэрлэсэн 3 шатны шүүхийн 200 гаруй шийдвэр, магадлал тогтоолд¹ дүн шинжилгээ хийж үзэхэд, анхан болон давж заалдах шатны шүүхүүд хэргийн үйл баримт, зохигч, гуравдагч этгээдийн тайлбарт дүгнэлт өгөлгүй орхигдуулж шийдэж буй байдал түгээмэл байлаа. Харин хяналтын шатны шүүхээс энэ төрлийн маргаан шийдвэрлэлтэд жишиг болохуйц үйл баримт, тайлбар, гомдлын үндэслэл бүрт дүгнэлт өгсөн 2022 оны 06 дугаар сарын 09-ний өдрийн 001/ХТ2022/00715 дугаартай тогтоолыг харьцуулсан эрх зүйн судалгааны зорилгоор энд танилцуулж байна.

¹ 2018-2022 оны 08 сар хүртэл.(Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга 2018.06.21-ний өдөр батлагдсан.)

Маргааны үйл баримтыг хураангуйлбал “Захиалгаар орон сууц барих, бариулах” буюу Иргэний хуулийн 343.1 дэх хэсэгт заасан гэрээг барилгын компани иргэнтэй байгуулж, уг орон сууцыг иргэнд мэдэгдэхгүйгээр гэрчилгээг өөрийн компанийн нэр дээр гаргуулсны дараа банканд барьцаалж, улмаар барьцаагаар хангагдах шаардлагад орон сууцны өмчлөх эрхийг тооцож, шилжүүлжээ.

Гурван шатны шүүхээр хэргийг шийдвэрлэхдээ баригдаж дууссан барилгаас орон сууц худалдан авсан байх тул гэрээний төрлийн хувьд Иргэний хуулийн 243.1 дэх хэсэгт заасан “худалдах, худалдан авах” гэрээ гэж дүгнэсэн. Ингэж дүгнэснээр барилгын компанийн зүгээс худалдах, худалдан авах гэрээ нь үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх хэлцэл учир түүнд Иргэний хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2 дахь хэсэгт заасан нотариатаар гэрчлүүлэх хэлбэрийн шаардлага тавигдах учиртай. Талууд энэ шаардлагыг тухайн үед хангаагүй бөгөөд одоо гэрээний нэг тал нь хэлцлийг цааш үргэлжлүүлэх хүсэлгүй байх тул Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1.8-д заасны дагуу хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгохыг хүссэн. Харин орон сууцны өмчлөлийг шилжүүлж авсан гуравдагч этгээд нь хуульд заасны дагуу өмчлөлийн зүйлийг шилжүүлж авсан тул өмчлөх эрх нь хөндөгдөх учиргүй гэсэн агуулга бүхий тайлбарыг хийжээ. Иргэний хувьд үнийг нь төлсөн орон сууцныхаа гэрчилгээг өөрийн нэр дэр гаргуулж авах хүсэлтэй байсан.

Хэргийг шийдвэрлэсэн үр дагаврын хувьд гурван шатны шүүх орон сууцны өмчлөгчөөр тогтоолгох нэхэмжлэгчийн шаардлагыг хангах тал дээр ижил байр суурьтай байсан ч шийдвэрийн



үндэслэлийг анхан болон давж заалдах шатны шүүх хангалттай тайлбарлаагүй байв. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх яагаад гуравдагч этгээдэд үүсээгүй болох, хэлбэрийн шаардлага хангаагүй хэлцлийг зохих шаардлага хангуулж дахин байгуулаагүй байхад яагаад нэхэмжлэгчид өмчлөх эрх хууль ёсоор үүсэх үндэслэлтэй талаар ямар нэгэн тайлбар шийдвэр, магадлалд дурдагдаагүй.

Хяналтын шатны шүүх байгуулагдсан гэрээний хувьд Иргэний хуулийн 243.1 дэх хэсэгт заасан "худалдах, худалдан авах гэрээ" гэж дүгнэсэн. Хэлцэл хэлбэрийн шаардлага зөрчсөн ч иргэнд өмчлөх эрх хэрхэн үүсэж буй тухайд Иргэний хуулийн 109 дүгээр зүйлийн 109.2-т "Үл хөдлөх эд хөрөнгийг шилжүүлэх хэлцэл, холбогдох бусад баримт бичигт өмчлөх эрх шилжүүлэх болсон үндэслэлийг тодорхой зааж нотариатаар гэрчлүүлэх бөгөөд хэрэв талуудын аль нэг нь төлөөлөгчөөр дамжуулан уг харилцаанд оролцож байвал төлөөлөгч болон түүний итгэмжлэлийг дээрх баримт бичигт тэмдэглэх буюу хавсаргана." гэж, 110 дугаар зүйлийн 110.1-д "Үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрх хэлцлийн үндсэн дээр нэг этгээдээс нөгөөд шилжиж байгаа бол уг хэлцлийг үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар бүртгүүлснээр өмчлөх эрх шинэ өмчлөгчид үүсэж, өмнөх өмчлөгчийн өмчлөх эрх дуусгавар болно." гэж тус тус заасан. Хэрэгт байгаа баримтаас үзвэл, гэрээг бичгээр байгуулж, талууд гарын үсгээ зурсан, "Ю Б Э П" ХХК гэрээний зүйлийг хүлээлгэн өгсөн, худалдан авагч Н.Л эд хөрөнгийн үнэ төлөх үүргээ биелүүлсэн байх ба "...2 орон сууцны өмчлөгчөөр тогтоолгох" нэхэмжлэлийн шаардлага нь өмчлөх эрхийг шилжүүлэх худалдагчийн үүргийг хангуулах буюу гэрээний хэлбэрийг хуульд

заасан дээрх шаардлагад нийцүүлснээр үүргийг хангуулах агуулгатай тул Иргэний хуулийн 110 дугаар зүйлийн 110.1-д заасныг зөрчөөгүй, 2014.11.03-ны өдрийн худалдах-худалдан авах гэрээг хүчин төгөлдөр бус гэж үзэх үндэслэлгүй байна хэмээн дүгнэжээ.

Эндээс сонирхол татаж буй нэг асуудал нь хэлбэрийн шаардлага зөрчөөгүй гэж дүгнэж байх боловч "... гэрээний хэлбэрийг хуульд заасан дээрх шаардлагад нийцүүлж.." дахин байгуулахыг шүүхээс гэрээний нэг талыг албадах боломжтой гэх агуулгаар дүгнэсэн байна. Иргэний хуульд хүчин төгөлдөр бус хэлцлийн хүчинтэй байдлыг хадгалах шууд заасан 2 арга байдаг. Эхнийх нь Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан "Энэ хуулийн 56.1-д заасан хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцох нөхцөлийг талууд хэлцэл хийснээс хойш мэдсэн бөгөөд уг хэлцэл нь өөр хэлцлийн шаардлагад нийцэж байгаа тохиолдолд талууд хүсвэл шаардлагад нийцэж байгаа хэлцлийг хүчин төгөлдөр гэж үзнэ". Удаах нь мөн хуулийн 56.3 дахь хэсэгт заасан "Энэ хуулийн 56.1.2-56.1.4, 56.1.8-д заасан хэлцлийг хийсэн этгээд уг хэлцлээр илэрхийлсэн хүсэл зоригоо хүчин төгөлдөр болохыг хожим хүлээн зөвшөөрч, хуульд заасан хэлбэрээр илэрхийлсэн бол шинээр хийсэнтэй адилтгаж хүчин төгөлдөр хэлцэл гэж үзнэ". Эдгээрээс үзвэл гэрээнд оролцогчид хэлбэрийн шаардлага хангаагүй хэлцлийг өөр хэлцэл гэж хүлээн зөвшөөрөх эсхүл тодорхой хэлцлийг хуульд заасан хэлбэрээр дахин хийхийг сайн дураар хүлээн зөвшөөрсөн байхыг тодорхой заасан байна. Гэтэл шүүхээс ийнхүү нэхэмжлэлийн шаардлагын хүрээнд нэгдүгээрт хэлбэрийн шаардлага хангуулах агуулга байгаа гэж үзэх, нөгөөтээгүүр сайн дурын үндсэн дээр



хэлбэрийн шаардлагыг хангуулах хуулиар заасан аргыг нөгөө талд албадан биелүүлэхийг даалгах боломжтой гэж үзсэн.

Энэ тохиолдолд барьцаагаар хангагдах үүргийн гүйцэтгэлийг хангуулах хэлцлийн дагуу өмчлөх эрхийг шилжүүлэн авсан гуравдагч этгээд болох банканд шударгаар өмчлөх эрх үүссэн байх үед л уг эрх нь хамгаалагдах боломжтой болно. Үүнийг хяналтын шатны шүүхээс *"Иргэний хуулийн 183 дугаар зүйлийн 183.1-д "Эрх шилжүүлж байгаа этгээдийн нэр дээр улсын бүртгэлд бүртгүүлсэн эрхийг хэлцлийн үндсэн дээр олж авч байгаа этгээд улсын бүртгэлд бичигдсэн тэмдэглэлийг буруу ташаа болохыг мэдэж байсан, эсхүл уг бүртгэлийг буруу ташаа гэж эсэргүүцсэнээс бусад тохиолдолд үнэн зөв гэж тооцно."* гэж заасан. Барьцааны гэрээ улсын бүртгэлийг үндэслэсэн, хуульд заасан хэлбэрээр байгуулагдсан боловч *"Ю Б Э н" ХХК-ийн 50 хувийн хувьцааг Т, Ө, Н.Т нар эзэмшдэг, үлдэх хувийг ХХБ-ны хамаарал бүхий этгээд эзэмшдэг гэх гэрч Н.Т-гийн мэдүүлгийг гуравдагч этгээд "ХХБ" ХХК няцаагаагүйгээс гадна нэхэмжлэгч нь эд хөрөнгийг бодитой эзэмшиж байсан тул ХХБ-ны зүгээс бүртгэл үнэн зөв эсэхийг мэдэх боломжтой байсан гэж үзнэ. Энэ тохиолдолд ХХБ-ийг шударга барьцаалагч, өмчлөх эрхийг шударгаар олж авсан гэж үзэхгүй"* хэмээн дүгнэжээ.

IV. Хэлбэрийн шаардлага зөрчсөн хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг хадгалах онолын үндэс, гадаад орнуудын шүүхийн практик

Хэлбэрийн шаардлага зөрчсөн хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг харьцуулан судлахдаа дэлхийн эрх зүйн бүлүүдээс тэргүүлэх шинжтэйгээр хөгжсөн

эрх газрын эрх зүйн² болон нийтлэг эрх зүйн³ бүлийн орнуудыг сонгон авсан.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 311b заалт, 925 дугаар зүйлүүдээс харвал газар худалдах, худалдан авах гэрээ болон өмчлөх эрхийг тусад нь шилжүүлэх хэлцлийн аль алиныг нь нотариатаар гэрчлүүлэхээр заасан байна. Мөн НХУ⁴-ын Иргэний хуулийн 3:89 дүгээр зүйлд үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх үндэслэл болж буй хэлцлийг заавал нотариатаар гэрчлүүлэхээр заажээ. Харин БНФУ-ын⁵ Иргэний хуулийн 1583 СС заалтад аливаа эд хөрөнгийг шилжүүлэх хэлцэл хийгдсэн мөчид уг эд хөрөнгийн өмчлөл шилжихээр заасан. Өөрөөр хэлбэл нотариатаар гэрчлүүлэх, газрын бүртгэлд бүртгүүлэх зэрэг нь гэрээ хүчин төгөлдөр болох хийгээд өмчийг шилжүүлж буй хэлцэлд ямар ч нөлөөгүй. Нотариатаар гэрчлүүлэх болон эд хөрөнгийн улсын бүртгэлд бүртгүүлэх зэрэг нь зөвхөн тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийг гуравдагч этгээдийн хувьд тодорхой болгох л ач холбогдолтой байдаг байна⁶.

Гэвч худалдан авагчийн хувьд бүртгэлийн ач холбогдол илүү чухал юм. Учир нь хэрэв бүртгэл хийгдэхгүй бол худалдан авагч буюу гэрээгээр өмчлөх эрх олж авсан этгээд нь шударгаар өмчлөх эрхийг олж авсан гуравдагч этгээдийн эсрэг эрхээ хэрэгжүүлэх боломжгүй болдог. Иймд гэрээ хийгдмэгц түүнийг нотариатаар гэрчлүүлж, улсын бүртгэлд бүртгүүлэх нь өөрийн эрхийг баталгаатай хамгаалах арга болдог байна⁷.

² Civil law

³ Common law

⁴ Нидерландын Хаант Улс

⁵ Бүгд Найрамдах Франц Улс

⁶ Jan. M. Smits. Contract law: A Comparative Introduction, (2014), p. 104-105.

⁷ Мөн тэнд.

ХБНГУ-ын Иргэний хуулийн 125 дугаар зүйлд хуулиар тогтоосон хэлбэрийн шаардлагыг хангаагүй хэлцэл хүчин төгөлдөр бус байх бөгөөд хэлцэл хэлбэрийн шаардлага хангаж буй эсэх нь эргэлзээтэй тохиолдолд ижил үр дагавартай байхаар хуульчилжээ. НХУ-ын Иргэний хуулийн 3:39 дэх заалтад “хуульд өөрөөр заагаагүй бол хэлбэрийн шаардлага хангаагүй хэлцэл нь хүчин төгөлдөр бус байна” хэмээн заажээ.

Хэлбэрийн шаардлага хангаагүй хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг хадгалах онолын шинжтэй 3 тохиолдол байдгаас эхний 2 нь эх газрын эрх зүйн бүлийн ихэнх орнуудад үйлчилдэг бол гурав дахь нь эрх зүйн бүл харгалзахгүй нийтлэг шинжтэй байхаас гадна үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх хэлцэлд түлхүү хэрэглэгддэгээрээ онцлог байна.

Эхнийх нь хэлбэрийн шаардлага хангаагүй гэрээг хүчинтэйд тооцох аргыг хуульд өөрт нь заасан бөгөөд гагцхүү тухайн гэрээнд оролцогч этгээдийг хамгаалах зорилготой байвал энэ зохицуулалтыг хэрэглэх агуулгатай юм⁸. Жишээ нь ХБНГУ-ын Иргэний хуулийн 550 дугаар зүйлд орон сууцны санхүүгийн түрээсийн гэрээний хугацаа 1 жилээс дээш байх тохиролцоог бичгээр илэрхийлээгүй бол үүнийг хугацаагүй гэрээнд тооцож, хүчин төгөлдөр байдлыг нь хадгалдаг байна. Уг зохицуулалтын зорилго нь энэ төрлийн харилцаанд хүчний тэнцвэрийг түрээслэгчид хамгаалалт олгох замаар тэнцвэржүүлэх явдал бөгөөд энэ нь түрээслэгчийн эрх ашигт нийцдэг.

Удаах нь хэлцлийн нэг тал эсхүл талуудын аль аль нь хэлбэрийн шаардлагыг огоорсон боловч бодит

үйлдлээрээ үүргээ гүйцэтгэчихсэн бол хэлцлийг хүчинтэйд тооцдог байна⁹. Тухайлбал ХБНГУ-ын Иргэний хуулийн 766 дугаар зүйл, НХУ-ын Иргэний хуулийн 7:859 дэх заалтад хувийн баталгааны гэрээ амаар байгуулагдсан ч баталгаа гаргагч тохирсон үүргээ зохих ёсоор гүйцэтгэсэн бол гэрээг хүчинтэйд тооцохоор заасан байна.

Сүүлчийн тохиолдол нь хэрэв нэг талын өгсөн амлалт, үүсгэсэн нөхцөл байдалд найдаж нөгөө тал нь хэлцэл хийсэн байвал ийм нөхцөлд оруулсан талыг хэлбэрийн шаардлага зөрчсөн гэх үндэслэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бусад тооцуулахыг зөвшөөрөхгүй байх тухай юм. ХБНГУ болон НХУ-д энэ ойлголт нь харилцан итгэлцэл, шударга ёсны зарчимд¹⁰ суурилан хөгжсөн бол нийтлэг эрх зүйн бүлийн гол төлөөлөгч болох Англид амлалтаа үл зөрчих¹¹, БНФУ-д эрхээ урвуулах¹² зэрэг зарчмуудаар илэрхийлэгддэг байна. Эдгээр зарчмуудыг хэлбэрийн шаардлагад хамааруулан хэрэглэх дийлэнх тохиолдлыг хэлбэрийн шаардлага зөрчсөн үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэх хэлцэл эзэлдэг.

Эх газрын болон нийтлэг эрх зүйн бүлд хамаарах орнуудын энэ төрлийн маргаан шийдвэрлэлтэд жишиг болсон дараах 2 шийдвэр байдаг.

Эхнийх нь 1967 онд Германы Холбооны Улсын Дээд шүүхээр шийдэгдэж байсан. (Kaufmanns-ehrenwort).

Маргааны товч: Газар худалдах худалдан авах гэрээг талууд бичгээр байгуулсан ч нотариатаар гэрчлүүлсэнгүй. Худалдан авагч нь худалдагчийг эчнээ таньдаг буюу түүний удирдлагад ажилладаг нэгэн бөгөөд тэрээр үл

⁸ Jan. M. Smits. Contract law: A Comparative Introduction, (2014), p. 106-107.

⁹ Мөн тэнд.

¹⁰ Principle of good faith

¹¹ Doctrine of proprietary estoppel

¹² Abus de droit



хөдлөх хөрөнгө худалдах, худалдан авах гэрээнд нотариатаар гэрчлүүлэх хэлбэрийн шаардлага тавигддаг болохыг мэддэг байв. Ингээд худалдагчид хандан гэрээгээ нотариатаар гэрчлүүлэх санал тавихад худалдагч тэгэх шаардлагагүй. Би амлалтаа заавал биелүүлнэ гэсэн хариу өгсөн. Хожим нь худалдагч уг гэрээг хэлбэрийн шаардлага зөрчсөн гэх үндэслэлээр хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага шүүхэд гаргажээ.

Шүүхийн шийдэл: Шүүхээс худалдагчийн амлалтад итгэж, гэрээний харилцаанд оролцсон худалдан авагчийн итгэлийг түүний эсрэг ашиглаж болохгүй гэх харилцан итгэлцэл шударга ёсны зарчмыг баримтлан нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгон шийдсэн байна.

Удаах нь 1979 онд Английн давж заалдах шүүхээр шийдэгдсэн. (*Pascoe v Turner*), (1979).

Маргааны товч: Ноён Паскөү нь Корнволлд үл хөдлөх хөрөнгө өмчилдөг бөгөөд хатагтай Төрнер тэднийд гэрийн үйлчлэгчээр ажилд орсон. Хэсэг хугацааны дараа тэд хувийн харилцаатай болж, Паскөү Төрнерт хандан энэ байшин бол чинийх гэж хэд хэдэн удаа хэлж байсан. Үүнд нь итгэсэн Төрнер өөрийн бүхий л хадгаламжаараа байшинг засварласан. Үүний дараа Паскөү түүнийг гэрээсээ хөөж, хариуд нь Төрнер шүүхэд хандсан.

Шүүхийн шийдэл: Английн эрх зүйд ийм төрлийн амлалтыг нотариатаар гэрчлүүлж байж үүрэг үүсдэг боловч тухайн үед шүүх ноён Паскөүгийн гаргасан баталгаанд итгэж, бүх хадгаламжаа байшинг засварлахад зарцуулж буй хатагтай Төрнерийг тухайн үед дэргэд нь байж энэ талаар мэдэж байсан ч Паскөүгийн зогсоогоогүй эс үйлдэл нь байшинг өөрийн мэт өмчлөх хүсэлгүй

болсныг нь хангалттай нотолж байна гэж үзэж хатагтай Төрнерийг өмчлөгчөөр тогтоожээ. Өөрөөр хэлбэл өөрийн үүсгэсэн нөхцөл байдалд итгэсэн талын итгэлийг тухайн талын эсрэг ашиглаж болохгүй гэх өмчийн эрх зүйн амлалтаа үл зөрчих зарчимд суурилж уг хэргийг шийдсэн юм¹³. (*Doctrine of proprietary estoppel*)

V. Санал, дүгнэлт

Хэлцэлд хуулиар тавигддаг хэлбэрийн шаардлагууд дотроос үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх хэлцэлд хамгийн олон, мөн хатуу шаардлага тавигддаг. Үүний шалтгаан нь тухайн хэлцлийн үнэ цэн, ач холбогдлоос улбаатай.

Хууль тогтоомжийн буюу эрх зүйн орчны хувьд эх газрын эрх зүйн бүлийн орнуудад манай улсын нэгэн адил үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэх хэлцэлд бичгээр байгуулж, нотариатаар гэрчлүүлэх үндсэн шаардлага тавигдаж байна. Харин энэ тохиолдолд хамаарахгүй эх газрын эрх зүйн бүлийн томоохон төлөөлөл нь БНФУ бөгөөд энэ улсад иргэний эрх зүйн "хийсвэрлэх зарчмыг"¹⁴ хэрэглэдэггүй билээ.

Үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг шилжүүлэх хэлцэл хэлбэрийн шаардлага хангахгүй байх тохиолдолд эх газрын эрх зүйн бүлийн томоохон төлөөлөл болсон орнуудын хууль тогтоомж манай улстай ижил үр дагавар бүхий зохицуулалтыг агуулж байна. Хэлбэрийн шаардлага зөрчсөн хэлцлийн хүчин төгөлдөр байдлыг хадгалах тохиолдлууд хууль тогтоомжийн гэхээс илүүтэй онолын хэрэглээтэй холбоотой болох нь харьцуулсан судалгааны үр

¹³ Ewan McKendrick, *Contract Law: Text, Cases, and Materials*, 5th edition, (2012), p. 224.

¹⁴ Үр дагаврын хувьд үүргийн хэлцэл, өмчийн хэлцэл тусдаа байх



дүнгээс харагдаж байна. Гэхдээ Иргэний хуулийн 43.3¹⁵, 330.2¹⁶, 202.1¹⁷ зэргүүдээс харвал манай хуульд онолын шинжтэй дээр дурдсан үзэл санаанууд тодорхой хэмжээгээр тусгагджээ. Тухайлбал, үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх шилжүүлэх хэлцлийн хувьд тухайлан өндөр давтамжтай хэрэглэгддэг харилцан итгэлцэл, шударга ёсны зарчим нь эх газрын эрх зүйн бүлийн бусад орнуудын адил манай Иргэний хуульд мөн хуульчлагдсан юм.

Дотоодын шүүхийн практикийг судалж үзэхэд анхан болон давж заалдах шатны шүүхүүд энэ төрлийн маргааныг шийдвэрлэхдээ зохигч, гуравдагч этгээдийн тайлбар, гомдол, тэдгээрийн үндэслэлд хангалттай тодорхой тайлбар бичихгүй байх нь түгээмэл бөгөөд хяналтын шатны шүүхээс шийдвэрлэсэн байдлын хувьд үндэслэлээ хангалттай тодорхой дурдаж байх боловч энэ төрлийн маргаан шийдвэрлэлтэд ижил үр дагаврыг гаргахад нийтлэг ашиглагдаж буй эрх зүйн ижил бүлд хамаарах бусад орнуудын хэрэглэдэг онол, зарчмуудыг төдийлөн хэрэглэхгүй байгаа дүр зураг ажиглагдлаа. Мөн хэлбэрийн шаардлагыг хангуулахаар шүүхээс даалгах асуудал нь гэрээний эрх чөлөөний зарчмыг хөндөх эрсдэлтэй юм.

Судлаачийн зүгээс санал болгож буй шийдэл нь энэ төрлийн маргаан шийдвэрлэлтэд ижил эрх зүйн бүлийн тэргүүлэх орнуудын шүүхийн практикт идэвхтэй ашиглаж буй харилцан итгэлцэл, шударга ёсны зарчмыг ашиглах явдал юм. Учир нь нэг талаас эрх зүйн орчны ойлгомжгүй байдал, нөгөөтээгүүр өмчлөх эрхээ олж авахад хууль тогтоомжийн зохицуулалтаас үүдэлтэй барилгын

компаниас хараат байгаагаас мэдэх боломжгүйгээр хэлбэрийн шаардлага зөрчсөн хэлцэл байгуулж буй иргэдэд хамгийн бага хэмжээний гэм бурууг ч оноох боломжгүй юм. Энэхүү өгүүлэлд дурдаж буй тохиолдлууд нь зөвхөн нөгөө талын үүсгэсэн итгэлд үндэслэлд зогсохгүй энэ төрлийн харилцааг зохицуулж буй эрх зүйн орчинд найдаж байх тул шүүхээс уг зарчмыг хэрэглэн тухайн төрлийн маргааныг шийдвэрлэх бүрэн боломжтой гэж үзэж байна.

НОМ ЗҮЙ

I. Эрх зүйн эх сурвалж

Монгол Улсын Үндсэн хууль 1992

Иргэний хууль 2002

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хууль 2018

ХБНГУ-ын Иргэний хууль 2002
(шинэчилсэн найруулга)

НХУ-ын Иргэний хууль 1992
(шинэчилсэн найруулга)

БНФУ-ын Иргэний хууль 1964
(шинэчилсэн найруулга)

II. Гадаад эх сурвалж

Jan. M. Smits. Contract law: A Comparative Introduction, 2014.

Ewan McKendrick, Contract Law: Text, Cases, and Materials, 5th edition, 2012.

III. УДШ-ийн тогтоол

2022.06.09 – Дугаар 001/
ХТ2022/00715

¹⁵ Бодит үйлдлээр хүсэл зоригоо илэрхийлэх

¹⁶ Тодорхой бус хугацаагаар байгуулсанд тооцох

¹⁷ Харилцан итгэлцэл, шударга ёсны зарчимд харш хэлцэл байгуулахыг хориглох



Abstract

ISSUE OF THEORETICAL AND PRACTICAL ON CURING LACK OF FORMALITIES RELATED TO CONVEYANCING CONTRACT: COMPARATIVE STUDY

B.BATBAYAR

*Researcher, Judicial Training, Research,
and Information Institute under Supreme Court of Mongolia*

This article examines the in-practice causes of the formation of conveyancing contracts which are violated formalities from a view of legislation in practice and finds a way of curing the lack of formalities related to conveyancing contracts based on comparative theory and judicial practice.

Keywords

Voidness, judicial practice, good faith (reasonableness and fairness), proprietary estoppel, abuse of right.



RESTORATIVE JUSTICE CONCEPT БУЮУ ШУДАРГА ЁСЫГ НӨХӨН СЭРГЭЭХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

RESTORATIVE JUSTICE CONCEPT AND TENDENCY IN DEVELOPMENT OF CRIMINAL JUSTICE

Зоригтбаатар ЯНЖИНЛХАМ¹

- I. Удиртгал
- II. Үндсэн хэсэг
 - II.1 “Restorative Justice Concept” буюу Шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлалын онолын үндэслэл
 - II.2 Харьцуулсан судалгаа
 - II.3 Шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлалыг Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжид нэвтрүүлэх шаардлага, арга зам
- III. Дүгнэлт
- IV. Санал
- V. Эх сурвалж

¹ УДШ-ийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач, МУИС ХЗС-ийн магистрант



RESTORATIVE JUSTICE CONCEPT БУЮУ ШУДАРГА ЁСЫГ НӨХӨН СЭРГЭЭХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ БА ЭРҮҮГИЙН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН ЧИГ ХАНДЛАГА

З.ЯНЖИНЛХАМ УДШ-ийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн хүрээлэнгийн судлаач, МУИС ХЗС-ийн магистрант

Түлхүүр үгс

Нөхөн сэргээх шударга ёс, уламжлалт ял шийтгэлд суурилсан эрүүгийн эрх зүйн тогтолцоо, эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын эрх зүй, эрүүгийн эрх зүй дэх хүнлэг ёсны зарчим

Хураангуй

Энэхүү судалгааны хүрээнд эрүүгийн эрх зүйн хүнлэг ёсны зарчмын хүрээнд хөгжиж буй “Restorative Justice Concept” буюу шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлалыг товч байдлаар таниулах, дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтрэх боломжийг эрэлхийллээ.

I Удиртгал:

Ял шийтгэлд суурилсан аргаар шударга ёсыг сэргээн тогтоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх уламжлалт хандлага нь эдүгээ хоцрогдож, гэмт этгээд дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх болон хохирогчийн эрхийг хамгаалах чиглэлээр эрүүгийн эрх зүйн тогтолцоонд харьцангуй чөлөөтэй, уян хатан арга хэмжээг нэвтрүүлэх хүнлэг ёсны чиг хандлага дэлхийн улс орнуудын эрүүгийн эрх зүйн хөгжилд нэвтэрч эхэлжээ. Дэлхийн хөгжингүй улс орнууд, НҮБ болон Европын холбооны зүгээс эрүүгийн хэрэгт хохирогч, гэмт хэрэгтнийг эвлэрүүлэн зуучлах хөтөлбөр нь гэмт хэргийн улмаас зөрчигдсэн

эрхийг нөхөн сэргээх, хохирол, хор уршгийг бүрэн барагдуулах, хохирогчийг дахин хохирохоос хамгаалах, гэмт хэрэгтнийг дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх үр дүнтэй арга хэрэгсэл болох тал дээр санал нэгдээд буй.

Манай улсын хувьд 1926 оноос хойш шударга ёсыг нөхөн сэргээх¹ үзэл санааг агуулсан элементүүд Эрүүгийн хууль тогтоомжид тусгагдаж ирсэн боловч бүрэн утгаар нь тайлбарлаж хэрэгжүүлж чадаагүй, уг зохицуулалтын боловсронгуй бус байдал 2015 онд Эрүүгийн хууль тогтоомжид орсон шинэчлэлийн хүрээнд ч хэвээр үлджээ. Энэ явдал нь Эрүүгийн хуулийн шударга ёсыг сэргээн тогтоох, ял шийтгэлээр дамжуулж цээрлүүлэхээс илүү нийгэмшүүлэх суурь үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд саад учруулж буй юм. Гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг бүрэн барагдуулах, гэмт хэрэгт хохирсны улмаас хохирогчид үүсдэг онцгой хэрэгцээг ойлгох, хангах, гэмт хэргээс урьдчилсан сэргийлэх ажиллагаанд Эрүүгийн эрх зүйн шударга ёс, энэрэнгүй ёсны зарчмыг

¹ Нэр томъёоны орчуулгын тухайд манай улсын хууль зүйн сурах бичиг, судалгааны бүтээлүүдэд уг нэр томъёоны төдийлөн нийтлэг биш буюу хууль ухааны доктор Ч.Нямсүрэн “Гэмт хэргийн виктимнологи” номондоо “сэргээн тогтоох-шүүн таслах ажиллагаа” гэж орчуулснаас өөрөөр хэрэглэгдсэн тохиолдол алга байна. Судлаач оюутан миний бие уг нэр томъёог англи хэлнээс шууд орчуулж хэрэглэсэн болно.



баримтлах үүднээс шударга ёсыг нөхөн сэргээх тухай ойлголтыг онолын үндэслэлтэйгээр судлах, энэ чиглэлээр судалгаа шинжилгээг эрчимжүүлэх, бусад улс орнуудын туршлагыг судалж, өөрийн орны онцлогт тохирсон эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь манай улсын Эрүүгийн эрх зүйн хөгжлийг дараагийн үе шатанд хөтлөх алхам болох юм.

Энэхүү сэдвийг хөндөж гүнзгийрүүлэн судалсан эрдэм шинжилгээний бүтээл одоогоор манай улсад ховор буюу доктор Ч.Нямсүрэнгийн “Гэмт хэргийн виктимологи”/2005/ номд “сэргээн тогтоох шүүн таслах ажиллагаа” нэршлээр бичигдсэнээс өөр судалгааны бүтээл хараахан гараагүй байна. Судлаач миний бие уг өгүүлэлэр дамжуулан нөхөн сэргээх шударга ёсны талаарх ерөнхий ойлголтыг бусад судлаач, хуульчдад хүргэх, дотоодын эрх зүйн тогтолцоонд нэвтэрсэн байдлыг гадаадын зарим улсуудын эрх зүйн зохицуулалттай жиших замаар товч тодруулахыг оролдлоо.

II Үндсэн хэсэг:

II.1 “Restorative Justice Concept” буюу Шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлалын онолын үндэслэл

Орчин үеийн эрүүгийн эрх зүйн хөгжлийн голлох чиг хандлага болоод буй “humanization of criminal law” буюу эрүүгийн эрх зүйн хүнлэг ёсны хандлагын үүднээс² ял шийтгэлийн зорилго нь гэмт этгээдийг залхаан цээрлүүлэх бус гэмт зан төлөвийг нь засаж дахин нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэхээс илүү ухааруулах зорилгод чиглэж байна. Энэхүү зорилгын үүднээс эрүүгийн хуульд ялаас чөлөөлөх, оногдуулах ялыг хөнгөрүүлэх нөхцөлийн хүрээг өргөжүүлэх, хохирогчид учруулсан

хохирлыг нөхөн төлсөн, нийгмийн хор уршгийг арилгасан, өөрийн гэм бурууг хүлээн зөвшөөрч, үүрэг хариуцлагаа ухамсарлаж буй хүнд холбогдох хэргийг хэрэгсэхгүй болгох, ялын бус арга хэмжээний төрлийг нэмэгдүүлэх, хохирол нөхөн төлөх арга хэлбэрийг уян хатан тогтоож өгөх зэргээр дэлхийн улс орнууд эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоондоо шинэчлэлийг нэвтрүүлж байна.

Энэ төрлийн шинэлэг туршлага, үзэл баримтлалуудын нэг нь “Restorative Justice Concept” буюу Шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлал юм. Энэхүү үзэл баримтлалыг анх 1970-аад оны дунд үеэс европт өсвөр насны хүүхэд холбогдсон гэмт хэрэгт холбогдогчийн нийгэмд харш зан төлөвийг засах, хүмүүжүүлэх, ирээдүйн боловсрол, ёс зүйтэй иргэн болгож бэлтгэх, хохирогчийн эрх ашгийг хамгаалах, хохирлыг уян хатан нөхцөлтэйгөөр бүрэн нөхөн төлүүлэх зорилгоор нэвтрүүлжээ. Тухайлбал, 1974 онд Канад улсад нийт 22 иргэний эд хөрөнгийг устгаж гэмтээсэн хэрэгт холбогдсон өсвөр насны 2 хүүхдэд холбогдох хэргийг хяналтын цагдаа буюу пробацын цагдаагийн санаачилгаар өсвөр насны гэмт этгээдүүдийн гэр бүлийн гишүүд, хүүхэд хамгааллын сайн дурын байгууллагуудын оролцоотойгоор гэр бүлийн гишүүдийн зөвлөгөөний хөтөлбөр /family group conferencing/-ийг боловсруулж хэрэгжүүлснээр Канад улсын шүүхийн жишигт анх хүлээн зөвшөөрөгджээ.³

Энэхүү үзэл баримтлалыг боловсруулахад нөлөөлсөн суурь шалтгаан нь ял шийтгэлд суурилсан уламжлалт эрүүгийн эрх зүйн тогтолцоо

² Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын шинэтгэлийн асуудлууд, Д.Баярсайхан, УБ хот, 2019 он, хуудас 8

³ Restoring Justice. An Introduction to Restorative Justice, Daniel W. Van Ness and Karen Heetderks Strong, 2015, USA, page 35



буюу “Retributive Justice”-н султалууд болох гэмт хэргийг мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагааны явцад төр бүх эрх мэдлийг гартаа төвлөрүүлж зарим талаараа хохирогчтой дүйцэхүйц байр сууринд очдог, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хохирогчийн эрх ашгийг хамгаалах хамгаалалт хангалтгүй, оролцоо хязгаарлагдмал “Гэмтнийг нотлох хэрэглүүр” төдий болж эрүүгийн процесс ажиллагааны улмаас дахин хохирох нөхцөлийг бүрдүүлэхээс гадна ял шийтгэлийн арга нь гэмт этгээдийн дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд хангалттай үр нөлөө үзүүлж чаддаггүй зэрэг нөхцөл байдлуудын шүүмжлэлээс бий болжээ.

Шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлалын үүднээс гэмт хэргийн талаарх ойлголтыг нийтийн аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөө зэрэг нийтлэг үнэт зүйлсийн эсрэг хууль зөрчсөн үйлдэл (эс үйлдэхүй) гэсэн уламжлалт байдлаар тодорхойлохын оронд **гэмт хэрэг гэдэг нь юун түрүүнд хувь хүний эсрэг үйлдэгддэг буюу нэг хүнээс нөгөөгийн эсрэг үйлдэгдсэн хүчирхийлэл бөгөөд нийгмийн харилцаанд тулгарсан бэрхшээл** болох талаас нь тодотгож үздэг.⁴

Хүснэгт №1. Restirbutive Justice ба Restorative Justice-н ялгаатай шинжүүд

Retributive Justice	Restorative Justice
Гэмт хэрэг бол нийтийн ашиг сонирхлын эсрэг үйлдэл	“Гэмт хэрэг нь нэг хүний эсрэг нөгөө хүнээс үйлдсэн хүчирхийлэл бөгөөд хүмүүс хоорондын харилцаанд үүссэн бэрхшээл”
Гэм бурууг нотлоход чиглэдэг	Гэмт хэргийн эсрэг хэрэгжүүлэх хариу арга хэмжээ нь гэмт хэргийн үр дагаврыг залруулах, ирээдүйд чиглэсэн арга хэмжээ авах мөн
Гэм буруугийн хэлбэрт тохирсон ялыг оногдуулах ёстой	Нэн тэргүүнд хохирогчид учирсан хохирол, хор уршгийг нөхөн төлөх, хохирогчийн хэрэгцээг хангах, гэм буруутай этгээдийн үүрэг хариуцлагыг тодорхойлох ёстой
Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хууль хэрэгжүүлэгч субъектүүд гол үүрэг гүйцэтгэдэг	Гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршиг, хэрэгцээ, үүрэг хариуцлагыг гэмт хэргийн нөлөөнд өртсөн этгээдүүдийн идэвхтэй оролцоогоор дамжуулан тодорхойлдог

Шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлалын үүднээс гэмт хэргийн үр дагавар эсрэг авах хариу арга хэмжээнүүд буюу хохирогчийн эрхийг сэргээх, хариуцлага хүлээлгэх ажиллагаа нь тодорхой элементүүдийг агуулсан бол тухайн ажиллагаа/хөтөлбөр нь шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлалд нийцнэ гэж үздэг. Тус онолын гол төлөөлөгчдийн нэг Ховард Цээр (Howard Zehr)-ийн үзсэнээр гэмт

хэргийн хохирогчид хохирол, түүнийг дагаад тодорхой хэрэгцээ бий болдог. Энэхүү хохирол, хэрэгцээг залруулах, хангах үүргийг хэн нэгэн /тодруулбал гэмт этгээд/ хүлээнэ. Хэрхэн яаж гэдгийг шийдвэрлэхийн тулд талууд хэлэлцэх шаардлагатай. Эдгээр нь шударга ёсыг нөхөн сэргээх үзэл санааны үндсэн 3

⁴ мөн тэнд



ойлголтыг бий болгодог. Үүнд⁵:

Гэмт хэрэгт хохирсны улмаас үүссэн хэрэгцээ: Гэмт хэргийн хохирогчид юун түүрүүнд дахин гэмт хэрэгт хохирохоос сэргийлэх аюулгүй байдлаа хангуулах хэрэгцээ үүсдэг. **Хоёрдугаарт** материаллаг хэрэгцээ буюу хохирол, хор уршгийг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэх, **гуравдугаарт** болж өнгөрсөн үйл явдлын улмаас хохирогчийн сэтгэл зүйд үүссэн, хэвийн амьдрахад саад болж буй сөрөг сэтгэл хөдлөлүүдийг давж гарах, гэмт хэргийн дараа үүссэн сэтгэл зүйн гэмтэл /trauma/-ийг даван туулах сэтгэл зүйн хэрэгцээ зайлшгүй үүсдэг. **Дөрөвдүгээрт** хохирогч өөрт хамааралтай хэргийн талаар эрүүгийн процессын мэдэх эрхээс өргөн хүрээний мэдээллийг олж авахыг жишээлбэл, гэмт этгээдээс яагаад тийм зүй бус үйлдлийг өөрийнх нь эсрэг хийсэн, яагаад заавал өөрийг нь хохирогчоор сонгосон шалтгаан, тухайн үйл явдал дахин давтагдах эсэх гэх мэт асуултад хариулт авах, ойлгохыг /ойлголцохыг/ хүсэж болно. Зарим тохиолдолд гэмт хэрэгтний өссөн орчин, гэмт хэрэг үйлдсэн шалтгаан гэх мэт нарийн мэдээллүүдийг олж мэдэхийг ч хүсэж болно.⁶ Эдгээр төрлийн мэдээллүүд нь гэмт хэргийн хохирогчийн эмзэг байдлыг хамгаалах, айдас түгшүүрийг бууруулах, гэмт хэрэгтэнтэй харилцан ойлголцох боломжийг нэмэгдүүлэх, эргээд нийгмийн нэгдмэл байдлыг хангахад тус болох боломжтой.

Үүрэг: Гэмт хэргийн улмаас үүсэх үүргийг гэмт этгээдийн болон нийгмийн гэсэн хоёр хэсэг хувааж авч үздэг. Гэмт этгээд өөрийн гэмт үйлдлийн үр дагаврыг ухаарах, гэм буруугаа ухамсарлах, уучлалт хүсэх /эс

суртахууны хариуцлага/, хохирол, хор уршгийг нөхөн төлөхийг бүхэлд нь гэмт этгээдийн үүрэг, хариуцлагын хүрээнд хамруулж үздэг. Нөгөө талаас гэмт хэрэг үйлдэх болсон шалтгаан буюу гэмт этгээд ч мөн нийгмийн шударга бус байдлын хохирогч болсон байхыг үгүйсгэхгүй тул нийгэм /нийгмийн гишүүдийн төлөөлөл/ гэмт этгээдийг нийгмийн амьдралд эргэн нэгдэхэд туслалцаа, дэмжлэг үзүүлэх нь нийгмийн үүргийн хүрээнд багтана. Иймээс шударга ёсыг нөхөн сэргээх хөтөлбөрийн үед нийгэмд харш зан төлөв бүрэлдэн тогтоход нөлөөлсөн нийгмийн нуугдмал, ужиг асуудлуудыг олж илрүүлэх боломж олддог.

Зөвлөгөөн: Шударга ёсыг нөхөн сэргээх хөтөлбөрийн онцлог нь гэмт хэргийн үр дагаврыг залруулах арга зам, хэлбэр, хохирол төлбөрийн хэмжээг хохирогч, гэмт этгээд болон гэмт хэргийн нөлөөнд өртсөн бусад этгээдүүдийн идэвхтэй оролцоо, харилцан ойлголцлын үндсэн дээр тодорхойлохыг зорьдогт оршино. Зөвлөлдөөнд оролцох оролцогчдын цар хүрээг хөтөлбөр бүрийн онцлог, зорилгоос хамаарч янз бүр байх боловч хохирогч, гэмт хэрэгтэн, нийгмийн төлөөллийг оролцуулах нь түгээмэл байдаг. Гэмт хэргийн хохирогч нь гэмт хэргийн улмаас хамгийн их гарз хохирол, зовлон шаналал амссан субъект учраас өөрт учирсан хохирол, хор уршгийг тодорхойлох, нөхөн төлөх арга хэлбэр, хэмжээг тогтоох процессын хамгийн идэвхтэй оролцогч байх ёстой. Нөгөө талаас гэмт этгээд нь өөрийн үйлдлээр бусдад учруулсан хохирол, зовлон шаналал болон бусад сөрөг үр дагавруудыг ойлгож ухаарах, чин сэтгэлийн гэмшил илэрхийлэх бололцоогоор хангах нь нөхөн сэргээх үзэл баримтлалын салшгүй хэсэг мөн.

⁵ Little book on Restorative Justice, Howard Zehr, 2014, USA-г үзнэ үү.

⁶ Little book on Restorative Justice, Howard Zehr, 2014, USA, page 17



Зөвлөлдөөнд оролцогч гуравдагч тал болох нийгмийн гишүүдийн төлөөлөл гэдэгт гэмт хэрэг үйлдэгдсэн тухайн орон нутгийн оршин суугчид, дам байдлаар хор уршгийг амссан иргэд болон хохирогч, гэмт хэрэгтэнд туслалцаа үзүүлэх сайн дурын байгууллагуудыг хамруулж болно. Гэмт хэрэг нь нийгмийн харилцаанд тулгарсан бэрхшээл болох талаасаа нийгмийн итгэлцэл гэх мэтчилэн нийтлэг үнэт зүйлсийг эрсдэлд оруулж байдаг. Энэхүү эрсдэлд орсон харилцаа, үнэт зүйлсийг сэргээх хэрэгцээ шаардлага нийгэмд ч мөн үүсдэг бөгөөд нийгмийн бусад гишүүдийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцуулах замаар гэмт хэргийн хохирогчийн онцгой хэрэгцээ, гэмт этгээдийг гэмт хэрэг үйлдэхэд түлхсэн шалтгаан нөхцөлийг ойлгох, нийгмийн дайсангасан байдлыг намжаах, нэгдмэл байдлыг дээшлүүлэхэд үр дүнтэй арга болдог гэж үздэг байна.

Ийнхүү гэмт хэргийн үр дагаврыг залруулах ажиллагааг уламжлалт шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас гадуур харьцангуй чөлөөт, уян хатан, харилцан зөвшилцөлд тулгуурласан процессоор дамжуулж шийдвэрлэхийг зорьдог нь нөхөн сэргээх шударга ёсны мөн чанарын нэгээхэн хэсэг юм.

Гэмт хэрэг бол юун түрүүнд ухамсар, сэтгэл бүхий бодгалиудын хооронд үйлдэгдсэн хүчирхийлэл гэдэг утгаараа хувь хүний сэтгэл зүйн болон бусад материаллаг бус хэрэгцээг харгалзалгүйгээр шийдвэр гаргах нь оролцогчдын шударга ёсны мэдрэмж, шүүхэд итгэх итгэлийг бууруулахад нөлөөтэй байж болох талтай. Хэдийгээр шүүх аль нэг талд таалагдсан шийдвэр гаргах албагүй ч, тухайн шийдвэрийн үндэслэлийг ойлгох бололцоог талуудад өгөх нь зүйтэй. Шударга ёсыг нөхөн сэргээх “эрх мэдлийг сэргээх загвар”-

ыг хөгжүүлэгч АНУ-ын судлаач Чарльз Бартон (*Charles Barton*): “Гэмт хэрэгтэн, хохирогч нар өөрсдийн гомдол, урам хугарсан мэдрэмж, уур хилэн зэрэг сэтгэл хөдлөл, мэдрэмжүүдийг илэрхийлэх хүртэл тэдний итгэж буй зүйл нь шударга эсвэл шударга бусын аль болохыг мэддэггүй ба ингэхгүйгээр шударга ёсыг сэргээсэн эсэхийг хүлээн зөвшөөрөхөд хэцүү. Уламжлалт эрүүгийн эрх зүйн тогтолцоонд хохирогчид дуу хоолой нь үл тоогдсон, мэдрэмж, үзэл бодол нь шийдвэр гаргах процесст нөлөөгүй мэт мэдрэмж төрүүлдэг” гэсэн санааг дэвшүүлжээ.⁷

Дээрх үндсэн ойлголтуудыг агуулсан **хөтөлбөрүүдээр** дамжин шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлал нь практикт хэрэгждэг. Дараах гурван хөтөлбөр хамгийн түгээмэл ашиглагдаж байна.

1. *Victim-offender mediation* буюу хохирогч-гэмт хэрэгтнийг эвлэрүүлэн зуучлах хөтөлбөр
2. *Conferencing* буюу зөвлөгөөний загварууд
3. *Circle* буюу тойргийн загварууд

Дээрх загварууд нь оролцогч талууд, тэдгээрийг үүрэг, уулзалтыг зохион байгуулах журам, болон уулзалтыг чиглүүлэгч зэргээрээ харилцан адилгүй байдаг байна.

II.2 Харьцуулсан судалгаа

Шударга ёсыг нөхөн сэргээх хөтөлбөрүүд нь үзэл баримтлалын талаасаа манай улсад шинэлэг ойлголт бөгөөд дэлхийн улс орнуудын туршлагыг харьцуулан судлах нь дотоодын эрх зүйн зохицуулалтад буй боломж болоод

⁷ Some Restorative Justice benefits to Offenders and Victims, Stefanova, 2014, Moskwa, page 19 http://www.antoniacasella.eu/restorative/Stefanovska_2014.pdf



хийдлийг танихад ач холбогдолтой юм.

ХБНГУ: Эрүүгийн болон эрүүгийн процессын хуулиудаар гэмт хэрэгтэн хохирогчтой эвлэрүүлэн зуучлах ажиллагааг хуульчилжээ. Тодруулбал, Эрүүгийн хуулийн 46а зүйлд “гэмт этгээд хохирогчтой эвлэрэх оролдлого хийсэн, хохирлоо бүрэн нөхөн төлсөн, эсхүл дийлэнх хэсгийг нөхөн төлсөн, нөхөн төлөхийн тулд хүчин чармайлт гаргасан бол оногдуулах ялыг хөнгөрүүлэх, нэг жил хүртэлх хорих ял эсвэл гурван зуу хүртэлх өдрийн ханш бүхий торгох ялаас чөлөөлөх боломжийг” хуульчилсан.⁸

Мөн Эрүүгийн процессын хуулийн 153а зүйлд “хүнд биш */less serious/* гэмт хэрэг үйлдсэн, уг хэрэг нь нийтийн ашиг сонирхлыг хөндөөгүй бөгөөд гэмт хэрэгтний гэм буруу нь харьцангуй бага⁹ гэж үзсэн тохиолдолд яллагдагч болон шүүгчийн зөвшөөрөлтэйгөөр прокурор тодорхой болзлууд тавьж яллахаас татгалзаж */dispense with prosecution/* болно”. Прокуророос тавьж болох болзлуудын дотор “*хохирогчтой эвлэрэх оролдлого хийх, хохирлыг нөхөн төлөх, эсхүл нөхөн төлөхийн төлөө нухацтай оролдлого*¹⁰”-ыг багтаажээ.¹¹

Эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд шилжүүлэх боломжтой гэмт хэргийн оролцогчдод тус ажиллагааны талаар санал болгохыг шүүгч, прокуроруудад үүрэгжүүлсэн бөгөөд Эрүүгийн процесс

хуулийн 155 дугаар зүйлд эвлэрүүлэн зуучлалд шилжүүлэх боломжтой гэмт хэргийн төрөлд ямар нэгэн хязгаарлалт тогтоож өгөөгүй байна.

Тус улсад Эрүүгийн хэргийн эвлэрүүлэн зуучлалын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр 400 орчим төрийн бус байгууллагууд үйл ажиллагаа явуулдаг байна.¹²

Унгар улс: Унгар улсын хувьд мөн адил Эрүүгийн болон Эрүүгийн процессын хуулиудаар эрүүгийн хэргийн эвлэрүүлэн зуучлалын ажиллагааг хуульчилж өгсөн бөгөөд уг ажиллагаанд эрүүгийн хэргийг шилжүүлэхэд Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд заасан “*active repentance*” хэмээх ойлголт чухал ач холбогдолтой. Энэ нь амьд явах эрхийн эсрэг; эрүүл мэндийн эсрэг; хүний үндсэн эрх, эрх чөлөөний эсрэг, замын хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг; хувийн өмч, оюуны өмчийн эсрэг хүнд биш гэмт хэргүүд болон хорих ялын дээд хэмжээ 3 жилээс доош хөнгөн гэмт хэрэг үйлдсэн хүн гэм буруугаа хүлээн зөвшөөрч, хохирлоо хохирогчийн тодорхойлсон хэлбэрээр нөхөн төлсөн, эсхүл гэмт хэрэгтэн-хохирогчийн эвлэрүүлэн зуучлах хөтөлбөрт оролцож эдгээрийг тохиролцож¹³ гэмт хэрэг үйлдсэн этгээд хохирол, хор уршгийг арилгахын төлөө идэвхтэй хүчин чармайлт гаргахыг илэрхийлдэг.

Үүнтэй холбоотойгоор тус улсын Эрүүгийн процессын хуулийн 255а зүйлд эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь сэжигтэн, хохирогчийн саналаар, эсхүл прокурорын санаачилгаар */ex officio/* талуудын зөвшөөрлөөр хэрэгжих бөгөөд гэмт этгээдийг зөвхөн нэг удаа эвлэрүүлэн

⁸ ХБНГУ-ын Эрүүгийн хууль /1998/, 46а дугаар зүйл

⁹ Эрүүгийн эрх зүйн шинжлэх ухаанд гэм буруугийн ойлголтод их, бага хэмжээ гэж байхгүй боловч гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, гэмт хэрэгтний нийгэмд аюултай зан төлвийн хэр хэмжээ зэргийг харгалзаж үзнэ.

¹⁰ ХБНГУ-ын Эрүүгийн процессын хуульд “*serious attempt*” хэмээх ойлголтыг дурдсан байх буюу энэ нь дан ганц оролдлого хангалттай бус, гэмт хэрэг үйлдэгчийн зүгээс чин сэтгэлийн хүчин чармайлт шаардлагатай гэсэн санааг агуулдаг.

¹¹ ХБНГУ-ын Эрүүгийн процессын хууль /1987/, 153а дугаар зүйлийн 2.4 дэх хэсэг

¹² Restorative Justice in Germany, Final National Report of Germany by Specific Programma Criminal Justice European Commission, 2013, page 8

¹³ Унгар улсын Эрүүгийн хууль /2012/, 29 дүгээр зүйл



зуучлах ажиллагаанд оролцуулахаар хуульчилжээ. Хохирогчтой эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцсоноор хэргийг хэрэгсэхгүй болгох, шүүхээс ялаас чөлөөлөх, оногдуулах ялыг хөнгөрүүлэх хууль зүйн үр дагавартай.

Эвлэрүүлэн зуучлах ажиллагааг Пробацийн төвөөс томилогдсон тусгай сургалтад хамрагдсан пробацийн цагдаа явуулдаг. 2008 оноос эхлэн тусгайлан сургалтад хамрагдсан хуульчид эвлэрүүлэн зуучлагчаар ажиллаж эхэлсэн боловч 2012 оноос төсвийн хүрэлцээгүй байдлаас болж зогсоожээ.¹⁴

Уг хоёр улсын аль аль нь шударга ёсыг нөхөн сэргээх хөтөлбөрүүдээс хохирогч-гэмт хэрэгтнийг эвлэрүүлэн зуучлах загварыг¹⁵ сонгож уламжлалт шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх тогтолцоотой хамтатгаж, хэргийг хэрэгсэхгүй болгох, ялаас чөлөөлөх, оногдуулах ялыг хөнгөрүүлэх урьдчилсан нөхцөл болгож хэрэглэж байх ба үүнийгээ эрүүгийн материаллаг хуулиар хуульчилж, харин эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд тавигдах шаардлага, шалгуур, зуучлалын ажиллагаанд шилжүүлж болох гэмт хэргийн төрлүүдийг эрүүгийн процессын хуулиараа зохицуулсан байна.

ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 46а зүйлд заасан “идэвхтэй хүчин чармайлт гаргах”, Унгар улсын Эрүүгийн хуулийн 29 дүгээр зүйлд заасан “*active repentance*” зэрэг ойлголтууд нь агуулгын хувьд нөхөн сэргээх шударга ёсны үзэл санааг илэрхийлсэн байна. Тодруулбал, гэмт хэрэг үйлдэгч нь өөрийн үйлдсэн гэмт

хэргийн үр дагаврыг залруулахын төлөө өөрийн зүгээс чин сэтгэлийн, идэвхтэй хүчин чармайлт гаргах явдал нь түүнд оногдуулах ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх үндэслэл болж байх бөгөөд тусгай процессыг бүрдүүлэх замаар хохирогчийг сонсох эвлэрэх боломжийг олгож, түүнийг нотлох боломжтой байдлаар зохицуулжээ.

ХБНГУ-ын хувьд эвлэрүүлэн зуучлалын ажиллагаанд шилжүүлж болох гэмт хэргүүдэд нарийвчилсан хязгаарлалт тогтоож өгөөгүй боловч практикт энэ нь зөвхөн хөнгөн хэргүүдэд л хэрэглэгддэг бол Унгар улс гэмт хэргүүдийг нэрлэн жагсаах, хорих ялын хэмжээгээр хязгаарлах аргыг хослуулан тогтоожээ. Гэвч хүнд гэмт хэргийн хохирогч, яллагдагч нар ч зарим тохиолдолд эвлэрэхийг хүсэж болохыг үгүйсгэхгүй бөгөөд энэ тохиолдолд тэдгээр оролцогчдын эвлэрүүлэн зуучлах ажиллагаанд оролцох хүсэлт гаргах эрхийг хязгаарлах нь эрүүгийн эрх зүйн шударга ёсны зарчмыг зөрчих эрсдэлтэйг анхаарах нь зүйтэй.

Дэлхий нийтийн чиг хандлагаар “эрүүгийн хэргийн эвлэрүүлэн зуучлалын ажиллагаа нь нийтлэг үйлчлэх боломжтой байх ёстой”.¹⁶ Түүнчлэн НҮБ-аас баталсан “Эрүүгийн хэрэгт шударга ёсыг нөхөн сэргээх хөтөлбөрүүдийг хэрэглэхэд баримтлах суурь зарчмууд”-ын 17 дугаар зүйлд мэргэшсэн хөтөлбөрийг чиглүүлэгч удирдахын ач холбогдлыг онцолсон байдаг.¹⁷ Шударга ёсыг нөхөн сэргээх загваруудад процессыг чиглүүлэх

14 Research and Selection of the Most Effective Juvenile Restorative Justice Practices in Europe, by European Council for Juvenile Justice and International Juvenile Justice Observatory, 2015, page 89

15 Шударга ёсыг нөхөн сэргээх загваруудаас хохирогч-гэмт хэрэгтнийг эвлэрүүлэн зуучлах хөтөлбөр нь дэлхий даяар хамгийн түгээмэл хэрэглэгддэг загвар болохыг дурдах нь зүйтэй.

16 Европын холбооны зөвлөлөөс батласан “Эрүүгийн хэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхэд анхаарах асуудлуудын талаарх зөвлөмж” /1999/-ийн 3 дугаар зүйлд “Эвлэрүүлэн зуучлах ажиллагаа нь нийтлэг үйлчлэх боломжтой байх ёстой” гэжээ.

17 Basic principles on the use of restorative justice programmes in criminal matters, UN ECOSOC, 2002



хараат бус, төвийг сахисан гуравдагч этгээд заавал байхыг шаарддаг. Судалсан хоёр орны тухайд эрүүгийн хэрэгт эвлэрүүлэн зуучлах үйлчилгээг үзүүлэх тогтолцоог харилцан адилгүй байдлаар шийдвэрлэжээ.

Харин манай улсын хувьд эрүүгийн эрх зүйд эвлэрлийн институтийг хуульчилж ирсэн уламжлалтай боловч 2015 оноос хойш хэрэгжиж буй эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд энэхүү институт бүрэн орхигдсон билээ. Өмнөх уламжлалын давуу болоод сул тал, одоогийн эрх зүйн зохицуулалтын шинж чанарыг тодруулж, дээрх улс орнуудын зохицуулалттай харьцуулах замаар дотоодын эрх зүйн системд эзлэх нөхөн сэргээх шударга ёсны байр суурийг тодорхойлох, суурь зохицуулалтыг олж тогтоох, түүнийг сайжруулах чиг баримжааг тодорхойлох нь энэхүү судалгааны нэгэн зорилт билээ.

II.3 Шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлалыг Монгол Улсын эрүүгийн эрх зүйн хууль тогтоомжид нэвтрүүлэх шаардлага, арга зам

Манай улсын хувьд хөнгөн гэмт хэрэгт хохирогч гэмт этгээдтэй эвлэрснээр

эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох зохицуулалт 1926 оны “Шүүх цаазын бичиг”-ээс хойш 2002 оны Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулиудыг хүртэл уламжлал болон зохицуулагдаж ирсэн билээ. Тодруулбал, 1926 оны “Шүүх цаазын бичиг”-ийн 193 дугаар зүйл, 1935 “Аливаа хэргийг хэрхэн байцаах ба шийтгэх тухай” хуулийн 30 дугаар зүйл¹⁸, 1949 оны ЭБШХ-ийн 5 дугаар зүйлийн 2 хэсэг, 1986 оны ЭХ-ийн 98 дугаар зүйлийн 1 дэх хэсэг тус тус хохирогчийн гомдлоор үүсэх хөнгөн хэргүүдэд гэмт этгээд хохирогчтой эвлэрсэн бол хэргийг хэрэгсэхгүй болгохоор зохицуулсан байжээ.¹⁹ Үүний дараа 2002 оны Эрүүгийн хуулийн 71 дүгээр зүйл, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 25 дугаар зүйлд хөнгөн гэмт хэрэг анх удаа үйлдсэн этгээд хохирогчтой эвлэрч, хохирлыг бүрэн барагдуулсан бол хэргийг хэрэгсэхгүй болгох зохицуулалтыг уламжлан авчээ.

Энэхүү уламжлалт зохицуулалтын үр нөлөө болоод дутагдлыг тодруулах зорилгоор судлаачийн зүгээс тоон мэдээлэл болон шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийж үзэхэд:

¹⁸ Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал /хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл/, Б.Бат-Орших, УБ хот, 2021 он, хуудас 118-с дам эшлэв.

¹⁹ БНМАУ-ын хууль тогтоомжийн системчилсэн эмхэтгэл 9, 1995 он



Хүснэгт № 2. Бүртгэгдсэн гэмт хэрэг ба 2002 оны ЭБШХ-ийн 25.1 дүгээр зүйлээр шүүхийн өмнөх шатанд хэрэгсэхгүй болсон эрүүгийн хэргийн судалгаа (2010-2015) ²⁰

	2010 он	2011 он	2012 он	2013 он	2014 он	2015 он
Нийт бүртгэгдсэн эрүүгийн хэрэг	30124	31349	34699	37686	40682	42130
Үүнээс хөнгөн гэмт хэрэг	10386	9709	11410	13763	16168	16666
ЭБШХ-ийн 25.1 дүгээр зүйлд зааснаар хэрэгсэхгүй болгосон хэрэг /шүүхийн өмнөх шатанд/	6524	7116	7980	8662	9569	9701
Хүндэвтэр хэрэг	16582	17299	18919	19782	20244	21629

Хүснэгтээс харахад 2010-2015 оны хооронд бүртгэгдсэн хөнгөн гэмт хэргүүдийн дунджаар 64.25 орчим хувь нь шүүхийн өмнөх шатанд талууд эвлэрсэн үндэслэлээр хэрэгсэхгүй болгож шийдвэрлэгдсэн ба уг хэргийн тоо жил ирэх тусам өссөн үзүүлэлттэй байна. Өөрөөр хэлбэл, дээрх тоон мэдээллүүдээс эрүүгийн хууль тогтоомжуудад уламжлагдан зохицуулагдаж ирсэн эвлэрлийн институт нь практикт өргөн хэрэглэгдэж хэвшсэн төдийгүй тодорхой хэмжээнд амжилттай хэрэгжиж чаддаг байжээ гэж дүгнэх боломжтой байна.

Харин 2002 оны Эрүүгийн болон Эрүүгийн процесс хуульд заасан хохирогч яллагдагчтай эвлэрэх зохицуулалтыг хэрэглэж шийдвэрлэсэн шүүхийн практикийг судлах явцад²¹ дараах асуудлууд нийтлэг ажиглагдсаныг товчлон хүргэвэл:

21 Судалгааны явцад Эрүүгийн хуулийн /2002/ 71.1 дэх хэсэгт, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 25.1 дэх хэсэгт, 208.1.3 дахь заалтад зааснаар 2012 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2016 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн хооронд шүүхээс эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн 20 шүүхийн шийдвэрийг шүүхийн шийдвэрийн цахим сан shuukh.mn сайтаас системчилсэн түүврийн аргаар сонгож судлав. Ингэхдээ 10 шийдвэр тутмын 1 дэх шийдвэрийг сонгосон бөгөөд үүнд ЭБШХ-ийн 25.1-т заасан хохирогч нь яллагдагч, шүүгдэгчтэй сайн дураараа эвлэрсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгосон 16, ЭХ-ийн 71.1-т заасныг үндэслэж хэргийг хэрэгсэхгүй болгосон 4 шийдвэр байлаа.

1. Шүүхээс талуудыг эвлэрлийг хүлээн зөвшөөрч буй үндэслэлийг шийдвэрийнхээ тодорхойлох хэсэгт тодорхой тайлбарлан бичдэггүй. Ихэвчлэн зөвхөн шүүхээс ЭХ-ийн 71.1, ЭБШХ-ийн 25.1-д заасан хуулийн гипотезийн бүрэлдэхүүн хэсгүүд буюу урьдчилсан нөхцөлүүдэд задалж хохирол нөхөн төлсөн хэмжээ; гэмт хэргийн ангилал; урьд ял шийтгэгдсэн эсэх, ялтай байдлын хугацаа дууссан эсэхийг тогтоож эвлэрэх үндэслэл бүрдсэн гэж дүгнэсэн байна.
2. УДШ-ийн 2012 оны 2 дугаар зөвлөмжийг дагаж мөрдөөгүй. Улсын дээд шүүхээс хохирогч яллагдагчтай эвлэрснээ холбогдох байгууллага, албан тушаалтанд тодорхой илэрхийлсэн байхаар тайлбарласан боловч шүүхийн шийдвэрүүдэд хохирогчийн хэрэг бүртгэлтийн шатанд, шүүхийн хэлэлцүүлэгт өгсөн “хохирлоо бүрэн барагдуулсан тул санал, гомдолгүй; нэхэмжлэх зүйл байхгүй” гэх мэдүүлгүүдийг шүүгдэгчтэй эвлэрэхийг зөвшөөрсөн мэтээр дүгнэсэн байгаа нь хуулийг алдаатай

²⁰ Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал /хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл/, Б.Бат-Орших, УБ хот, 2021 он, хуудас 153-аас дам эшлэв.



хэрэглэсэн гэж үзэх нөхцөл болж байна.

3. Шүүхийн шийдвэрүүдийн дийлэнх нь б усдын эрүүл мэндэд хөнгөн гэмтэл санаатай учруулах гэмт хэрэг нь ихэвчлэн шүүгдэгч архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үед үйлдэгдсэн байх ба шүүгдэгч, хохирогч хоёр танил найз нөхөд, хөршүүд, гэр бүлийн хамааралтай зэрэг хоорондоо хоорондоо танилын харилцаатай хүмүүс байна.

Эрүүгийн хэрэгт эвлэрлийн механизмыг хэрэглэж ирсэн практикийг харахад ихэвчлэн танилын холбоо хамааралтай хүмүүсийн хооронд гарсан хөнгөн төрлийн гэмт хэргүүдэд ашигласан байх ба эвлэрлийн үнэн бодитой байдлыг шалгах, хяналт тавих механизм хөгжөөгүй байжээ. Үүнээс шалтгаалан яллагдагчид ял завшуулах талаарх маргаан практикт үүсэхийг буруутгах аргагүй бөгөөд хүснэгт №2-ын тоон мэдээллүүдэд авагдсан хэрэглээний өндөр түвшинтэй харьцуулахад ийм төрлийн дутагдал, хийдлүүд нь практикт сөрөг үр дагавар үзүүлж болохыг ч мөн үгүйсгэх аргагүй.

Хэдийгээр зарим талаараа засаж сайжруулах шаардлагатай боловч эвлэрлийн аргыг эрүүгийн хэрэгт хэрэглэж байсан нь манай улсын хувьд олон улсын эрүүгийн эрх зүйн хөгжлийн чиг хандлага, тэр дундаа хүнлэг ёсны зарчмыг агуулсан томоохон илрэл хэлбэр байсан хэдий ч эрүүгийн хууль тогтоомжийн шинэтгэлийн хүрээнд энэхүү институтыг бүрэн хассан явдал нь тодорхой хэмжээний ухралт болсон гэж судлаачийн зүгээс дүгнэж байна.

Шинэчлэн найруулсан 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангийн

6.7 дугаар зүйлд “гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх” зохицуулалт нь хохирогч яллагдагчийг эвлэрсэн байхыг шаардаагүй ч бусад улс орны эрх зүйн зохицуулалтуудтай харьцуулахад манай улсын эрүүгийн эрх зүйн хэм хэмжээний доторх шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлалын элементүүдийг агуулсан суурь зохицуулалт байна. Гэхдээ уг зохицуулалтыг илүү тодорхой авч үзвэл дараах хийдлүүд буюу боловсронгуй бус байдлууд ажиглагдана. Нэгдүгээрт, шинэчлэн найруулсан эрүүгийн хууль тогтоомж хэрэгжиж эхэлснээс хойших шүүхийн практикийг харахад шүүхээс оногдуулж буй нийтийн ялын оролцоогоор 45-50 орчим хувийг торгох ял эзэлж байхад тус зохицуулалтад ялаас чөлөөлөх үндэслэлд хорихоос өөр төрлийн ялыг оруулаагүй. Хоёрдугаарт, “хохирол нөхөн төлөхөө илэрхийлсэн” гэх тодорхойгүй ойлголтыг хэрэглэснээр хохирогчийн эрх ашиг бүрэн хамгаалагдаж, гэмт этгээдээс хохирлоо бүрэн нөхөн төлүүлж авах баталгааг сулруулсан байна. Төлбөрийн чадваргүй, нэг дор их хэмжээний хохирлын төлбөр нөхөн төлөх чадваргүй яллагдагчийн хувьд тус ойлголт нь эрүүгийн хуулийн хөнгөлөлтөд хамрагдах боломжийг нээж өгч буйгаараа ач холбогдолтой боловч баталгаат байдлыг хангах асуудал дээр эргэлзээ үүсгэсэн билээ.

Эрүүгийн хуулийн 6.7 дугаар зүйлд заасан тус зохицуулалтыг манай улсад нэгэнт уламжлагдан хэрэглэгдэж хэвшсэн хохирогч-гэмт хэрэгтнийг эвлэрүүлэн зуучлах хөтөлбөрийн агуулга, зохицуулалтын цар хүрээг шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлалын үүднээс боловсронгуй болгон хуульчлах боломжтой. Ингэснээр гэмт хэргийн



хор уршиг, хохирлын талаар хохирогч, гэмт этгээдийн харилцан зөвшилцөөний үндсэн дээр нөхөн төлөх нөхцөл, арга хэлбэрийг уян хатан тодорхойлох боломж бүрдэнэ. Нөгөө талаас гэмт хэргийн хохирлыг үнэлэх тогтолцоо хангалттай хөгжөөгүй манайх шиг улсад гэмт хэргийн улмаас учирсан хохирол, хор уршгийг талууд өөрсдөө тодорхойлж, нөхөн төлөх хэлбэр /материаллаг болон материаллаг бусаар/, хэмжээг тогтоох нь гэмт хэргийн сөрөг үр дагаврыг залруулах ажилд дэмжлэг болж болох юм.

III ДҮГНЭЛТ

“Restorative Justice Concept” буюу шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлал нь дэлхий нийтэд эрүүгийн эрх зүйн хөгжлийн шинэ чиг хандлага болон хөгжиж буй бөгөөд бусад улс орнуудын туршлагаас харахад уламжлалт шүүхээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай хамтатгаж, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгох, ялаас чөлөөлөх, ял хөнгөрүүлэх нэг нөхцөл болгон хэрэглэж байна.

Манай улсын хувьд 1926 оноос 2002 оныг хүртэл хохирогч гэмт этгээдтэй эвлэрсэн үндэслэлээр хэргийг хэрэгсэхгүй болгох зохицуулалт нь уламжлагдан зохицуулагдаж ирсэн боловч зарим талаараа боловсронгуй бус байсны улмаас практикт хэрэглэхэд хүндрэл гарч байсныг үгүйсгэх аргагүй ч нэгэнт хэрэглэж хэвшсэн бөгөөд тодорхой үр дүнд хүрснийг мөн үгүйсгэж болохгүй.

Шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулиас дээрх зохицуулалтыг хассан нь эрүүгийн эрх зүйн хөгжлийн хүнлэг ёсны чиг хандлагын үүднээс ухралт болсон. Гэсэн хэдий ч тус хуулийн 6.7 дугаар зүйлд заасан “гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх” зохицуулалт нь шударга ёсыг

нөхөн сэргээх үзэл баримтлалын суурь элементүүдийг агуулсан, хүнлэг ёсны хандлагын үзэл санааг сэргээн нэвтрүүлж болох суурь зохицуулалт байна. Энэхүү зохицуулалтын хийдэл, сул талыг шударга ёсыг нөхөн сэргээх хөтөлбөр, үзэл баримтлалын үүднээс баяжуулж боловсронгуй болгох боломжтой.

IV САНАЛ

Судалгааны хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Цаашид нөхөн сэргээх шударга ёсны үзэл баримтлалыг онолын үндэслэлтэйгээр гүнзгийрүүлэн судлах, дотоодын эрх зүйн тогтолцоонд эзлэх байр суурийг тодорхойлж, боловсронгуй болгох чиглэлээр судалгаа, шинжилгээг гүнзгийрүүлэх ажлыг үндэсний эрх зүйн тогтолцооны зорилтын хүрээнд багтааж авч үзэх;
2. 2015 оны Эрүүгийн хуулийн “гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн хүнд оногдуулах хорих ялыг хөнгөрүүлэх, ялаас чөлөөлөх, албадлагын арга хэмжээ хэрэглэх” зохицуулалтад ялаас чөлөөлөх нөхцөлд хорихоос өөр төрлийн ялуудыг нэмж хуульчлах;
3. Мөн тус зохицуулалтын ялаас чөлөөлөх, хөнгөрүүлэх нөхцөлд манай улсад нэгэнт уламжлагдан хэрэглэж хэвшсэн хохирогч-гэмт хэрэгтнийг эвлэрүүлэн зуучлах хөтөлбөрийг шударга ёсыг нөхөн сэргээх үзэл баримтлалын үүднээс боловсруулж нэмж хуульчлах. Ингэхдээ эрүүгийн хэргийн мэргэшсэн эвлэрүүлэн зуучлагчийг бэлтгэх, ажиллагааг удирдуулах, эвлэрүүлэн зуучлалын ажиллагаагаар



талуудын хүрсэн тохиролцоог баталгаажуулах үүргийг тогтоох.

ЭХ СУРВАЛЖ

Хууль:

1. Эрүүгийн хууль /2015 он/;
2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль /2017/;
3. Эрүүгийн хууль /2002 он/;
4. Эрүүгийн байцаан шийтгэх хууль /2002 он/

Ном, судалгааны бүтээл /Монгол хэл дээрх/:

1. Баярсайхан Д., Эрүүгийн эрх зүй, эрүүгийн процессын шинэтгэлийн асуудлууд, УБ хот, 2019 он;
2. Бат-Орших Б., Эрүүгийн хэргийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтын үндсэн асуудал /хууль зүйн докторын зэрэг горилсон бүтээл/, УБ хот, 2021 он;
3. Нарангэрэл С. болон Эрдэнэбулган Ж., Монгол Улсын Эрүүгийн эрх зүй: үзэл баримтлал, уламжлал, шинэчлэл, УБ хот, 2019 он

Хууль, олон улсын эрх зүйн хэм хэмжээ /гадаад хэл дээр/:

1. ХБНГУ-ын Эрүүгийн хууль /1998/;
2. ХБНГУ-ын Эрүүгийн процессын хууль /1987/;
3. Унгар улсын Эрүүгийн хууль /2012/;
4. Унгар улсын Эрүүгийн процессын хууль //;
5. Эрүүгийн хэрэгт эвлэрүүлэн зуучлалыг хэрэглэхэд анхаарах асуудлуудын талаарх зөвлөмж, Европын холбооны зөвлөл, /1999/;

6. Эрүүгийн хэрэгт шударга ёсыг нөхөн сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах суурв зарчмууд, НҮБ, 2002 он;

Судалгаа ажил, өгүүллэгүүд / гадаад хэл дээр/:

1. Restoring Justice. An Introduction to Restorative Justice, Daniel W. Van Ness and Karen Heetderks Strong, 2015, USA;
2. Little book on Restorative Justice, Howard Zehr, 2014, USA;
3. Some Restorative Justice benefits to Offenders and Vistims, Stefanova, 2014, Moskwa, page 19 http://www.antonioacasella.eu/restorative/Stefanovska_2014.pdf;
4. Restorative Justice in Germany, Final National Report of Germany by Specific Programma Criminal Justice Europian Commision, 2013;
5. Research and Selection of the Most Effective Juvenile Restorative Justice Pratices in Europe, by European Council for Juvenile Justice and International Juvenile Justice Observatory, 2015

Статистик мэдээллүүд:

1. Гэмт хэргийн статистик 2020, Статистикийн үндэсний хороо, 2021 он;
2. Шүүхийн ерөнхий зөвлөлийн тайлан мэдээ 2020;
2. Унгар улсын гэмт хэргийн статистик https://www.ksh.hu/stadat_files/iga/en/iga0002.html



Abstract

RESTORATIVE JUSTICE CONCEPT AND TENDENCY IN DEVELOPMENT OF CRIMINAL JUSTICE

Z.YANJINKHAM

*Researcher, Judicial Training, Research, and Information
Institute under Supreme Court of Mongolia*

General purpose of this article is to provide a brief identification of Restorative Justice Concept in the field of humanization in criminal law. Also it's implementation in national criminal law.

Keywords

restorative justice, retributive justice, criminal law, criminal procedure, humanization in criminal law



**ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ,
ШҮҮХИЙН ТОГТООЛД ГОМДОЛ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН
ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ¹**

**THE ISSUE OF IMPROVING THE LEGAL REGULATIONS REGARDING
WITH RIGHT TO APPEAL ON JUDGE'S ORDER AND DECREE OF THE
ADMINISTRATIVE COURT**

**А.ТҮВШИНТУЛГА²
Г.ЦЭРЭНДЭЖИД³**

- I. Удиртгал
- II. Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын талаар товч өгүүлэх нь
- III. Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, практикт тулгамдаж буй зарим асуудал
- IV. Дүгнэлт, санал
- V. Ашигласан материал

¹ Энэхүү илтгэл нь Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны шүүхээс зохион байгуулсан “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгох нь” сэдэвт эрдэм шинжилгээний илтгэлийн уралдаанд тусгай байрт шалгарсан болно.

² Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Хууль зүйн магистр (LL.M)

³ Шүүгчийн туслах



ЗАХИРГААНЫ ХЭРГИЙН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗАХИРАМЖ, ШҮҮХИЙН ТОГТООЛД ГОМДОЛ ГАРГАХТАЙ ХОЛБООТОЙ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ АСУУДАЛ

А.ТҮВШИНТУЛГА Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч

Г.ЦЭРЭНДЭЖИД Шүүгчийн туслах

Түлхүүр үгс

Шүүх эрх мэдэл, шүүгч, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, гомдол гаргах эрх

Хураангуй

Энэхүү илтгэлээр Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, түүнд гомдол гаргахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг судлан шүүхийн практикт тулгамдаж буй зарим асуудлыг хөндөж, түүнийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий санал, дүгнэлт хийхийг зорив.

I. Удиртгал

Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ. Шүүхийг эрүү, иргэн, захиргааны зэрэг шүүн таслах ажлын төрлөөр дагнан байгуулж болох бөгөөд дагнасан шүүхийн үйл ажиллагаа, шийдвэр нь Улсын дээд шүүхийн хяналтаас гадуур байж үл болохыг Монгол Улсын Үндсэн хуульд тунхагласан билээ.

Манай улсад Үндсэн хуулийн дээр дурдсан үндэслэлийн дагуу орчин үеийн Захиргааны хэргийн шүүх байгуулахад чиглэсэн зохион байгуулалт-эрх зүйн ажил 1998 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр эхэлсэн¹

¹ Чимид Б., “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн” УБ., 2004, 26 дахь тал

гэж үзэх болох юм. Улмаар 2002 оны 12 дугаар сарын 26-ны өдөр “Захиргааны хэргийн шүүх байгуулах тухай хууль”, “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” батлагдсанаар захиргааны хэргийн шүүх нь нийгэмд өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэх эрх зүйн суурь нөхцөл бүрджээ.

Өдгөө захиргааны хэргийн шүүх нь Монгол Улсын шүүхийн тогтолцооны салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд захиргааны байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлж, иргэн, хуулийн этгээд /захиргааны байгууллага, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд хамаарна/-ийн зөрчигдсөн, эсхүл зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах чиг үүргээ амжилттай хэрэгжүүлж байна.

Аливаа шүүх хуулиар тодорхойлсон зорилго, чиг үүргээ хэрэгжүүлэхэд тухайн шүүхийн үйл ажиллагаанд хамаарах процессын хууль чухал ач холбогдолтой байдаг. Захиргааны хэргийн шүүхийн тухайд, 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль хэрэгжиж эхэлсэн нь захиргааны процессын эрх



зүйн хөгжлийн шинэ үеийг эхлүүлсэн билээ. Уг хууль хэрэгжиж эхэлснээс хойшхи 6 орчим жилийн хугацаанд хуулийн зохицуулалтыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хэрэглэхтэй холбоотой дэвшилтэй, үр нөлөөтэй олон зохицуулалт бий боловч зарим тодорхой асуудал тулгамдаж байна. Тухайлбал, шүүхэд нэхэмжлэл гаргах этгээд, тэдгээрийн эрх зүйн байдал, нэхэмжлэлийн бүрдүүлбэр, түүнийг хангуулах, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, шүүгч татгалзан гаргах, шүүгчийг татгалзан гаргах, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх гэх мэт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны тодорхой үе шатад хамаарах эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгох, шүүхийн практикийг нэгтгэх асуудалд цаашид анхаарах шаардлагатай юм.

Судлаачийн зүгээс энэхүү илтгэлээр Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, түүнд гомдол гаргахтай холбоотой эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох асуудлыг судалж, тулгамдаж буй зарим асуудлыг тодорхойлж, түүнийг шийдвэрлэхэд ач холбогдол бүхий санал, дүгнэлт гаргах зорилгоор энэхүү сэдвийг сонгон судалсан болно.

Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол, түүнд гомдол гаргахтай холбоотой ажиллагаа нь шүүхийн практикт байнга тохиолдолд нийтлэг ажиллагаанд хамаарах бөгөөд захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад

шүүгчээс дангаараа болон шүүх бүрэлдэхүүнээс гаргасан шийдвэр, түүнийг эс зөвшөөрч гаргасан гомдолд хамаарах ажиллагаанд тулгамдсан асуудлыг тодорхойлж, эрх зүйн зохицуулалтыг илүү боловсронгуй болгосноор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрахаас сэргийлэх, процессын хуулийн зохицуулалтыг шүүхийн практикт нэг мөр ойлгож хэрэглэх, шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс гарсан шийдвэрийн биелэлт /даруй/ хангагдахад чухал ач холбогдолтой юм. Энэ нь эцэстээ шүүхийн үйлчилгээ түргэн шуурхай ойлгомжтой байх, иргэдэд чирэгдэлгүй хүрэх, шүүхэд хандсан этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хуульд заасан хугацаанд хамгаалагдаж, нөхөн сэргэх зэрэг эерэг үр нөлөөтэй.

Энэхүү сэдвийн хүрээнд нэг сэдэвт ном, судалгааны бүтээл, өгүүлэл, нийтлэл хараахан гараагүй байх боловч зарим судлаачдын судалгааны бүтээлд тодорхой хэмжээнд тусгагджээ. Тодруулбал, Г.Банзрагч “Захиргааны процессын эрх зүй” УБ, 2019, А.Эрдэнэцогт “Монгол Улсын Захиргааны процессын эрх зүй” УБ, 2012, Ц.Цогт “Захиргааны хэргийн шүүх” УБ, 2019, Б.Чимид “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн” УБ, 2004 болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар УБ, 2007, Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар УБ, 2012 он зэрэг судалгааны бүтээлд тодорхой дэд сэдвийн хүрээнд дурдагдсан байна.

Судалгааны ажлын явцад олон төрлийн санал, дүгнэлт бүхий судалгааны бүтээл, шүүхийн статистик мэдээллээс түүвэрчлэх



аргаар мэдээлэл цуглуулсан болно. Мөн шүүхийн практик судалгаа хийж, эрх зүйн баримт бичгийг харьцуулан судалж үзлээ.

II. Шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын талаар товч өгүүлэх нь

Захиргааны хэргийн шүүх нь нийтийн эрх зүйн субъект болох засаг захиргааны байгууллага, албан тушаалтны хууль дээдлэн бэхжүүлж хүний эрхийг хэрхэн хангаж байгааг иргэд, хуулийн этгээдийн нэхэмжлэлийн үндсэн дээр хянан шалгаж, тэдгээр байгууллага, албан тушаалтны хууль бус акт, дур зоргын үйл ажиллагаанаас хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, зөрчигдсөн эрхийг нь сэргээж тогтоох зорилго эрх мэдэл бүхий дагнасан шүүх мөн.²

Харин “шүүгч” гэдэг бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу томилогдож, шүүгчийн тангараг өргөсөн, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж байгаа Монгол Улсын иргэнийг ойлгохоор хуульчилжээ.

Шүүгч өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлж, хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тодорхой төрлийн эрхийн актууд гаргадаг байна.

Шүүхийн шийдвэр хууль зүйн үр дагавраараа заавал биелэгдэх, эцсийн байх шинжийг өөртөө агуулдаг. Аливаа хэрэг маргааны тухайд хамгийн дээд хүчин чадалтай эрх зүйн акт нь шүүхийн хуулийн хүчин төгөлдөр шийдвэр юм. Захиргааны хэргийн шүүхээс гаргах актыг шийдвэр, магадлал, тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэр гэсэн

хэлбэртэй байхаар хуульд тусгасан.³

Тодруулбал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1. дэх хэсэг Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно: 3.1.4.-д “анхан шатны шүүхийн шийдвэр” гэж захиргааны хэргийн анхан шатны шүүхээс захиргааны хэргийг хянан шийдвэрлэж гаргасан шийдвэрийг”, 3.1.5.-д “шүүхийн тогтоол” гэж захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх бүрэлдэхүүнээс гаргасан болон хяналтын шатны шүүхээс захиргааны хэргийг хянан хэлэлцэж гаргасан шийдвэрийг”, 3.1.6.-д “магадлал” гэж захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс захиргааны хэргийг хянан шийдвэрлэж гаргасан шийдвэрийг”, 3.1.7.-д “шүүгчийн захирамж” гэж захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчээс дангаараа гаргасан шийдвэрийг”, 3.1.8.-д “шийтгэвэр” гэж захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөрчил гаргасан этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага оногдуулсан шийдвэрийг”, 12 дугаар зүйлийн 12.1. дэх хэсэгт Захиргааны хэргийн шүүхийн шийдвэр дараах хэлбэртэй байна: 12.1.1.-д “анхан шатны шүүхийн шийдвэр”, 12.1.2.-т “магадлал”, 12.1.3.-т “тогтоол”, 12.1.4.-т “шүүгчийн захирамж”, 12.1.5.-д “шийтгэвэр”, 12.2. дахь хэсэгт “Захиргааны хэргийн шүүхийн шийдвэрийг Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа холбогдох захиргааны байгууллага, хуулийн этгээд, албан тушаалтан, хүн заавал

² Чимид Б., “Захиргааны хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн” УБ., 2004, 33 дахь тал

³ Амарсайхан Ц. нар, “Процессын эрх зүй онол, туршлага” УБ., 2014, 70 дахь тал



биелүүлэх үүрэгтэй бөгөөд сайн дураар биелүүлээгүй бол хуульд заасан үндэслэл, журмын дагуу албадан гүйцэтгэнэ.” гэж тус тус заасан.

Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад бий болсон тодорхой асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн байдаг. Үүнийг агуулгаар нь захиргааны процессын харилцаа “үүсгэх” болон үүсгэхээс “татгалзах” тухай, процессын тодорхой ажиллагаа “явуулах” болон “хойшлуулах” тухай, мөн хэргийн оролцогчийн “эрхийг хангах” болон шүүх хуралдааны “журам сахиулах”-аар гаргасан акт, тэрчлэн захиргааны хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг “түдгэлзүүлэх” болон ажиллагааг “сэргээн явуулах” тухай акт гэх зэргээр ангилж болно.⁴

Захиргааны хэргийн шүүхээс гарах дээрх актыг хэлбэрийн хувьд “амаар” болон “бичгээр” гэж ангилах бөгөөд хуульд гомдол гаргахаар заасан болон шүүх хуралдааны бус үед хянан шийдвэрлэж байгаа асуудлаар шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг ажлын гурван өдрийн дотор бичгээр гаргана. Гомдол гаргах эрхгүй шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол гарснаар шууд хүчин төгөлдөр болно, харин гомдол гаргах эрхтэй бол гомдол гаргах хугацаа дууссанаар юм уу гомдлыг хянан шийдвэрлэж дууссанаар хүчин төгөлдөр болно.⁵ Шүүх хуралдааны явцад хууль гомдол гаргахаар заагаагүй асуудлыг шийдвэрлэсэн захирамжийг хуралдааны тэмдэглэлд

⁴ Эрдэнэцогт А. “Монгол Усын захиргааны процессын эрх зүй” Уб., 2012, 320 дахь тал

⁵ Банзрагч Г., “Захиргааны процессын эрх зүй” Уб., 2019, 331 дэх тал

тусгах байдлаар амаар гаргаж болно.⁶

Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж нь шүүхийн шийдвэрийн нэгэн адил удиртгал, тодорхойлох, үндэслэх (хянах), тогтоох (захирамжлах) хэсгээс бүрдэнэ.⁷ Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид шийдвэрлэж буй асуудлыг аль болох товч, тодорхой, хуулийн үг хэллэгээр боловч хэргийн оролцогч нарт ойлгомжтой байхаар тусгах нь зүйтэй байдаг.

Онолын хувьд, захиргааны хэргийн шүүхээс гаргадаг баримт бичгийг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны харилцан уялдаа холбоо, бий болгодог эрх зүйн үр дагавраар нь 1) нотолгооны, 2) зохицуулсан, 3) захирамжилсан, 4) тогтоосон, 5) бусад баримт бичиг гэж ангилдаг байна.⁸

Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол нь хэргийн оролцогчийн субъектив эрхийг хөндсөн, эсхүл хуулиар тогтоосон журам зөрчсөн байх нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нараас гомдол гаргах үндэслэл болдог ажээ.

Өдгөө захиргааны хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гарсан гомдол гаргах эрхтэй шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хянаж байгаа бол иргэний хэргийн тухайд, ИХШХШТХ-н 170, 171

⁶ Азжаргал Т. нар, “Процессын эрх зүйн толь” гарын авлага Уб., 2014, 193 дахь тал

⁷ Улсын дээд шүүх, Хансс-Зайделийн сан “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар” Уб., 2012, 265 дахь тал

⁸ ХЗҮТ “Захиргааны хэргийн шүүхийн баримт бичиг” Уб., 2005, 15 дахь тал



дүгээр зүйлд зааснаар тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй хянан шийдвэрлэж тогтоол гаргах бөгөөд уг тогтоол нь эцсийн шийдвэр болж байна.

III. Захиргааны хэргийн шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргахтай холбоотой эрх зүйн зохицуулалт, практикт тулгамдаж буй зарим асуудал

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн /цаашид ЗХШХШТХуулийн гэх/ 122 дугаар

зүйлийн 122.1. дэх хэсэгт “Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 14.6, 32.6, 54.2, 61.1, 65.1, 111.3, 119.6, 123.7 дахь хэсэгт заасан болон гуравдагч этгээдийг оролцуулахаас татгалзсан тухай шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд бичгээр гарсан өдрөөс нь хойш долоо хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.”, 122.2. дахь хэсэгт “Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 122.1-д зааснаас бусад шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхгүй.” гэж заасан.

Хуулийн дээрх заалтад дурдсан гомдол гаргах эрх бүхий хуулийн заалтыг дэлгэрүүлэн үзвэл:

№	ЗХШХШТХ-н зүйл, хэсэг	Хуулийн зохицуулалт
1.	14.6	Энэ хуулийн 14.1-14.4-т заасан хугацаа зайлшгүй хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтэрсэн бол хүн, хуулийн этгээд, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх эрх бүхий этгээд хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт тухайн захиргааны хэргийн шүүхэд гаргаж болох бөгөөд шүүгч уг хугацааг хэтэрснээс хойш гурван жилийн дотор нөхөн сэргээж болно.
2.	32.6	Захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд уг баримтыг шаардан гаргуулж болохгүй.
3.	54.2	Нэхэмжлэлийг энэ хуулийн 54.1-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзахдаа шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, уг нэхэмжлэлийг дахин гаргах, эсхүл хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж, нэхэмжлэлийг буцаана.
4.	61.1	Энэ хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ.
5.	65.1	Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараах тохиолдолд шүүгч захирамж, шүүх тогтоол гарган түдгэлзүүлнэ:
6.	111.3	Энэ хуулийн 111.1-д заасны дагуу гаргасан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол илт үндэслэлгүй бол уг захирамж, тогтоолыг гаргасан шүүгч, шүүх бүрэлдэхүүн хүчингүй болгох, эсхүл өөрчилж болно.
7.	119.6	Энэ хуулийн 119.5-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтийг анхан шатны шүүхэд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсхийг шүүгч захирамж гарган шийдвэрлэнэ.



8.	123.7	Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 119.5-д заасан хугацааг хүндэтгэн үзэх шалтгаанаар хэтрүүлсэн бол хугацаа сэргээлгэх хүсэлтээ холбогдох нотлох баримтын хамт анхан шатны шүүхэд гаргах бөгөөд хүсэлтийг хангах эсэхийг шүүгч тухайн хүсэлтэд хавсаргасан баримтын хүрээнд захирамж гарган шийдвэрлэнэ.
9.		Гуравдагч этгээдийг оролцуулахаас татгалзсан /ЗХШХШТХ-н 22/

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад дээрх хуулийн зохицуулалтад хамаарах хүсэлтийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд бичгээр гарсан өдрөөс хойш долоо хоногийн дотор хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гомдол гаргах эрхтэй байхаар хуульчилжээ.

Улмаар энэ төрлийн гомдлыг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар анхан шатны шүүхээр дамжуулан гаргаж, анхан шатны шүүхээс давж заалдах шатны шүүхэд хүргүүлж давж заалдах журмаар хянах ажиллагаа хийгдэж байна.

Монгол Улсын Шүүхийн шүүн таслах ажиллагааны мэдээнээс үзэхэд, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2016 онд нийт хянан шийдвэрлэсэн 1460 хэргээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан 823 хэрэг, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан 573 хэрэг, 2017 онд нийт хянан шийдвэрлэсэн 1668 хэргээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан 923 хэрэг, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан 649, 2018 онд нийт хянан шийдвэрлэсэн 1382 хэргээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан 687 хэрэг, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан 594, 2019 онд нийт хянан шийдвэрлэсэн 1416 хэргээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан 718, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг

хянасан 591, 2020 онд нийт хянан шийдвэрлэсэн 1476 хэргээс анхан шатны шүүхийн шийдвэрийг хянасан 662, шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжийг хянасан 686 хэрэг⁹ байгаа нь дунджаар нийт шийдвэрлэсэн хэргийн 43 хувийг эзэлж байна.

Судлаачийн зүгээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гомдол гаргах эрх бүхий дээрх хуулийн зохицуулалтаас зарим зохицуулалтыг тусгайлан авч, шүүхийн практиктай харьцуулан судлахыг зорилоо. Тодруулбал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.6., 54.2., 61.1., 65.1. дэх хэсэгт заасан асуудлыг шийдвэрлэсэн шүүхийн тогтоол, шүүгчийн захирамжид гомдол гаргах ажиллагаа, шүүгчийн шийтгэвэр /шүүх тогтоол/, түүнд гомдол гаргах ажиллагаа, мөн тусгай журмаар /ЗХШХШТХ-ийн 112.4/ хянан шийдвэрлэж буй хэрэгт шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах ажиллагааны талаар авч үзнэ.

/Жич: Шүүхийн практик судлах энэхүү хэсэгт Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоолын сан болон Захиргааны хэргийн бүртгэл хяналтын нэгдсэн системийг ашигласан бөгөөд тухайн маргаан бүхий кейст дурдагдсан хэргийн оролцогч нарын мэдээллийн

⁹ https://admincourt2.gov.mn/site/full_story/2339 сүүлд үзсэн 2022.06.20



нууцалсан ба уг судалгааг зөвхөн энэхүү илтгэлд зориулан эрдэм шинжилгээний зорилгоор ашигласан болохыг тэмдэглэв./

1. ЗХШХШТХуулийн 32 дугаар зүйлийн 32.6 дахь хэсэгт “Захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас **хасах бөгөөд** уг баримтыг шаардан гаргуулж болохгүй.” гэж заасан.

Дээрх хуулийн заалтын агуулгаас үзвэл шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасна, улмаар энэ төрлийн баримтыг шаардан гаргуулж болохгүй гэсэн утгыг агуулжээ.

Өөрөөр хэлбэл шүүхээс “нотлох баримт хасуулах” тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн тохиолдолд, мөн нотлох баримт гаргуулах “ тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдолд ЗХШХШТХуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт зааснаар гомдол гаргах боломжтой гэж ойлгож болохоор байна.

Харин шүүхийн практикт, “нотлох баримт хасуулах” болон “нотлох баримт гаргуулах” тухай хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэнээс үл хамааран гомдол гаргах эрхтэй мэт ажиллагаа хийгдэж байна. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн тогтоолын сангаас үзэхэд нотлох баримт хасуулах хүсэлтийг хангасан болон хэрэгсэхгүй болгосон тохиолдлын аль алийг хянажээ.¹⁰

¹⁰ <http://www.togtool.court.gov.mn/iadmin/?menu=15&vsetWidth=1920&vsetheight=1040> сүүлд үзсэн 2022.06.20

Харин нотлох баримт гаргуулах хүсэлтийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг хянасан зарим тохиолдлоос товч дурдвал,

Иргэн “Э”-гийн нэхэмжлэлтэй, Нийслэлийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт нэхэмжлэгчээс гаргасан нэхэмжлэлийн нэмэгдүүлсэн шаардлага болон нотлох баримт гаргуулах тухай хүсэлтийг анхан шатны шүүх хүлээн авч, хангаж шийдвэрлэсэн байна. Энэхүү шүүгчийн захирамжийг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч эс зөвшөөрч гомдол гаргаж, улмаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2020 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн **** дугаар тогтоолоор “ ... хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчийн “нотлох баримт гаргуулах” хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамж хууль зөрчөөгүй байна ...” гэж дүгнэн шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхиж шийдвэрлэжээ.¹¹ Мөн өөр хэрэгт анхан шатны шүүхээс “нотлох баримт гаргуулах” тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг 2020 оны 3 дугаар сарын 24-ний өдрийн **** дугаар тогтоолоор хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхижээ.¹² Энэ мэтчилэн “нотлох баримт гаргуулах” тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн тохиолдолд гомдол гаргах, гомдлыг давж заалдах шатны шүүх хянах шүүхийн практик байна.

¹¹ <http://www.togtool.court.gov.mn/iadmin/?menu=15&vsetWidth=1920&vsetheight=1040> сүүлд үзсэн 2022.06.20

¹² <http://www.togtool.court.gov.mn/iadmin/?menu=15&vsetWidth=1920&vsetheight=1040> сүүлд үзсэн 2022.06.20



Мөн өөр нэг хэрэгт нотлох баримт гаргуулах тухай хүсэлтийг хангасан шүүгчийн захирамжийг давж заалдах шатны шүүх хянахдаа “... Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.6-д “Захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй, нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд уг баримтыг шаардан гаргуулж болохгүй” гэж заасан бөгөөд мөн хуулийн 32 дугаар зүйлийн 32.1-д заасны дагуу шүүх хэрэгт хамааралтай нотлох баримтыг цуглуулах үүрэгтэй. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д “Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн ... 32.6, ... дахь хэсэгт заасан ... шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд бичгээр гарсан өдрөөс нь хойш долоо хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно” гэж тус тус заасныг **шүүх нотлох баримт гаргуулах хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдолд уг захирамжид гомдол гаргах эрхтэй**, харин нотлох баримт гаргуулах хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн болон өмнө уг хүсэлтийг шийдвэрлэсэн үндэслэлээр хүсэлтийг хангахаас татгалзсан шүүгчийн захирамжид гомдол гаргах эрх олгогдоогүй гэж ойлгоно.

Иймд нэхэмжлэгчийн төлөөлөгч *****нараас гаргасан гомдол болон гуравдагч этгээдийн өмгөөлөгч **** нараас гаргасан нотлох баримт гаргуулах хүсэлтийг ханган шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийн холбогдох хэсэгт гаргасан гомдлыг давж заалдах

шатны шүүх хянах боломжгүй тул буцаав.

Цаашид **нотлох баримт гаргуулах хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн** болон хамтран хариуцагчаар оролцуулах хүсэлтийг шийдвэрлэсэн **шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг анхан шатны шүүх анхаарвал зохино ...**” гэх байдлаар дүгнэн гомдлыг буцаажээ.¹³

Судлаачийн зүгээс ЗХШХШТХуулийн 32 дугаар зүйлийн 32.6., 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасан зохицуулалтыг шүүхийн практикт “нотлох баримт хасуулах” тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн, мөн “нотлох баримт гаргуулах” тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдолд давж заалдах шатны шүүхэд гаргах эрхгүй байхаар хэрэглэх нь зүйтэй гэж үзлээ.

Өөрөөр хэлбэр, ЗХШХШТХуулийн 32 дугаар зүйлийн 32.6. дахь хэсэгт заасан хүсэлтийг шийдвэрлэсэнтэй холбоотой асуудлаар мөн хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт зааснаар гомдол гаргах ажиллагааг зөвхөн “нотлох баримт хасуулах” тухай хүсэлтийг хангасан, мөн “нотлох баримт гаргуулах” тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүгчийн захирамж /шүүхийн тогтоол/-ийн хүрээнд хамааруулан үзэх боломжтой гэж үзэж байна.

Учир нь анхан шатны шүүхээс нэгэнт тухайн нотлох баримтыг хасаагүй эсхүл нотлох баримтыг цуглуулах тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн тохиолдолд шүүх

¹³ <http://www.togtool.court.gov.mn/iadmin/?menut=15&vsetwidth=1920&vsetheight=1040>
сүүлд үзсэн 2022.06.20



шийдвэр гаргахдаа тухайн нотлох баримтыг хэрхэн үнэлсэн талаар тайлбарлах, хэргийн оролцогч нарын шаардлага ба татгалзлын үндэслэлтэй холбогдож буй эсэхэд дүгнэлт хийх боломжтой юм. Улмаар энэ асуудалд давж заалдах болон хяналтын шатны шүүх ч дүгнэлт өгөх эрх хэмжээтэй билээ.

2. ЗХШХШТХуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт “Нэхэмжлэлийг энэ хуулийн 54.1-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзахдаа шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, уг нэхэмжлэлийг дахин гаргах, эсхүл хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж, нэхэмжлэлийг буцаана.” гэж заасан.

Шүүхийн практикт хариуцагч, түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч, өмгөөлөгч, гуравдагч этгээд түүний төлөөлөгч, өмгөөлөгч нараас нэхэмжлэгчийн шүүхэд гаргасан нэхэмжлэлийг дээрх хуулийн 54 дүгээр зүйлийн 54.1.1-54.1.8-д заасан аль нэг үндэслэлийг дурдаж нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай хүсэлт гаргах тохиолдол цөөнгүй¹⁴ байна. Улмаар шүүхээс тухайн хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдолд гомдол гаргах эрхгүй гэж заасан хэдий ч шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд давж заалдах журмаар гомдол гаргаж / ЗХШХШТХуулийн 122.5/ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах

/хүндрэл үүсгэх/ тохиолдол гарч байна.

Гэтэл ЗХШХШТХуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт “Нэхэмжлэлийг энэ хуулийн 54.1-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзахдаа шүүгч захирамж гарган татгалзсан шалтгааныг зааж, уг нэхэмжлэлийг дахин гаргах, эсхүл хүлээн авахад саад болж байгаа зөрчлийг хэрхэн засахыг зааж, нэхэмжлэлийг буцаана.” гэж зааснаас үзвэл тус хуулийн 54.1-д заасан үндэслэл тогтоогдож, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсан тохиолдолд л мөн хуулийн 122 дугаар зүйлийн 122.1. дэх хэсэгт зааснаар тухайн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхтэй байхаар зохицуулсан заалт юм.

Өөрөөр хэлбэл, энэ тохиолдолд анхан шатны шүүхийн шүүгчээс нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нөхцөл тогтоогдоогүй гэж үзсэн, ЗХШХШТХуулийн 54 дүгээр зүйлийн 54.2-т заасан шийдвэр гаргаагүй байгаа нөхцөлд шүүгчийн захирамжийн энэ хэсэгт гомдол гаргах эрхгүй байна.

Мөн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүгчийн захирамжийг ЗХШХШТХуулийн 122 дугаар зүйлийн 122.5-д заасан үндэслэлд хамааруулан ойлгох боломжгүй бөгөөд уг заалтаар давж заалдах журмаар гомдол гаргах нь үндэслэлгүй билээ.

Анхан шатны шүүх ч энэ үндэслэлээр гаргасан хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн гомдлыг хүлээн авах,

¹⁴ Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн 2021.11.04-ний 1965 дугаартай “Гомдлыг буцаах тухай” шүүгчийн захирамж, 2021.12.01-ний өдрийн 2149 дугаартай “Гомдлыг буцаах тухай” шүүгчийн захирамж, 2022.03.18-ны өдрийн 0653 дугаартай “Гомдлыг буцаах тухай” шүүгчийн захирамж гэх мэт.



давж заалдах шатны шүүхэд хүргүүлэх шаардлагагүй гэж үзэж байна.

3. ЗХШХШТХуулийн 61 дүгээр зүйлийн 61.1. дэх хэсэгт “Энэ хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ” гэж заасан.

Онолын хувьд, “Захиргааны актыг биелэлтийг түдгэлзүүлэх” ажиллагаа нь нэхэмжлэгчийн нөхөн сэргээгдэхгүй, мөнгөөр илэрхийлэгдэхгүй эрхийн зөрчил, эсхүл түүнд тайлбаргүй тулгамдсан бөгөөд засагдахгүй хор хохирлын хувьд захиргааны хэрэг үүсгэснээр маргаж буй актын биелэлтийг даруй зогсоож эрхийн яаралтай хамгаалалт тогтоох, харин мөнгөн дүнгээр илэрхийлж болох эрхийн зөрчлийн тухайд, нийтийн эрх ашигт сөрөг нөлөөтэй гэх мэт тодорхой тохиолдолд актыг түдгэлзүүлэхгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлээд эцэст нь нэхэмжлэл хангагдсан тохиолдолд зөрчигдсөн эрхийг өөр бусад байдлаар сэргээх боломжтой байдлаар зохицуулах нь “хүний эрхийг захиргааны үйл ажиллагаанаас хамгаалах” захиргааны процессын эрх зүйн зорилгод нийцсэн хандлага юм.¹⁵

Шүүхийн практикт маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүсэлтийг “хангасан” болон “хэрэгсэхгүй болгосон” тохиолдлын аль алинд нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч гомдол гаргах боломжтой, түүнийг давж заалдах

¹⁵ Цогт Ц., “Захиргааны хэргийн шүүх” УБ., 2019, 100 дахь тал

журмаар хянах ажиллагаа хийгдэж байна.¹⁶

Тухайлбал, иргэн “Г”-ийн нэхэмжлэлтэй, “А” аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт маргаан бүхий захиргааны актын биелэлтийг анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар түдгэлзүүлж шийдвэрлэжээ. Уг шүүгчийн захирамжийг хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч эс зөвшөөрч давж заалдах журмаар гомдол гаргасан байх бөгөөд давж заалдах шатны шүүхээс анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг хянаж, хэвээр үлдээж шийдвэрлэсэн байна. Мөн иргэн “Б”-гийн нэхэмжлэлтэй, “А” аймгийн Засаг даргад холбогдох захиргааны хэрэгт шүүхээс маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Энэхүү шүүгчийн захирамжийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хянаж хүчингүй болгожээ.¹⁷

Түүнчлэн “захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай” хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүгчийн захирамж /шүүхийн тогтоол/-ийн гомдлыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хүлээн авч /ЗХШХШТХуулийн 122.6 /шийдвэрлэх¹⁸

¹⁶ 2016 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд 3406 шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шүүх хуралдаанаар хянан шийдвэрлэсэн байх бөгөөд 8,6 хувь буюу 292 тогтоол нь хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн гаргасан захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх тухай хүсэлтийг шийдвэрлэсэн захиргааны шүүхийн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоол байна.

¹⁷ <http://www.togtool.court.gov.mn/iadmin/?menu=15&vsetwidth=1920&vsetheight=1040> сүүлд үзсэн 2022.06.20

¹⁸ <http://www.togtool.court.gov.mn/>



шүүхийн практик хэрэгжиж байна.

Гэтэл дээрх хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийн зохицуулалтын агуулгаас үзвэл мөн хуулийн 61.1. /Энэ хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр **захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ.**/-д заасан зохицуулалтаар шийдвэрлэсэн буюу захиргааны актын биелэлтийг “түдгэлзүүлсэн” шүүгчийн захирамжид л гомдол гаргах боломжтой гэж ойлгож болохоор байна.

Магадгүй дээрх агуулгын хүрээнд хуулийн заалтыг тайлбарлан шүүхийн практикт хэрэгжүүлсэн тохиолдолд уг асуудлаар давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах ажиллагааны хүрээ хязгаар багасах, шүүхийн ачаалал буурах, анхан шатны шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шуурхай явагдахад эергээр нөлөөлөх боломжтой юм.

4. ЗХШХШТХуулийн 65 дугаар зүйлийн 65.1. дэх хэсэгт “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараах тохиолдолд шүүгч захирамж, шүүх тогтоол гарган түдгэлзүүлнэ: ...” гэж заасан.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг хуульд заасан тодорхой үндэслэлүүдээр шүүгч захирамж, шүүх тогтоол гарган түдгэлзүүлнэ. Түдгэлзүүлсэн хугацаанд хэрэг хянан шийдвэрлэхтэй холбоотой ямар нэгэн ажиллагаа хийгдэхгүй¹⁹ байна.

Шүүхийн практикт хэргийн

оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нараас ЗХШХШТХуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1-65.1.7-д заасан үндэслэлийн аль нэгийг дурдаж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай хүсэлт гаргадаг. Үүнийг нь анхан шатны шүүх хүлээн авч, өөрийн эрх хэмжээний хүрээнд хүсэлтийг хангах эсэх талаар шүүгчийн захирамж / шүүхийн тогтоол/-аар шийдвэрлэдэг билээ.

Уг ажиллагаатай холбоотой шүүхийн практикийг дурдвал, “Н” ХХК-ийн нэхэмжлэлтэй, А аймгийн Ө сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд холбогдох захиргааны хэргийг Архангай аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 5 дугаар сарын 4-ний өдрийн **** дугаар захирамжаар түдгэлзүүлж шийдвэрлэжээ. Энэхүү шүүгчийн захирамжийг нэхэмжлэгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч эс зөвшөөрч давж заалдах журмаар гомдол гаргаж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс шүүгчийн захирамжийг хэвээр үлдээсэн байна.

Мөн иргэн “Л”-ийн нэхэмжлэлтэй, “А” аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст холбогдох захиргааны хэрэгт хариуцагчийн өмгөөлөгчөөс ЗХШХШТХуулийн 65.1.3-т заасан үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай хүсэлт гаргажээ. Уг хүсэлтийг тус шүүхийн шүүгчийн 2021 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн **** дугаар захирамжаар хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна. Улмаар хариуцагчийн өмгөөлөгчөөс дээрх захирамжийг эс зөвшөөрч давж заалдах журмаар

iadmin/?menut=15&vsetwidth=1536&vsetheight=824 сүүлд үзсэн 2022.06.20

¹⁹ Улсын дээд шүүх, Хансс-Зайделийн сан “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар” Уб., 2012, 165 дахь тал



гомдол гаргасан байх бөгөөд Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2021 оны 9 дүгээр сарын 2-ны өдрийн **** дүгээр тогтоолоор анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж, гомдлыг хангахгүй орхижээ.²⁰

Энэ мэтчилэн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай хүсэлтийг хангасан болон хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд давж заалдах журмаар гомдол гаргах, уг гомдлыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хянах ажиллагаа хийгдэж байсан.

Харин сүүлийн үед ЗХШХШТХуулийн 65 дугаар зүйлийн 65.1. дэх хэсэгт гомдол гаргах эрхийн зохицуулалтыг зөвхөн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн” тохиолдолд л хэрэглэхээр шүүхийн практик тогтож байна.

Тухайлбал, иргэн “Ж”-гийн нэхэмжлэлтэй, “А” аймгийн Нийгмийн даатгалын хэлтэст холбогдох захиргааны хэрэгт нэхэмжлэгчийн өмгөөлөгчөөс гаргасан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх тухай хүсэлтийг анхан шатны шүүх хэрэгсэхгүй болгож, уг захирамжид давж заалдах журмаар гомдол гаргах эрхгүй талаар дурдаж шийдвэрлэжээ.

Гэвч нэхэмжлэгчийн өмгөөлөгч энэхүү захирамжид гомдол гаргах эрхгүй болохыг дурдсан шүүгчийн захирамжийг ЗХШХШТХуулийн 122.5 дахь хэсэгт заасан захирамжид хамаарна хэмээн маргаж, давж заалдах журмаар гомдол гаргасан

байна. Улмаар Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс “... нэхэмжлэгчийн өмгөөлөгчийн хүчингүй болгуулахаар гомдол гаргаж буй шүүгчийн захирамжаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.2-т “Энэ хуулийн 65.1-д зааснаас бусад шалтгаанаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэхийг хориглоно” гэж заасны дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн, энэ нь Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1-д заасан тохиолдолд хамаарахгүй, давж заалдах шатны шүүхийн хянах шүүгчийн захирамж биш байна.

Тодруулбал, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1-д “Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дараах тохиолдолд шүүгч захирамж, шүүх тогтоол гарган түдгэлзүүлнэ” гэж зааснаар давж заалдах шатны шүүх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн үр дагаврыг үүсгэсэн шүүгчийн захирамж, тогтоолыг л хянахаас биш энэ талаарх хүсэлтийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрийг хянах хууль зүйн үндэслэлгүй, уг захирамжид хэргийн оролцогчид гомдол гаргах эрхгүй юм ...” гэх үндэслэлээр гомдлыг буцааж шийдвэрлэсэн байна.²¹

Судлаачийн зүгээс дээрх агуулгаар уг хуулийн заалтыг тайлбарлаж байгааг дэмжиж байгаа бөгөөд гагцхүү хэргийн оролцогч, тэдгээрийн

²⁰ <http://www.togtool.court.gov.mn/iadmin/?menut=15&vsetwidth=1536&vsetheight=824> сүүлд үзсэн 2022.06.20

²¹ <http://www.togtool.court.gov.mn/iadmin/?menut=15&vsetwidth=1536&vsetheight=824> сүүлд үзсэн 2022.06.20



төлөөлөгч, өмгөөлөгч уг заалтыг өмнө хэрэглэж байсан агуулгаар ойлгох, маргаан үүсгэх, шүүхийг буруутгах зэрэг үл ойлголцол үүсч болзошгүй байгааг анхаарах нь зүйтэй.

Мөн энэхүү хэсэгт хамаарах хуулийн зохицуулалтыг “захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх” хүсэлтийг шийдвэрлэхэд адилтган үзэх, тайлбарлах боломжтой эсэх талаар цаашид судлах, хэрэв боломжтой бол шүүхийн практик тогтоох шаардлагатай байна.

5. ЗХШХШТХуулийн 83 дугаар зүйлийн 83.1. дэх хэсэгт “Хуульд заасан торгох шийтгэл оногдуулж болох зөрчлийг шүүх хуралдаан дээр гаргасан бол уг хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч шийтгэвэр, шүүх тогтоол гарган зөрчил гаргасан этгээдийг торгоно.” гэж заасан зохицуулалтын тухайд:

“Шийтгэвэр” гэж захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөрчил гаргасан этгээдэд хуульд заасны дагуу хариуцлага оногдуулсан шийдвэрийг ойлгохоор хуульчилсан.

Шүүгч, шүүх бүрэлдэхүүн хуульд заасан торгох шийтгэл оногдуулж болох зөрчлийг Зөрчлийн тухай хуулийн 15 дугаар зүйлд тусгасан байх бөгөөд шүүх хуралдааны танхимд шүүх хуралдаан хэвийн явагдах, хэргийн оролцогчдоос эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалах боломжийг алдагдуулах, саад хийх, шүүхийг үл хүндэтгэн гүтгэх, доромжлох, элдэв цээртэй үгээр хараах, сүрдүүлэх зэрэг үйлдэл гаргасан хэргийн оролцогч болон шүүх хуралдааны оролцогч, мөн шүүх хуралдааны танхимд байгаа

хөндлөнгийн сонирхогч этгээд зэрэг хүмүүст шүүх мөнгөн торгууль оногдуулна.²²

Шүүх хуралдааныг шүүгч дангаар хянан шийдвэрлэж байгаа бол шийтгэвэр, шүүх бүрэлдэхүүнтэй хэрэг хянан шийдвэрлэж байгаа бол шүүхийн тогтоолоор хуульд заасан хэмжээний дотор мөнгөн торгууль оногдуулна.

Зөвхөн 2020 оны шүүн таслах ажиллагааны мэдээнээс үзэхэд, 2020 онд Захиргааны хэргийн анхан шатны 3 шүүхэд, Иргэний хэргийн анхан шатны 5 шүүхэд шийтгэл оногдуулсан шийтгэврийг тус тус гарсан байгаагаас Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхээс Зөрчлийн тухай хуулийн 15.7 дугаар зүйл буюу Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах зөрчлөөр 51 шийтгэвэр гаргасан нь хамгийн өндөр дүнтэй байна. Иргэний хэргийн анхан шатны шүүх нь Зөрчлийн тухай хуулиас гадна Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 97 дугаар зүйлийн 97.1 болон 2 дахь хэсэгт зааснаар мөнгөн торгууль оногдуулж шийтгэл хүлээлгэсэн тохиолдлууд гарчээ. Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх тайлант хугацаанд 117 зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн байна гэх тоон үзүүлэлт гарсан байна.²³

Шүүхийн практикаас үзэхэд анхан шатны шүүхийн хувьд хуульд заасан үндэслэлээр шийтгэл оногдуулж шийтгэвэр /шүүхийн тогтоол/ гаргаж байна. Улмаар шийтгэвэрт зөрчил гаргасан этгээд давж заалдах

²² Улсын дээд шүүх, Хансс-Зайделийн сан “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар” У6., 2007, 262 дахь тал

²³ <https://court26.kho.gov.mn/news/604--2020-.html> сүүлд үзсэн 2022.06.20



журмаар гомдол гаргах, үүнийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хянан үзэх ажиллагаа хийгдэж байна.

Харин процессын хуулийн зохицуулалтаас үзвэл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 82 дугаар зүйлийн 82.4. дэх хэсэгт “Шүүх хуралдааны журам зөрчсөн этгээдэд эхний удаа хуралдаан даргалагч урьдчилан сануулна. Зөрчлийг дахин гаргасан этгээдийг хуралдаан даргалагчийн шийдвэрээр шүүх хуралдааны танхимаас гаргаж, энэ хуулийн 83 дугаар зүйлд заасан шийтгэл оногдуулна.”, 83 дугаар зүйлийн 83.1. дэх хэсэгт “Хуульд заасан торгох шийтгэл оногдуулж болох зөрчлийг шүүх хуралдаан дээр гаргасан бол уг хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч шийтгэвэр, шүүх тогтоол гарган зөрчил гаргасан этгээдийг торгоно.”, 83.2. дахь хэсэгт “Энэ хуулийн 83.1-д зааснаас бусад тохиолдолд торгох шийтгэл оногдуулах асуудлыг зөрчил гаргасан этгээдийг дуудан ирүүлж шийдвэрлэнэ. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр түүний ирээгүй явдал шийтгэвэр гаргахад саад болохгүй.” гэжээ.

Түүнчлэн Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 8.-д “Иргэний болон захиргааны хэргийн шүүхээр хэрэг, маргаан хянан шийдвэрлэх явцад Зөрчлийн тухай хуулийн 15.3, 15.4, 15.5, 15.7 дугаар зүйлд заасан зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд тухайн шүүх, ... шийтгэл оногдуулна.”, 2.1 дүгээр зүйлийн 2.-т “Захиргааны хэргийн шүүх энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14,

6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27, 6.28, 6.31 дэх заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрт гаргасан оролцогчийн гомдол, прокурорын дүгнэлтээр зөрчил хянан шийдвэрлэнэ.”, 7.6 дугаар зүйлийн 2.-т “Оролцогч энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.7, 6.10, 6.11, 6.12, 6.14, 6.15, 6.16, 6.17, 6.18, 6.19, 6.20, 6.21, 6.22, 6.23, 6.24, 6.25, 6.27, 6.28, 6.31 дэх заалтад заасан эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг эс зөвшөөрвөл Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан журмаар гомдол гаргаж шийдвэрлүүлнэ.” гэж тус тус заажээ.

Дээрх хуулийн зохицуулалтаас үзвэл шийтгэл оногдуулсан шийтгэвэрт гомдол гаргах эрхийг Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль болон холбогдох хуульд тодорхой заагаагүй, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах зохицуулалттай харьцуулахад боловсронгуй бус байна.

Гэтэл шүүхийн практикт шийтгэвэрт гомдол гаргах, түүнийг давж заалдах журмаар хянах ажиллагаа явагдаж байгаа бөгөөд анхан шатны шүүхийн шүүгч /шүүх бүрэлдэхүүн/-ийн шийтгэвэр /шүүхийн тогтоол/-ийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хянаж байна.²⁴ Тодруулбал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс ... зөрчилд оногдуулсан шүүгчийн шийтгэлийн хуудсыг давж заалдах

²⁴ <http://www.togtool.court.gov.mn/iadmin/?menu=15&vsetwidth=1920&vsetheight=1040> сүүлд үзсэн 2022.06.20



журмаар хянан хэлэлцэж, хүчингүй болгож шийдвэрлэсэн асуудал гарсаар байна.²⁵ Харин Улсын Дээд шүүхийн шүүгч /шүүх бүрэлдэхүүн/-ийн шийтгэврийг хэн, хэрхэн хянах нь тодорхойгүй байна.

Иймд нэгэнт шүүхийн практикт шийтгэвэрт гомдол гаргах эрхийг олгох нь зүйтэй гэж үзвэл ЗХШХШТХуульд шийтгэвэр, түүнд гомдол гаргах, хянах зохицуулалтыг нэмж тусгах, уг харилцааг хуульчлан зохицуулах зайлшгүй шаардлагатай юм.

6. Тусгай журмаар /ЗХШХШТХ-н 112.4/ хянан шийдвэрлэж буй хэрэгт шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах ажиллагааны тухайд:

ЗХШХШТХуулийн 112 дугаар зүйлийн 112.4. дэх хэсэг Дараах төрлийн маргааныг анхан шатны шүүх 30 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ: 112.4.1.-д “хуульд өөрөөр заагаагүй бол аймаг, сум, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн маргаан”, 112.4.2.-т “төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаатай холбоотой маргаан.”, 112.4.3.-т “хуульд тусгайлан заасан гомдлоор үүсэх хэрэг, маргаан” гэж заасан.

Мөн хуулийн 122 дугаар зүйлийн 122.4. дэх хэсэгт “Энэ хуулийн 112.1.3, **112.4**-т заасан маргааны хувьд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсанаас бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад

гаргах шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргахгүй.” гэж тусгайлан зохицуулжээ.

Харин шүүхийн практикт дээр дурдсан тусгай журмаар шийдвэрлэх маргааны явцад гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд давж заалдах журмаар гомдол гаргах эрхийг шүүх заах, эсхүл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчөөс гомдол гаргах тохиолдол гарсаар байна.

Тухайлбал, “Э” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Улаанбаатар хотын “Б” дүүргийн татварын хэлтсийн татварын улсын байцаагч “М”-д холбогдох захиргааны хэрэгт нотлох баримт гаргуулах тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэхдээ анхан шатны шүүх шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхийг олгожээ. Улмаар энэхүү шүүгчийн захирамжид холбогдуулан гаргасан гомдлыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх 2022 оны 4 дүгээр сарын 29-ний өдрийн **** дугаар шүүгчийн захирамжаар буцаасан байна. Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн захирамжид “... хуулиар гомдол гаргах эрх олгоогүй шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрх олгосон зөрчил гаргахгүй байхыг анхан шатны шүүх цаашид анхаарвал зохино...” гэж тэмдэглэсэн байна.

Мөн “Х” ХХК-ийн нэхэмжлэлтэй, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын улсын байцаагч “Э”-д холбогдох захиргааны хэрэгт шинжээч томилуулах тухай хүсэлтийг хангахаас татгалзаж шийдвэрлэсэн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжид нэхэмжлэгчийн

²⁵ Дуламсүрэн Н., “Шүүгч зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болох нь: эрх зүйн зохицуулалт анхаарах асуудал” ШЭМ сэтгүүл, УБ., 2019 №4



итгэмжлэгдсэн төлөөлөгч нараас давж заалдах журмаар гомдол гаргасан байх бөгөөд уг гомдлыг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх ЗХШХШТХуулийн 112 дугаар зүйлийн 112.4.-т заасан үндэслэлээр буцааж шийдвэрлэжээ.

Судалгааны явцад энэ мэт анхан шатны шүүхээс гомдол гаргах эрх олгосон, эсхүл эрх олгоогүй боловч хэргийн оролцогч нар гомдол гаргаж, гомдлыг давж заалдах шатны шүүх буцаасан тохиолдол цөөнгүй гарсан байна.

Иймд ЗХШХШТХуулийн 112 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт заасан гомдол гаргах эрхтэй асуудлыг шийдвэрлэсэн байх боловч тусгай журмаар шийдвэрлэх маргааны хувьд нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзсанаас бусад тохиолдолд шийдвэрлэсэн асуудлаар гарсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхгүй болохыг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүх анхаарах, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарт тайлбарлан таниулах шаардлагатай гэж үзлээ.

IV. Дүгнэлт, санал

Судлаачийн зүгээс энэхүү илтгэлээр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгийн зохицуулалт, түүний ойлголт хэрэглээг шүүхийн практикт нэгтгэх /сайжруулах/ замаар захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааг боловсронгуй болгоход ач холбогдол бүхий санал, дүгнэлт гаргахад чиглэсэн билээ.

Угаас шүүхийн практик, процессын хуулийн хэрэглээ ойлгомжтой, тодорхой байх нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа түргэн шуурхай явагдахад чухал үүрэгтэй бөгөөд тэр хэмжээгээр хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нарын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны талаарх ойлголт, соёл сайжрах, шүүхэд итгэх итгэл нэмэгдэх ач холбогдолтой.

Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нараас тодорхой төрлийн хүсэлтийг гаргадаг. Улмаар шүүгч /шүүх бүрэлдэхүүн/ тухайн хүсэлтийг хэргийн нөхцөл байдал, өөрийн бүрэн эрхийн хүрээнд хангах эсэх талаар шийдвэр гаргаж, уг шийдвэр нь шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолоор илрэн гардаг билээ. Тухайн шийдвэрийг хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч эс зөвшөөрвөл давж заалдах журмаар гомдол гаргах боломжтой бөгөөд ямар хүсэлтийг хэрхэн шийдвэрлэсэн тохиолдолд давж заалдах журмаар гомдол гаргаж болох талаар Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсгээр зохицуулжээ.

Гэвч шүүхийн практикт хуулийн дээрх заалтад дурдсан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах, түүнийг давж заалдах журмаар хянах ажиллагаанд дараах асуудлыг боловсронгуй болгох шаардлага үүсээд байна. Үүнд:

1. ЗХШХШТХуулийн 32 дугаар зүйлийн 32.6 дахь хэсэгт “Захиргааны хэргийн шүүх хэрэгт хамааралгүй,



нотолгооны ач холбогдолгүй, хуулиар зөвшөөрөгдөөгүй баримтыг хэргийн нотлох баримтаас хасах бөгөөд уг баримтыг шаардан гаргуулж болохгүй.” гэсэн хуулийн зохицуулалтыг шүүх практикт харьцангуй өөр өөр байдлаар тайлбарлан хэрэглэж байна.

Тухайлбал, нотлох баримт хасуулах тухай хүсэлтийг хэрхэн шийдвэрлэснээс үл хамааран давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах, нотлох баримт гаргуулах хүсэлтийн тухайд зарим тохиолдолд хангасан болон хэрэгсэхгүй болгосон аль аль тохиолдолд, зарим тохиолдолд зөвхөн хэрэгсэхгүй болгосон тохиолдолд давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй мэтээр хэрэглэж байгаа нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд сөргөөр нөлөөлж хуулийг нэг мөр тайлбарлаж хэрэглэхэд хүндрэл үүсгэж байна.

Иймд ЗХШХШТХуулийн 32 дугаар зүйлийн 32.6., 122 дугаар зүйлийн 122.1. дэх хэсэгт заасан зохицуулалтыг шүүхийн практикт зөвхөн “нотлох баримт хасуулах” тухай хүсэлтийг хангасан, “нотлох баримт гаргуулах” тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүгчийн захирамж /шүүхийн тогтоол/-ийн хүрээнд хамааруулан ойлгож, гомдол гаргах эрхтэй байхаар хэрэглэх боломжтой юм.

Угаас анхан шатны шүүх нэгэнт тухайн нотлох баримтыг хасаагүй эсхүл нотлох баримтыг цуглуулах тухай хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн тохиолдолд шүүх шийдвэрээр тухайн нотлох баримтыг хэрхэн үнэлсэн талаар тайлбарлах, хэргийн оролцогч нарын шаардлага ба татгалзлын

үндэслэлтэй холбогдож буй эсэхэд дүгнэлт хийх боломжтой байна.

2. ЗХШХШТХуулийн 61.1. дэх хэсэгт зааснаар зохицуулагдаж буй “захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх” хүсэлтийг шийдвэрлэхдээ тухайн хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдолд давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй эсэхэд анхаарах шаардлагатай.

Учир нь ЗХШХШТХуулийн 61.1. дэх хэсэгт “61.1.Энэ хуулийн 62 дугаар зүйл, эсхүл хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд шүүгч хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтээр захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлнэ.” гэж заасан. Энэхүү заалтыг утгачлан үзвэл “захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх” гэсэн санаа агуулагдаж байна. Улмаар мөн хуулийн 122 дугаар зүйлийн 122.1. дэх хэсэгт “Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн ...61.1, ... дахь хэсэгт заасан болон гуравдагч этгээдийг оролцуулахаас татгалзсан тухай шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд бичгээр гарсан өдрөөс нь хойш долоо хоногийн дотор давж заалдах шатны шүүхэд гомдол гаргаж болно.” гэж зааснаас үзвэл зөвхөн захиргааны актын биелэлтийг “түдгэлзүүлсэн” шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд холбогдуулан давж заалдах шатны шүүхэд гомдол гаргах эрхтэй гэж ойлгож болох юм.

Нөгөөтээгүүр, шүүхээс нэгэнт тухайн маргаан бүхий захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх шаардлагагүй гэж үзсэн бол маргаан бүхий актын улмаас иргэн, хуулийн этгээдэд учрах хохирол, хор уршиг



нь нөхөн сэргэх боломжтой, үнэлж болохуйц байх нөхцөлийг хангасан гэж үзэх боломжтой юм. /Жишээ нь: ажлаас үндэслэлгүй халагдсантай холбоотой төрийн албаны маргааны хувьд гэх мэт/

Мөн уг асуудлыг ЗХШХШТХуулийн 65 дугаар зүйлийн 65.1. дэх хэсэгт гомдол гаргах зохицуулалттай адилтгах хэрэглэх боломжтой байна. Тодруулбал, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс зөвхөн “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн” шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд л гомдол гаргах эрхтэй, түүнийг давж заалдах шатны шүүх хянах боломжтой гэж тайлбарлаж байгаа тул энэхүү зохицуулалтыг “захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх” эсэх асуудлыг шийдвэрлэхэд адилтган тайлбарлаж болохоор байна.

Иймд цаашид хуулийн дээрх зохицуулалтыг хэрэглэхдээ “захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх” тухай хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдолд гомдол гаргах эрх олгох эсэх, процессын хуулийг нэг мөр тайлбарлаж хэрэглэхэд анхаарах нь зүйтэй.

3. ЗХШХШТХуулийн 83 дугаар зүйлийн 83.1. дэх хэсэгт “Хуульд заасан торгох шийтгэл оногдуулж болох зөрчлийг шүүх хуралдаан дээр гаргасан бол уг хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгч шийтгэвэр, шүүх тогтоол гарган зөрчил гаргасан этгээдийг торгоно.” хэмээн заасан. Энэхүү илтгэлийн үндсэн хэсэгт шүүгч шийтгэл оногдуулсан шийтгэвэр / тогтоол/ гаргах, түүнд давж заалдах журмаар гомдол гаргах ажиллагааны

талаар дэлгэрэнгүй авч үзсэн билээ.

Анхан шатны шүүхийн шийтгэвэрт гомдол гаргах, түүнийг Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүх хянан үзэх шүүхийн практик тогтсон боловч энэ нь процессын хуульд нарийвчлан зохицуулагдаагүй байна.

Өөрөөр хэлбэл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулиар зохицуулагдаагүй процессын харилцаа шүүхийн практикт явагдаж байна.

Гэтэл угаас хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж буй шүүгчид олгогдсон эрх хэмжээний хүрээнд гарсан “шийтгэвэр /тогтоол/”-ийг давж заалдах журмаар хянах нь оновчтой эсэх, шийтгэвэрт гомдол гаргах эрх олгох нь эргэлзээтэй асуудал хэвээр байна.

Нөгөөтээгүүр Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг болон бусад заалтаар шийтгэвэрт гомдол гаргах эрхийг тухайлан зохицуулаагүй, шийтгэвэр нь шүүхээс гарах эрхийн актын тусдаа төрөлд хамаарах бөгөөд мөн хуулийн 122.2. дахь хэсэгт “Хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч энэ хуулийн 122.1-д зааснаас бусад шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхгүй.” гэж заасан болохыг ч анхаарах шаардлагатай юм.

Хэрэв шийтгэвэрт гомдол гаргах, давж заалдах шатны шүүх хянах өнөөгийн шүүхийн практикийг цаашид хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзвэл процессын хуульд уг асуудлыг тусгах, гомдол гаргах эрхийг нэмж оруулах, Улсын дээд шүүхийн шүүгчийн шийтгэвэр, шүүхийн



тогтоолыг хэн хэрхэн хянах асуудалд ч мөн анхаарах нь зүйтэй.

4. Түүнчлэн ЗХШХШТХуулийн 54 дүгээр зүйлийн 54.2., 65 дугаар зүйлийн 65.1. болон тусгай журмаар шийдвэрлэж буй маргааны тухайд ч анхаарах зарим асуудлууд байна. Тухайлбал, хэрэг үүсгэсний дараа хариуцагч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нараас тухайн нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгох тухай хүсэлт гаргах тохиолдол байдаг. Энэ төрлийн хүсэлтийг шүүхээс хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдолд ЗХШХШТХуулийн 54 дүгээр зүйлийн 54.2 дахь хэсэгт заасан үндэслэлд хамаарахгүй тул давж заалдах гомдол гаргах эрхгүй юм. Гэтэл хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгч нар энэхүү зохицуулалтыг буруугаар ойлгох, гомдол гаргах эрх олгоогүй хэмээн маргах, үүнтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа удаашрах зэрэг нөхцөл үүсч байна. Мөн ЗХШХШТХуулийн 65 дугаар зүйлийн 65.1 дэх хэсэгт заасан хүсэлтийг хангаж шийдвэрлэсэн шүүгчийн захирамжид гомдол гаргах эрхгүй хэмээн давж заалдах шатны шүүх гомдлыг буцаах болсонтой холбогдуулан анхан шатны шүүх хүсэлтийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн тохиолдолд гомдол гаргах эрхгүй байхаар захирамжид заахад өмнө нь гомдол гаргах эрх олгодог байсан атлаа одоо процессын хуулийг өөрөөр тайлбарлаж байна зэргээр гомдол гаргах тохиолдол гарсаар байна. Түүнчлэн тусгай журмаар шийдвэрлэх маргааны хувьд нэхэмжлэлийг хүлээн авахаас

татгалзсанаас бусад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргах шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргахгүй гэж хуульчилсан боловч шүүхээс тухайн шийдвэрлэж буй хүсэлтэд хамаарах заалтын хүрээнд давж заалдах гомдол гаргах эрх олгох, эсхүл хэргийн оролцогч нар давж заалдах гомдол гаргах тохиолдол цөөнгүй гарчээ.

Иймд цаашид гомдол гаргах эрх олгосон шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын талаар тухайлсан судалгаа хийх, /дотоод/ сургалт зохион байгуулах, хэргийн оролцогч, тэдгээрийн төлөөлөгч, өмгөөлөгчийг мэдээллээр хангах, соён гэгээрүүлэх нэн шаардлагатай байна.

V. Ашигласан материал:

V.I. Хууль тогтоомжийн хүрээнд:

1. Монгол Улсын Үндсэн хууль 1992 он
2. Шүүх байгуулах тухай хууль 2002 он
3. Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
4. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2002 он
5. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль 2016 он
6. Захиргааны ерөнхий хууль 2015 он
7. Монгол Улсын Шүүхийн тухай хууль 2021 он

V.II. Ном, судалгааны бүтээл:

1. Б.Чимид., “Үндсэн хуулийн үзэл баримтлал” УБ., 2004 он
2. Б.Чимид Б., “Захиргааны



- хэргийн шүүхийн тухай мэдэгдэхүүн” УБ, 2004 он
3. ХЗҮТ “Захиргааны хэргийн шүүхийн баримт бичиг” УБ, 2005 он
 4. Улсын дээд шүүх, Хансс-Зайделийн сан “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар” УБ, 2012 он
 5. Улсын дээд шүүх, Хансс-Зайделийн сан “Захиргааны хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар” УБ, 2012 он
 6. А.Эрдэнэцогт “Монгол Улсын захиргааны процессын эрх зүй” УБ, 2012 он
 7. Ц.Амарсайхан нар, “Процессын эрх зүй онол, туршлага” УБ, 2014 он
 8. Т. Азжаргал нар, “Процессын эрх зүйн толь” гарын авлага УБ, 2014 он
 9. П.Одгэрэл “Захиргааны эрх зүйн ерөнхий анги” УБ, 2016 он
 10. Г.Банзрагч., “Захиргааны процессын эрх зүй” УБ, 2019 он
 11. Ц. Цогт., “Захиргааны хэргийн шүүх” УБ, 2019 он
 12. Н. Дуламсүрэн., “Шүүгч зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтан болох нь: эрх зүйн зохицуулалт анхаарах асуудал” ШЭМ сэтгүүл, УБ, 2019 №4
 13. Монгол Улсын Шүүхийн тайлан 2017, 2018, 2019, 2020, 2021



Abstract

THE ISSUE OF IMPROVING THE LEGAL REGULATIONS REGARDING WITH RIGHT TO APPEAL ON JUDGE'S ORDER AND DECREE OF THE ADMINISTRATIVE COURT

A.TUVSHINTULGA

*Judge on the Administrative Court of First Instance
in Arkhangai aimag (province) of Mongolia*

G.TSERENDEJID

*Judicial Assistant on the Administrative Court of First Instance
in Arkhangai aimag (province) of Mongolia*

In this paper has intended to study the legal regulations regarding with right to appeal on Judge's order and Decree of the Administrative Court and to consider issues which facing in judicial practice, and to make a specific suggestion and conclusion for its solution.

Keywords

Judicial power, judge, judge's order, court decree, right to appeal



**ШҮҮХЭД ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА:
БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ АЖИЛЛАГААНД
АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**

**PROCEEDINGS IN COURT: SOME ISSUES TO BE CONSIDERED
IN ARREST AND POLICE DETENTION**

Дашдоржийн АЗЖАРГАЛ¹

- I. Удиртгал
- II. Онолын үзэл баримтлал
- III. Тулгамдаж буй асуудал
- IV. Дүгнэлт
- V. Ном зүй

¹ Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны Ерөнхий шүүгч, Хууль зүйн магистр /LL.M./



**ШҮҮХЭД ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
АЖИЛЛАГАА: БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ
АЖИЛЛАГААНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ**

Д.АЗЖАРГАЛ Булган аймгийн Эрүү, Иргэний хэргийн давж заалдах шатны Ерөнхий шүүгч, Хууль зүйн ухааны магистр /LL.M./

Түлхүүр үг

Эрүүгийн шүүх, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа, эрх, эрх чөлөө, цагдан хорих, мөрдөгч, өмгөөлөгч, баривчлах

Хураангуй

Хүний халдашгүй, чөлөөтэй байх эрхийг хэн ч зөрчиж, үгүйсгэх эрхгүй бөгөөд хуулиар тогтоосон үндэслэл, журмын дагуу тодорхой тохиолдлуудад төр хязгаарладаг. Үндэслэлгүй хүнийг баривчилж, цагдан хорих нь хүний эрх болон олон гэрээ, конвенцыг ноцтой зөрчсөн хэрэг болно. Гэвч практик дээр гэмт хэргийг илрүүлэх, шалгах явцад хуулийн хийдлээс үүдэж, хүний эрхийг зөрчсөн тохиолдлууд гарч байна.

Энэхүү илтгэлээр шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: баривчлах, цагдан хорих ажиллагаанд анхаарах зарим асуудлын талаар судалгааны тайлан болон практикт нөхцөл байдлыг судалж, хуулийн байгууллагад ажиллаж байгаа ажилтан, судлаачдын дунд анкетын аргаар судалгаа явуулж, судалгаандаа үндэслэн судлаачийн зүгээс санал, зөвлөмжийг дэвшүүлсэн болно.

Нэг. Удиртгал

Хүн бүрт амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх зэрэг эрх бий. Энэ эрхийг хэн ч зөрчих, үгүйсгэх

эрхгүй боловч хууль зөрчсөн тохиолдолд зөвхөн төр хязгаарладаг. Манай улс Үндсэн хуулиараа хүний суурь эрхийг хамгаалж, үүргийг нь сахиулж, энэ талаарх харилцааг холбогдох хуулиараа зохицуулсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 13 дахь хэсэгт “халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч ... баривчлах, хорих ... эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно. ... Баривчилсан шалтгаан, үндэслэлийг баривчлагдсан хүн, түүний гэр бүлийнхэн, өмгөөлөгчид нь хуульд заасан хугацаанд мэдэгдэнэ. ...” хэмээн хуульчилсан нь хүний халдашгүй эрхийг баталгаажуулсан суурь зохицуулалт болсон бөгөөд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд тусгалаа олсон юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль нь нэг талаас хүн, нөгөө талаас төр буюу түүний хууль, хүчний байгууллага, эрх бүхий албан тушаалтан хоёрын дунд үүссэн харилцаанд хүний эрхийг хууль бусаар хязгаарлах, хууль бусаар баривчлах, хорих зэргээр дур зоргоор авирлахаас урьдчилан сэргийлэх, хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээх суурь зохицуулалт болдог.



Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны бүхий л шатанд үйл ажиллагааг хэрэгжүүлэгч албан хаагчид Үндсэн хууль болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан хүний халдашгүй эрхийг хангаж хамгаалах нь нэн чухал бөгөөд энэ талаарх асуудлыг судлан, олон улс, нийгэм цаг үеийн шинэчлэлийн хамт улам боловсронгуй болгох шаардлага тавигдаж байна.

Иймд энэхүү илтгэлээр эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх ажиллагаанд буюу хүнийг баривчлах, цагдан хориход тулгамдаж буй зарим асуудлыг хөндөж, энэ талаарх ойлголтыг нэгтгэх, практик дадлыг зөв төлөвшүүлэх, тулгамдаж буй асуудлыг тодорхойлон, шийдвэрлэх арга замыг санал болгон дэвшүүлсэн. Энэхүү сэдвийг судлахдаа дараах аргуудыг ашигласан болно. Үүнд:

Баривчлах, цагдан хорих тухай ойлголт түүхэн хөгжлийн асуудлыг судлахдаа түүхчлэх аргыг, энэ талаарх өмнөх хуулийн төсөөтэй талуудыг харьцуулан судалж, баривчлах, цагдан хорих ажиллагааг хэрэгжүүлэхэд Монгол Улсын эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн тулгамдаж буй асуудалд анализ дүгнэлт хийж судлахдаа харьцуулах аргыг, өнөөгийн шүүхийн практикийг судлахдаа статистик тоо баримт цуглуулах аргыг, дээрх судалгааны хүрээнд практикт тулгамдаж буй асуудлаар шүүгчдийн санал зөвлөмжийг судалснаар ярилцлагын аргыг, хуулийн зохицуулалттай уялдуулан практикт тулгамдаж буй асуудлыг судлах зорилгоор шүүгч, прокурор, иргэдээс санал асуулгын судалгаа хийснээрээ анкетын аргыг тус тус ашигласан болно.

Сэдвийн судлагдсан байдлын хувьд ХЭҮК-оос “Баривчлах, урьдчилан хорих байрны нөхцөл эрүү шүүлттэй холбогдох

нь”¹ гэсэн сэдвийн хүрээнд 2006 онд судалгааны тайлан гаргасан байна. Уг судалгааны тайлангаар баривчлах, хорих байрны нөхцөл хүний эрхийг хөндөж байгаа талаар авч үзсэн байна.

Мөн судлаач Ч.Ганболд “Эрүүгийн процесс дахь сэжигтний эрх зүйн байдлын зарим тулгамдсан асуудал”² эрдэм шинжилгээний өгүүллэгээрээ сэжигтний эрх, үүргийг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудлыг тодорхойлж, хуулийг боловсронгуй болгох талаар санал, зөвлөмж дэвшүүлсэн байна.

Харин баривчлах, цагдан хорих ажиллагааг боловсронгуй болгох талаар судалгааны өгүүллэг, нийтлэл хараахан байхгүй байна.

Хоёр. Онолын үзэл баримтлал

2.1. Баривчлах ажиллагааны тухай

Эрх зүйн онолын үүднээс баривчлах гэж албадан саатуулах, цагдан хорихын өмнө эрх зүйн зөрчил үйлдсэн болон үйлдсэн байж болзошгүй этгээдийн чөлөөтэй зорчих, бусадтай чөлөөтэй харьцах зэрэг чөлөөтэй байх наад захын хувийн эрх нь хязгаарлагдаж эрх бүхий албан тушаалтны хяналтад орсон үеэс эхлэн зохих байгууллагад хүргэх хүртэлх ажиллагааг хэлнэ. Доктор, профессор С.Жанцан “Гэмт хэрэг үйлдсэн сэжиглэгдэж байгаа этгээдийн гэмт хэрэг үйлдсэн эсэхийг тодруулах, түүнд цагдан хорихоор таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх үндэслэл байгаа эсэх зэрэг асуудлыг шийдвэрлэх зорилгоор хуулийн хүрээнд авч хэрэгжүүлдэг албадлагын арга хэмжээг баривчлалт гэнэ”³ гэж үзжээ.

¹ Хүний эрхийн Үндэсний Комисс: Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний тухай илтгэл 2006 (legaldata.mn)

² Чимэддагвын Ганболд: Эрүүгийн процесс дахь сэжигтний эрх зүйн байдлын зарим тулгамдсан асуудал (legaldata.mn)

³ С.Жанцан. Хууль зүйн сэтгэл судлал. УБ хот. 2001 он, 349 дэх тал



Харин монгол хэлний үгийн санд баривчлах гэдэг үгний илэрхийлж байгаа салаа утгаас эхтэй бөгөөд тухайн судлаач аль утга санааг гол болгосноос үүдэлтэй юм. Тодруулбал баривчлах гэдэг үг нь хүнийг сул дураар явуулж үл болох ба болгох, гянданд хорих гэсэн утгатай⁴. Өөрөөр хэлбэл хорих буюу хорихоос арай өөр байдлаар эрхийг хязгаарлах гэсэн хоёр утгыг илэрхийлдэг байна. Эрх зүйн зөрчил, ялангуяа гэмт хэрэг үйлдсэнд сэжиглэгдэж байгаа этгээд эсхүл оргон зугтсан сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, түүнчлэн хил зөрчигчийг баривчлах ажиллагаа нь хүний халдашгүй чөлөөтэй байхыг хязгаарлаж, цаашилбал амьд явах жам ёсны салшгүй эрхэд халдаж байдаг гэсэн дүгнэлт гарна.

Эрүүгийн хэргийн процессын эрх зүйн үүднээс эрүүгийн хэргийн процесс ажиллагааны явцад гэмт хэрэг үйлдсэн болох сэжигтэй этгээдийн чөлөөтэй байх халдашгүй эрх хязгаарлагдаж цагдаагийн ажилтан, мөрдөгчийн хяналтад орсон үеэс эхлэн эрүүгийн хэрэг үүсгэсэн прокурор, шүүгчээс тодорхой шийдвэр гаргах хүртэл түр хугацаагаар түүнийг эрх мэдэлгүй болгож байгаа төрийн албадлагын арга хэмжээг баривчлах гэнэ.

НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 1998.12.09-ний өдрийн 43/173 тогтоолоор батлагдсан “Аливаа хэлбэрээр саатуулагдсан болон хоригдсон хүмүүсийг хамгаалах зарчмуудын цогц” хэмээх олон улсын баримт бичигт “баривчлах” гэдэг үг нь эрх зүйн аливаа зөрчил үйлдсэнд сэжиглэгдсэн буюу эрх бүхий байгууллагын шийдвэрээр уг этгээдийг саатуулахыг хэлнэ” гэж заасан байдаг. Баривчлах ажиллагааг зөвхөн мөрдөгч хийхээр хуульчилсан тул мөрдөгчөөс өөр этгээд баривчлах ажиллагааг хэрэгжүүлэх

нь хууль бус юм⁵. Хүнийг хууль бусаар баривчлахыг⁶ хориглож манай улс Эрүүгийн хуулиар хамгаалсан.

Баривчлах ажиллагааг хэрэгжүүлэхэд өмгөөлөгч оролцуулах⁷ үндэслэл байвал, түүнчлэн тухайн этгээд өмгөөлөгч авсан, авах хүсэлт гаргасан тохиолдолд өмгөөлөгчийг заавал оролцуулна⁸. Баривчлагдсан, эсхүл яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудагдсан хүнийг сэжигтэн гэнэ. Сэжигтний эрхийг хуульд тусгасан байдаг⁹. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолтой танилцуулахаар дуудсан сэжигтэн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй, мэдэгдэх хуудсыг хүлээн авахаас татгалзсан нь түүнийг шүүхийн зөвшөөрлөөр баривчлах үндэслэл болно¹⁰. Мөрдөгч нь мөн хуульд заасан үндэслэл байгаа бол сэжигтнийг баривчлах шүүхийн зөвшөөрөл авах тухай саналыг прокурорт гаргаж, прокурор хүлээн авснаас хойш даруй уг саналыг прокурорын саналын хамт шүүхэд хүргүүлнэ¹¹. Шүүх нь прокурорын саналыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор сэжигтнийг баривчлах эсэхийг

⁵ ЭХХШТХ-ийн 6.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрэн сурвалжлах, мөрдөн шалгах ажиллагааг харьяаллын бус мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллагаар хийлгэх шаардлага гарвал мөрдөгч энэ тухай саналаа прокурорт гаргана. Прокурорын даалгаврыг хүлээн авсан тухайн мөрдөн шалгах ажиллагааг явуулах байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамт прокурорт хүргүүлнэ” гэсэн нь эрэн сурвалжлах ажиллагаагаар хязгаарлагдах ба баривчлах ажиллагаа хийх эрхийг олгоогүй байна.

⁶ 13.9 дүгээр зүйл. Хууль бусаар баривчлах, саатуулах

⁷ ЭХХШТХ-ийн 5.3 дугаар зүйл

⁸ ЭХХШТХ-ийн 5.1 дүгээр зүйлийн 2.12-т “Сэжигтнийг баривчлах, яллагдагч, шүүгдэгчийг цагдан хорих, бусад таслан сэргийлэх арга хэмжээтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцох”

⁹ ЭХХШТХ-ийн 31.8 дугаар зүйл

¹⁰ ЭХХШТХ-ийн 31.2 дугаар зүйл

¹¹ ЭХХШТХ-ийн 4.1, 31.4 дүгээр зүйлүүд

⁴ Я.Цэвэл. МХТТТ. УБ хот. 1966 он, 76 дахь тал



шийдвэрлэнэ. Шүүхийн зөвшөөрлөөр баривчилж саатуулах хугацаа 48 цагаас хэтэрч болохгүй. Мөрдөгч нь сэжигтнийг дараах тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй баривчлах эрхтэй¹². Үүнд:

- гэмт хэрэг үйлдэж байх үед, эсхүл үйлдсэн дор нь барьсан;
- энэ хуульд заасан хойшлуулшгүй¹³ тохиолдолд;
- гэмт хэрэг үйлдсэн гэж гэрч, хохирогч шууд заасан;
- тухайн хүний хувцас, бие, орон байр, эд зүйл, тээврийн хэрэгсэлд гэмт хэргийн ул мөр илэрсэн.

Мөрдөгч сэжигтнийг баривчилсан даруй¹⁴ прокурорт мэдэгдэж, прокурор шийдвэрийг шүүхэд даруй хүргүүлнэ. Шүүх 24 цагийн дотор шийдвэрлэнэ. Мөрдөгч сэжигтнийг баривчилснаас хойш 6 цагийн дотор түүний хувийн байдлыг тогтоох, мэдүүлэг авах ба мэдүүлэг авахын өмнө сэжигтэнд ямар хэрэгт хологдуулан мэдүүлэг авч байгаа талаар танилцуулж, эрхийг тайлбарлана¹⁵, мөн хугацаанд тухайн сэжигтнийг баривчилсан талаар түүний гэр бүлийн арван найман насанд хүрсэн гишүүн, эсхүл өмгөөлөгч, гадаад улсын иргэн бол тухайн улсын Дипломат төлөөлөгчийн газарт мэдэгдэнэ. Мөрдөгч сэжигтнийг баривчлахдаа тэмдэглэл үйлдэн бэхжүүлэх ба тэмдэглэлийг баривчлах ажиллагааны үед үйлдэх боломжгүй байсан бол тухайн ажиллагааг дууссанаас хойш даруй нөхөн үйлдэнэ¹⁶.

Сэжигтний сонгон авсан өмгөөлөгч 2 цагийн дотор хүрэлцэн ирээгүй, эсхүл

¹² ЭХХШТХ-ийн 31.5 дугаар зүйл

¹³ ЭХХШТХ-ийн 1.4 дүгээр зүйлийн 1.26 “хойшлуулшгүй тохиолдол” гэж хүний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд ноцтой хохирол учрах, сэжигтэн, яллагдагч оргон зайлах, хэргийн ул мөр, эд мөрийн баримт устах, зөөвөрлөх, нуун далдлах, үрэгдэх бодит аюул байгааг”

¹⁴ Мөн зүйлийн 1.7 “даруй” гэж боломжит богино хугацааг

¹⁵ Мөн хуулийн 31.11 дүгээр зүйл

¹⁶ ЭХХШТХ-ийн 31.7 дугаар зүйл

өмгөөлөгч авахаас татгалзсан бол энэ хуулийн 5.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу өмгөөлөгч оролцуулна. Хуульд зааснаас бусад тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй, эсхүл шүүхийн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар баривчлагдсан, цагдан хоригдож байгаа хүнийг прокурор даруй суллана. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлагдсан сэжигтнийг хуульд заасан үндэслэлээр шүүгч суллах шийдвэр гаргана /31.12/, Баривчилснаас хойш 48 цаг дуусаж, сэжиглэгдэж байгаа хүнд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах прокурорын шийдвэр, цагдан хорих шүүхийн шийдвэр ирээгүй бол баривчлах байрны дарга мөрдөгч, прокурор, шүүгчид мэдэгдэж, түүнийг суллана.

Хуульд зааснаар зайлшгүй баривчлах үндэслэл бий болоогүй, хуульд заасан баривчлах процессыг зөрчсөн зэрэг нь тогтоогдсон тохиолдолд хууль бусаар баривчлагдсан сэжигтнийг прокурор даруй суллана /31.5-6/. Хүнийг баривчлах үед түүнд баривчилсан шалтгаан, үндэслэлийг мэдэгдэж, өмгөөлөгч авах, өөрийгөө өмгөөлөх, шүүхэд гомдол гаргах, өөрийнхөө эсрэг мэдүүлэг өгөхгүй байх эрхийг сануулах ба энэ талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дахь хэсэг, 5.2 дугаар зүйлийн 2.1, 2.5, 2.12 дахь хэсгүүд, 5.3 дугаар зүйл, 7.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 31.4-өөс 31.12 дугаар зүйлүүдэд тусгасан байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.7 дугаар зүйлийн 1-т “Баривчлагдсан сэжигтэн, цагдан хоригдсон яллагдагч, шүүгдэгч нь түүнийг баривчилсан, цагдан хорьсон нь хууль ёсны эсэхийг шүүхээр хянуулах, хууль бусаар баривчилсан цагдан хорьсон бол суллуулахаар шүүхэд гомдол гаргах эрхтэй” гэж заасан. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.9



дүгээр зүйлд баривчлах хугацааг тоолох талаар зохицуулсан. Баривчилж байгаа тохиолдолд сэжигтэнд баривчлах тухай шүүхийн шийдвэрийг танилцуулсан үеэс баривчилсан хугацааг тоолохоор хуулийн 31.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан. Шүүхийн зөвшөөрөлгүй баривчилсан тохиолдолд ямар гэмт хэрэгт сэжиглэж байгаа, хууль зүйн туслалцаа авах эрхтэй болох, сэжигтний хийсэн үйлдэл, хэлсэн үг өөрийнх нь эсрэг шүүхэд нотлох баримт болохыг анхааруулж, хууль ёсны шаардлагыг биелүүлэхгүй бол холбогдох хуульд заасны дагуу албадлага хэрэглэхийг сануулсан үеэс буюу эдгээр эрхийг танилцуулсан үеэс баривчилсан хугацааг тоолохоор хуульчилсан байна.

Монгол Улсын хэмжээнд 2018 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 116 сэжигтнийг баривчлах тухай материал хүлээн авснаас 87 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 29 сэжигтэнд баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ¹⁷. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтнийг баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоог өмнөх онтой харьцуулбал 462 хүн буюу 79.9 хувиар, баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо 409 хүн буюу 82.5 хувиар, баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо 52 хүнээр буюу 64.2 хувиар тус тус буурсан байна. 2019 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад сэжигтнийг баривчлуулахаар тогтоол үйлдэж ирүүлсэн хүний тоог өмнөх онтой харьцуулбал 116 хүнээр буюу 2 дахин, баривчлах зөвшөөрөл олгосон хүний тоо 100 хүнээр буюу 2.1 дахин, баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзсан хүний тоо 16 хүнээр буюу 1.6 дахин өссөн байна.

¹⁷ Монгол Улсын Шүүхийн 2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан

Харин 2020 онд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйлд заасан үндэслэлээр 178 сэжигтнийг баривчлах тухай материал хүлээн авснаас 148 сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгож, 30 сэжигтэнд баривчлах зөвшөөрөл олгохоос татгалзжээ¹⁸. 2020 оны байдлаар шүүхийн шийдвэргүйгээр буюу мөрдөн байцаагч, прокурорын тогтоолоор хойшлуулшгүй ажиллагааны явцад баривчилсан 8 тохиолдол гарсан¹⁹.

2.2. Цагдан хорих ажиллагааны тухай

Таслан сэргийлэх арга хэмжээг эрүүгийн гэмт хэрэг үйлдсэн этгээдэд зөвхөн хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд хэрэглэх бөгөөд таслан сэргийлэх арга хэмжээ авах үндэслэл гэдэгт яллагдагчид таслан сэргийлэх арга хэмжээний аль нэг төрлийг зайлшгүй авах шаардлагатай болохыг бодитойгоор нотолсон баримт сэлт, мэдээлэл хамаарна.

2017 оны ЭХХШТХ-ийн арван дөрөвдүгээр бүлгийн 14.1.1 дэх хэсэгт “Яллагдагч, шүүгдэгчид энэ хуульд заасан үндэслэл, журмын 6 төрлийн таслан сэргийлэх арга хэмжээ авна”²⁰ гэж заажээ. Дээрх арга хэмжээний хамгийн хүнд нь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ бөгөөд энэ нь яллагдагчийг гагцхүү хуульд заасан үндэслэл байгаа тохиолдолд мөрдөгч, прокурорын санал болгосноор шүүгчийн захирамжаар хуульд заасан хугацаанд нийгмээс тусгаарлаж, Үндсэн хуульд заасан эрх, эрх чөлөөний зарим хэсгийг тодорхой хугацаагаар хязгаарлаж байгаа албадлагын арга хэмжээ юм.

¹⁸ Монгол Улсын Шүүхийн 2020 оны шүүн таслах ажиллагааны тайлан

¹⁹ ХЭҮК-ын тайлан, 2020 он

²⁰ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль.2017. Төрийн мэдээлэл №23



2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуулиар цагдан хорих арга хэмжээ авах үндэслэл нь оргон зайлж болзошгүй, дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй, хэрэг шалгах ажиллагаанд саад хийж болзошгүй зэрэг бодит бус харьцангуй хийсвэр үндэслэлээр цагдан хорьдог байсныг шинэ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар өөрчлөхийг оролдсон. 2002 оноос өмнө сэжигтэн, яллагдагчийг цагдан хорих асуудал нь мөрдөн байцаагч тогтоол үйлдэж прокурор баталснаар хэрэгждэг байсан бол өнөөдөр зөвхөн шүүхийн зөвшөөрлөөр буюу шүүхийн хэлэлцүүлгээр цагдан хорих, суллах, хугацааг сунгах эсэх асуудлыг шийдэж байгаа нь олон улсын жишигт нийцэж байна. Хүнийг хууль бусаар хорьж халдашгүй эрхийг зөрчсөн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан²¹.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хүнийг аль болох цагдан хорихгүй байхыг чухалчилж, хорих үндэслэлүүдийг тодорхой болгосон төдийгүй цагдан хорих үндэслэлгүй тохиолдолд бусад таслан сэргийлэх арга хэмжээг авахаар зохицуулсан. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэлэлцүүлэг /шүүх хуралдаан/ хийсний үндсэн дээр шүүх хуульд заасан үндэслэлийн аль нэг нь байвал яллагдагчийг цагдан хорих шийдвэр гаргана. /14.9, 14.13/.

Яллагдагчийг цагдан хорих хугацаа 1 сар байх ба хэргийн ээдрээ төвөгтэй байдлыг харгалзан яллагдагчийг цаашид цагдан хорих зайлшгүй шаардлагатай бол шүүх цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг тухай бүр 1 сар хүртэл хугацаагаар сунгах ба яллагдагчийг цагдан хорих нийт хугацаа Эрүүгийн

хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жил хүртэл хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 12 сар, Эрүүгийн хуульд хорих ялын дээд хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар оногдуулахаар заасан гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй. /14.10/

Харин Эрүүгийн хуулийн зарим зүйлд заасан гэмт хэргийн яллагдагчийг энэ зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас илүү хугацаагаар цагдан хорих шаардлагатай бол шүүх 6 сар хүртэл хугацаагаар нэмж сунгаж болохоор хуульчилсан. Хуульд зааснаас бусад тохиолдолд шүүхийн зөвшөөрөлгүй, эсхүл шүүхийн шийдвэрт зааснаас илүү хугацаагаар цагдан хоригдож байгаа хүнийг прокурор даруй суллах үүрэгтэй.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд зааснаар 2018 онд шүүхээс 4647 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар санал ирүүлсэн байна. Шүүхэд цагдан хорих таслан сэргийлэх авхуулахаар ирүүлсэн хүний тоо 2017 оноос 1174 хүн буюу 33.8 хувиар, цагдан хорихоос татгалзсан хүний тоо 40 хүнээр буюу 9.5 хувиар өссөн дүнтэй гарсан байна. Цагдан хорих зөвшөөрлийн 13.7 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан”, 11.6 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлсан”, 0.1 хувийг “мөрдөгчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 1 хувийг “хохирогчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.4 хувийг “гэрчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.4 хувийг “гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн”, 1.4 хувийг өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 1 хувийг “хохирогчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.5 хувийг “гэрчийн

²¹ Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.4 дүгээр зүйл. Хүнийг хүчээр алга болгох



амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.2 хувийг “гэмт хэрэг хамтран үйлдсэн хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 30.5 хувийг “гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 20 хувийг урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн”, 0.6 хувийг “шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 4.2 хувийг “прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 14.3 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан” үндэслэлээр тус тус олгожээ²².

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд зааснаар 2019 онд шүүхээс 3955 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар санал ирүүлсэн байна²³. Шүүхээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар ирүүлсэн хүний тоо 2018 оноос 692 хүн буюу 14.9 хувиар, цагдан хорихоос татгалзсан хүний тоо 40 хүнээр буюу 9.5 хувиар өссөн дүнтэй гарсан байна. Цагдан хорих зөвшөөрлийн 32.8 хувийг “гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 19.8 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан”, 14.7 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх 231 ажиллагаанаас оргон зайлсан”, 12.1 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан”, 11.5 хувийг урьд нь

авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн”, 4.8 хувийг “прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 1.4 хувийг “хохилогчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.9 хувийг “гэрчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.8 хувийг өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.3 хувийг “гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.4 хувийг “шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 0.3 хувийг “хохилогчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.1 хувийг “гэрчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.1 хувийг “гэмт хэрэг хамтран үйлдсэн хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.03 хувийг “прокурорыг дарамталсан, сүрдүүлсэн”, үндэслэлээр тус тус олгожээ.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.1 дүгээр зүйлд зааснаар 2020 онд шүүхээс 3672 хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авхуулахаар санал ирүүлсэн байна.

Цагдан хорих зөвшөөрлийн 9.7 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан”, 21.1 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлсан”, 1.1 хувийг “хохилогчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.5 хувийг “гэрчийг дарамталсан, сүрдүүлсэн”, 0.8 хувийг “гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн”, 1.9 хувийг өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.3 хувийг “хохилогчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт,

²² Монгол Улсын Шүүхийн 2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан

²³ Монгол Улсын Шүүхийн 2019 оны шүүн таслах ажиллагааны тайлан



мэдээлэл байгаа”, 0.1 хувийг “гэрчийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 0.1 хувийг “гэмт хэрэг хамтран үйлдсэн хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 17.8 хувийг “гэмт хэрэг дахин үйлдэх талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа”, 11.5 хувийг урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн”, 0.1 хувийг “шүүхийн мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 15.4 хувийг “прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй”, 19.6 хувийг “эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилтод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан” үндэслэлээр тус тус олгожээ.

Эрүүгийн процессын явцад баривчлах, цагдан хорих ажиллагаа хэрхэн хийгдэж байгаа, хүний халдашгүй эрх хэрхэн хангагдаж, зөрчигдөж байгаа талаар эцэслэн шийдвэрлэгдэж, хуулийн хүчин төгөлдөр болж архивд орсон эрүүгийн хэргүүдээс судалж, shuukh.mn сайтад байршсан шүүхийн шийдвэрүүдэд дүн шинжилгээ хийсэн. Түүнчлэн хууль хэрэглээ, нийтлэг зөрчлийн талаар хотын болон орон нутгийн нийт 29 шүүгч, өмгөөлөгч, хуульч нартай ярилцлага зохион байгуулж, гарсан санал, шүүмжийг нэгтгэн тусгасан болно. Үүний зэрэгцээ Монгол Улсын шүүхийн сүүлийн 3 жилийн статистик мэдээнд үндэслэн баривчлагдаж цагдан хоригдсон хүний судалгаа, ХЭҮК-ын сүүлийн 3 жилийн илтгэл, тайланд үндэслэн хүний халдашгүй эрхийн зөрчлийн талаар, мөн шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч, яллагдагч, иргэдээс анкетын аргаар санал асуулга авч судалгаа хийсэн.

Хүний эрхийн тухай асуудал нь өнөөгийн соёл иргэншлийн салшгүй хэсэг, үндэсний төдийгүй дэлхий дахины нийтлэг үнэт зүйлсийн шалгуур болж хүнийг баривчлах, цагдан хорих зэрэг нь мөн чанарын хувьд аливаа этгээдийг өөрийн эрх мэдэлгүй болгож байгаа төрийн албадлага юм. Иймд хүний халдашгүй эрхэд халдаж буй буй аливаа шийдвэр, үйл ажиллагаа нь хууль ёсны байх шаардлагатай. Хуулийг нэг мөр, бүтээлчээр хэрэглэж, хэрэгжүүлэх нь тухайн эрх олгосон субъектүүдэд өгсөн нэг талын үүрэг тул өмгөөлөгч, мөрдөгч, прокурор, шүүгч нь мэдлэг чадвараа тогтмол дээшлүүлэх, нөгөө талаас тэдний ажлын арга барилыг ОУ-ын жишиг тулгуурлан хүний эрхэд суурилсан хандлагаар өөрчлөх зайлшгүй шаардлагатай байна.

Гурав. Тулгамдаж буй асуудал

3.1. Практикт тулгамдаж байгаа асуудлуудаас дурдвал:

Шүүхийн зөвшөөрөлгүй баривчлан 48 цаг хүртэл хүнийг хорьсон атал сэжигтнийг баривчлах тогтоолоо шүүхэд хүргүүлж, шүүгчийн захирамж гаргуулаагүй болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.5 дугаар зүйлд заасан 24 цагийн дотор шүүхээр шийдвэрлүүлдэггүй боловч энэхүү баривчилж саатуулсан хоног нь хууль журмын дагуу гэж үзэх эсэх, хоригдсон хугацааг тооцох эсэх нь асуудал дагуулна. Иймд хуулийг хэлбэрэлтгүй хэрэгжүүлэхэд шүүхийн хяналт чухал юм.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар прокурорын санал, мөн хуулийн 31.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан мөрдөгчийн шийдвэрийг шүүх хүлээн авснаас хойш 24 цагийн дотор шийдвэр гаргахдаа шүүхийн



хэлэлцүүлэг хийх эсэх нь тодорхой бус байна. Ингэснээр шүүх бүр өөр өөрөөр шийдвэр гаргах нөхцөл бүрдсэн байна. Хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2.12-т заасан өмгөөлөгчийн эрхэд “сэжигтнийг баривчлах...холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцох” гэж хуульчилснаас үзвэл хэлэлцүүлэг хийх нь зүйтэй байна.

ЭХХШТХ-ийн 7.7 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “... хууль бусаар баривчилсан, цагдан хорьсон бол суллуулахаар гомдол гаргах эрхтэй” гэж хуульчилсан атал хэрхэн гомдол гаргах, хэн шийдвэрлэх нь хуульчлагдаагүй. Өөрөөр хэлбэл шүүхийн өмнөх шатанд шийдвэрлэж буй шүүгчийн шийдвэрт тус шүүхийн ерөнхий шүүгчид гомдол гаргах эрхтэй талаар хуульчлахдаа энэхүү заалтыг орхигдуулсан /15.8/.

Мөн хуулийн 31.8 дугаар зүйлийн 1.4-т зааснаар баривчлах шийдвэр ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах эрхтэй гэж хуульчилсан атал хэрхэн хэнд нь гомдол гаргах, ямар хугацаанд, ямар журмаар гомдол шийдвэрлэх процессыг нарийвчлан тусгаагүй.

Хүнийг баривчлах үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний эрхэд халдсан аливаа зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь чухал. Баривчлах ажиллагаа хууль журмын дагуу хийгдээгүй гэх гомдол мэдээлэл гарч, үүнийг хянан шалгах прокурорын үйл ажиллагаа хийх нь үр дүн багатай байна. Тиймээс хүний эрхэнд халдах баривчлах ажиллагааг дуу-дүрс бичлэгээр заавал баримтжуулж байхаар хуульд тусгах шаардлага үүсэж байна.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиар сэжигтнээр тооцох, сэжигтний эрх үүрэг, түүнээс мэдүүлэг авах процессыг нарийвчлан тусгаагүйгээс хүнийг гэрчээр дуудаж мэдүүлэг авсны

дараа, яллагдагчаар татан цагдан хорих тохиолдол гарч болзошгүй. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд сэжигтнээр тооцож мэдүүлэг өгөх эсэхийг тодруулсны дараа сэжигтнээр цагдан хорих эсэх асуудлыг хуульчлах нь чухал бөгөөд ийм заалтгүйгээс гэрчийн хувиар өмгөөлөгчгүй мэдүүлэг авсны дараа уг мэдүүлгийг нь өөрийнх нь эсрэг ашиглах зэргээр хүний эрхийг зөрчиж болзошгүй юм.

Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.2 дахь хэсэгт заасны дагуу хорих байрны дарга нь хоригдсон этгээдийг хуульд заасан хорих хугацаа дуусах болсон тухай 24 цагаас доошгүй хугацааны өмнө хорих шийдвэр гаргасан албан тушаалтанд болон харьяалах прокурорт бичгээр мэдэгдэх үүрэгтэй. Гэвч энэхүү ажиллагаа зохих журмын дагуу хийгдэж байгаа эсэх эргэлзээтэй.

Баривчилсан, цагдан хорьсон талаар түүний ар гэрийн гишүүдэд мэдэгдсэн талаар баримт хэрэгт хавсаргаагүй, эсхүл мэдэгддэггүй талаар Хүний эрхийн комисст мэдээлсэн байдаг.

3.2. Практикт тулгамдаж байгаа асуудлуудаас дурдвал:

Практикт гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт мэдээлэл бий болоогүй атал энэхүү үндэслэлээр цагдан хорих санал шүүхэд ирүүлж байгаа талаар энэ талаарх судалгаанаас ажиглагдсан²⁴.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар яллагдагчийн эрх үүрэг нь шүүгдэгчид мөн адил хамаарахаар хуульчилсан. Цагдан хорих үндсэн хугацаа 1 сар, хөнгөн гэмт хэрэгт 12

²⁴ Шүүгч, хуульч нартай хийсэн ярилцлагаас



сар, хүнд гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй, ЭХХШТХ-ийн 14.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан 4 төрлийн гэмт хэрэгт 18 сар дээр нэмээд дахин 6 сар сунгаж болно гэж хуульчилжээ. Гэтэл шүүхийн практикт үзэхдээ дээрх хугацаа бол зөвхөн шүүхийн өмнөх шатанд буюу яллагдагчид л хамаарна, шүүхэд шилжүүлсэн хэргийн тухайд шүүгдэгчид цагдан хорих хугацаа тоолохгүй хэмээн дур мэдэн цагдан хорих хугацаа дууссан байхад ч үргэлжлүүлэн хорьсоор байгаа тохиолдол нэг бус удаа гарсаар. Тухайлбал ХЭҮК-ын судалгаанд хуульд зааснаас илүү хугацаагаар цагдан хорьсон буюу 12, 18 сараас илүү хугацаагаар цагдан хорьсон байна. Яллагдагч Дэнзэнд холбогдох хэргийг анхан шатны шүүхэд буцаахдаа цагдан хорих хугацаа нь хэтэрсэн атал дээд шатны шүүхээс цагдан хорих шийдвэрийг хэвээр үлдээж үргэлжлүүлсэн байна²⁵, хойшид цагдан хорих хугацаа дууссан л бол суллаж байх нь шүүхийн үүрэг юм. Удаан хугацаагаар цагдан хорихыг эрүүдэн шүүлтийн хэлбэр гэж ОУ гэрээ конвенцод тусгагдсан байдаг.

Шүүхээс цагдан хорих захирамжийн хугацааг сунгасан шийдвэр гаргахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9-т заасан үндэслэлийг зарим тохиолдолд бичдэггүй, мөн хуулийн 14.10-т заасан үндэслэлээр цагдан хорих шийдвэр гаргах нь хуульд заасан үндэслэлгүйгээр цагдан хорьсон гэж үзэхээр байна²⁶.

Цагдан хорих ажиллагааны талаар буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлд зааснаар цагдан хорьсон шийдвэрийг өөрчлүүлэх, хүчингүй болгох талаар яллагдагч, түүний өмгөөлөгч нь шүүхэд хүсэлт ирүүлэхэд

²⁵ ХЭҮК-ын илтгэлээс

²⁶ Хуульч нартай хийсэн ярилцлагад

хавтаст хэргийг ямар хугацаанд шүүхэд мөрдөгч, прокурор нь ирүүлэх эсэх нь тодорхой хуульчлаагүйгээс хугацаа алдаж, яллагдагчийн эрх ашиг зөрчигдөж байна²⁷.

Шүүхийн өмнөх шатанд ихэнх тохиолдолд өмгөөлөгчгүйгээр мөрдөн байцаалтын ажиллагаа явуулж цагдан хорих эсэх асуудлыг шийдвэрлэж байгаа нь нэг талыг барьсан шийдвэр гарч мэтгэлцэх зарчим хэрэгжиж чадахгүйд хүргэх тохиолдол цөөнгүй байна²⁸.

Түүнчлэн цагдан хорих талаар шүүхийн хэлэлцүүлэгт нотлох баримтыг өмгөөлөгч нарт танилцуулахгүй /ялангуяа мөрдөн шалгах нууц ажиллагааны талаар/ талуудын эрх тэгш мэтгэлцээнийг өрнүүлэхгүйгээр зөвхөн прокурорын санал, дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэр гаргах нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.1 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасан “шүүхийн хэлэлцүүлэг, шүүх хуралдаанаар шинжлэн судалсан нотлох баримт шүүхийн шийдвэрийн үндэслэл болно” гэсэнтэй, мөн зүйлийн 15 дахь хэсэгт заасан “Хавтаст хэрэгт тусгагдсан нотлох баримтыг шүүх хуралдаанаар шинжлэн судалж аль нь шүүхийн шийдвэрийн үндэслэл болохыг шүүх шийдвэрлэнэ” гэсэнтэй, Мөн хуулийн 1.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан “Шүүх хэргийн бодит байдлыг талуудын мэтгэлцээний үндсэн дээр тогтооно” гэсэнтэй зөрчилдөж байх тул зөвхөн мөрдөн шалгах ажиллагааг дууссаны дараа хавтаст хэргийн материалтай танилцахаар хуульчилсныг өөрчлөн найруулж, аль ч шатанд танилцах, хуулбарлах эрхийг олгох нь зүйтэй байна.

Оргон зайлсан хүнийг, болон бусад үндэслэлээр цагдан хорих тухай шүүхийн

²⁷ Хуульч нартай хийсэн ярилцлагаас

²⁸ Мөн тэнд




шийдвэрийг биелүүлэхэд хэрхэн цагдан хорих байранд хүргэх эсэх нь хуульд нарийвчлан тусгаагүй байна. Өөрөөр хэлбэл цагдан хорих шийдвэр биелүүлэхэд баривчлах ажиллагаанд тавигдах шаардлага, үзлэгийг хийж, тэмдэглэл үйлдэх нь хүний эрхийг зөрчихгүй байх нэн чухал шаардлага юм.

Хохирогч нь шүүхийн хэлэлцүүлэгт оролцохоор тус хуульд заасан /8.2-1.4/, мөн хуулийн 15.8-д зааснаар цагдан


хорих шийдвэрийн талаар ерөнхий шүүгчид гомдол гаргах эрхтэй атал тус хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хохирогчийн эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасныг өөрчлөн найруулж, нэмэх нь зүйтэй байна.

“Шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа: БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ АЖИЛЛАГААНД АНХААРАХ ЗАРИМ АСУУДАЛ” сэдвээр 30 хүнээс авсан санал асуулгын судалгааны үр дүн:


Асуулт 1. Таны нас



Асуулт 2. Таны албан тушаал




Асуулт 3. Таны ажилласан жил







Асуулт 4. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд /таслан сэргийлэх арга хэмжээ авах шүүхийн хэлэлцүүлэгт/ хэргийн оролцогчдыг хавтаст хэргийн материалтай танилцах, хуулбарлан авах эрхээр хангах нь зүйтэй эсэх




Асуулт 5. Шүүхээс сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгоход шүүхийн хэлэлцүүлэг хийх нь зүйтэй эсэх



Асуулт 6. Баривчлах шийдвэр ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах эрхтэй гэж хуульчилсан. Иймд гомдлоо ерөнхий шүүгчид гаргах нь зүйтэй эсэх




Асуулт 7. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлд заасан яллагдагчийг цагдан хорих хугацаа шүүгдэгчид адил хамаарах эсэх







Асуулт 8. Мөрдөгч, прокурор нь мөрдөн шалгах бүхий л ажиллагааг /баривчлах ажиллагааг/ дуу-дүрсний бичлэгээр бэхжүүлэх нь зөв үү




Асуулт 9. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.13 дугаар зүйлд зааснаар цагдан хорьсон шийдвэрийг өөрчлөх, хүчингүй болгох талаар яллагдагч, түүний өмгөөлөгч нь шүүхэд хүсэлт ирүүлэхэд хавтаст хэргийг мөрдөгч, прокурор нь шүүхэд ирүүлэх талаар хугацаа тогтоох шаардлагатай юу?



Асуулт 10. Оргон зайлсан яллагдагч болон бусад үндэслэлээр цагдан хорих тухай шүүхийн шийдвэрийг биелүүлэхэд хэрхэн барьж, цагдан хорих талаар хуульчлах шаардлагатай юу?



Асуулт 11. Хохирогч нь хуулийн 14.13 дугаар зүйлд заасан хэлэлцүүлэгт оролцох эсэх





Дээрх судалгаанаас үзвэл нийт 30 оролцогчийн дийлэнх нь 36-55 насны, эрүүгийн хэргийн процесс ажиллагаанд оролцогч, 5-15 жилийн ажлын туршлагатай хүмүүс байна. Судалгаанд оролцсон хүмүүсийн 22 нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны аль ч шатанд хэргийн материалтай танилцах эрхийг хуульчлах, 20 хүн сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгоход шүүхийн хэлэлцүүлэг хийх, 20 хүн баривчлах ажиллагаанд гомдол гаргах эрхийг хангах, 24 хүн шүүгдэгчийг цагдан хорих хугацаа нь яллагдагчтай нэгэн адил байх, 25 хүн хавтаст хэргийг шүүхэд ирүүлэх хугацааг тогтоох, 21 хүн хохирогчийг таслан сэргийлэх арга хэмжээний хэлэлцүүлэгт оролцуулахыг тус тус дэмжсэн байна.

Дүгнэлт

Баривчлах, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хүрээн дэх хүний эрх нь халдашгүй эрх бөгөөд иргэний хувийн эрхэд хамаарах эрх юм. Хүний эрх гэж хүн бүрт төрөхөөс нь үхэх хүртэл заяагдсан хүний суурь эрх, эрх чөлөөг хэлдэг. Энэ эрхээ хүн бүр хаана төрсөн, ямар үзэл бодол, итгэл үнэмшилтэй, амьдралаа яаж сонгосноосоо үл хамааран эдлэх ёстой. Энэ эрхийг хэн ч булааж авах ёсгүй боловч хууль зөрчсөн, эсвэл үндэсний аюулгүй байдалд хор учруулсан тохиолдолд зөвхөн төр хязгаарладаг. Хүний халдашгүй эрхийн талаар Хүний эрхийн түгээмэл тунхаглалын 3 дугаар зүйлд “Хүн бүр амьд явах, эрх чөлөөтэй байх, халдашгүй дархан байх эрхтэй гэж, Иргэний болон улс төрийн тухай олон улсын фактын 9 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “хүн бүр эрх чөлөөтэй, халдашгүй дархан байх эрхтэй. Хэнийг ч дур мэдэн баривчлах буюу цагдан хорьж болохгүй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур хэний ч эрх чөлөөг хасаж болохгүй”

гэж, НҮБ-ын хорихоос өөр төрлийн арга хэмжээнд холбогдох наад захын жишиг дүрмийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Шүүхийн өмнөх шатанд хорьж, саатуулахаас зайлсхийж, хорьж саатуулахыг орлох бусад арга хэмжээг боломжийн хирээр аль болох эхэлж хэрэглэнэ” гэж тус тус зааж манай улс дээрх баримт бичгүүдэд нэгдэн орж, дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил даган мөрдөж байгаа ба Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олжээ. Хүний эрхийг жинхэнэ утгаар нь эдлүүлнэ гэдэг нь тухайн хууль, конвенцын заалт амьдралд хэрхэн хэрэгжихээс шууд хамааралтай. Манайх ардчилсан улс учраас төр нь хуулиараа хүний эрхийг хамгаалж, үүргийг нь сахиулж, харин иргэний нийгэм нь төрийн ажлыг хянаж, засаж залруулахыг төрөөс шаарддаг тогтолцоотой²⁹. Иймд эрүүгийн процессын бүхий л харилцаанд хүний халдашгүй эрхийн зарчмыг тууштай хангах, баривчлах, цагдан хорих талаарх мөрдөгч, прокурор, шүүгчдийн сэтгэлгээг шинэчлэх, эрдэмтэн судлаачид болон холбогдох байгууллага дээр дурдагдсан зүйлсийг анхааралдаа авч нарийвчлан судлах, энэ талаарх хууль тогтоомжийг боловсронгуй болгох зэргээр тулгамдсан олон асуудлыг оновчтой шийдвэрлэх шаардлагатай юм.

Саналын хувьд: Энэ бүхний эцэст дүгнэн үзэхэд хүний эрхэд суурилан илүү сайжруулж болох, эрх зүйн зохицуулалтгүйгээр явагдаж байгаа гэж болох зарим ажиллагааг хуулиар тодорхойлж боловсронгуй болгох шаардлагатай байна. Үүнд:

1) Мэтгэлцэх зарчмыг хангах үүднээс, хэргийн эрх тэгш оролцоог хангаж, хэргийн оролцогчдыг аль ч

²⁹ <https://jargaldefacto.com/article/khunii-erkhiig-batalgaajuulan-khamgaalakh-uureg>



шатанд хавтаст хэргийн материалтай танилцах, хуулбарлан авах боломжоор хангаж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2.9-д заасан “хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, мөрдөн байцаалт дууссан бол” гэснийг хасах;

2) Шүүхээс сэжигтнийг баривчлах зөвшөөрөл олгох эсэх буюу Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар прокурорын саналыг шүүх хүлээн авснаас хойш 24 цагийн дотор шийдвэр гаргахдаа шүүхийн хэлэлцүүлэг хийх эсэх нь тодорхой бус байна. Иймд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 31.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт нэмэлт 1 заалт оруулан, “шүүх шийдвэр гаргахдаа энэ хуулийн 14.13-т заасан журмыг баримтална” гэж нэмэх;

3) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.7-д зааснаар хууль бусаар баривчилсан, цагдан хорьсон бол суллуулахаар гомдол гаргах эрхтэй” гэж, Мөн хуулийн 31.8 дугаар зүйлийн 1.4-т зааснаар баривчлах шийдвэр ажиллагааны талаар шүүхэд гомдол гаргах эрхтэй гэж хуульчилсан атал хэрхэн хэнд нь гомдол гаргах, ямар хугацаанд, ямар журмаар тухайн гомдлыг шийдвэрлэх процессыг нарийвчлан тусгаагүй. Өөрөөр хэлбэл хууль бусаар хүнийг огт хорьж болохгүй бөгөөд энэ талаар гомдол гаргасан тохиолдолд шийдвэрлэх процесс, хугацаа, эрх бүхий албан тушаалтан нь тодорхой байх хэрэгтэй. Түүнчлэн баривчлах захирамж хуулийн хугацаанд гараагүй, болон захирамжийг хүчингүй болгуулахаар гомдол гаргах эрхийг дараах байдлаар хуульчлах. Үүнд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “...21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт...” гэсний дараа “31.4, 31.5” гэж нэмэх;

4) Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 7.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар яллагдагчийн эрх үүрэг нь шүүгдэгчид мөн адил хамаарахаар хуульчилсан. Цагдан хорих үндсэн хугацаа 1 сар, хөнгөн гэмт хэрэгт 12 сар, хүнд гэмт хэрэгт 18 сараас хэтэрч болохгүй, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан 4 төрлийн гэмт хэрэгт 18 сар дээр нэмээд дахин 6 сар сунгаж болно гэж хуульчилжээ. Гэтэл шүүхийн практикт дээрх хугацаа бол зөвхөн шүүхийн өмнөх шатанд буюу яллагдагчид л хамаарна, шүүхэд шилжүүлсэн хэргийн тухайд шүүгдэгчид цагдан хорих хугацаа тоолохгүй хэмээн дур мэдэн цагдан хорих хугацаа дууссан байхад ч үргэлжлүүлэн хорьж болзошгүй байна. Иймд хуулийн 14.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “яллагдагч” гэсний дараа “шүүгдэгч” гэж нэмж оруулах;

5) Хохирогч нь шүүхийн хэлэлцүүлэгт оролцохоор Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 8.2 дугаар зүйлийн 1.4-т зааж, мөн хуулийн 15.8-д зааснаар цагдан хорих шийдвэрийн талаар ерөнхий шүүгчид гомдол гаргах эрхтэй атал тус хуулийн 14.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт хохирогчийн эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасныг өөрчлөн найруулж, “хохирогч” гэж нэмэх.

Ном зүй:

Олон улсын гэрээ, конвенц:

1. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын факт;
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглал;
3. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж, шийтгэхийн эсрэг конвенц;



4. Хүний эрх, үндсэн эрх чөлөөг хамгаалах тухай конвенц,

Хуулиуд

1. Монгол Улсын Үндсэн хууль.УБ., 1992 он
2. Монгол Улсын Эрүүгийн хууль. УБ., 2015 он
3. Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль. УБ., 2017 он

Ном, зохиолууд:

1. С.Жанцан. “Хууль зүйн сэтгэл судлал”. УБ хот. 2001 он
2. Лүндэндорж.Л. “JURISPRUDENCE Эрх зүй судлал: Философи, онол”. УБ. 2011 он
3. Лүндээжанцан.Д нар.“Эрх зүйн философи”. УБ. 2014 он
4. Нямсүрэн.Ч “Эрх зүйн үндэс”. УБ. 2015 он
5. Эрдэнэбат.Х. “Хүний халдашгүй эрх”. УБ. 2002 он
6. Я.Цэвэл. МХТТТ. УБ хот, 1966 он

7. “Шүүх эрх мэдэл”. ШЕЗ. №2. УБ. 2017 он

8. “Монгол Улсын шүүхийн тайлан”. ШЕЗ. УБ. 2018, 2019, 2020 он
9. “Хүний эрх ба эрүү шүүлт тулгах гэмт хэрэг”. УЕПГ. УБ. 2020 он
10. “Хүний эрхийн олон улсын гэрээ ба Монгол Улс”. ХЭҮК. УБ. 2021 он
11. “Шүүх эрх мэдэл”. ШЕЗ. №1. УБ. 2021 он
12. “Монголын төр, эрх зүй”. УДШ. №1. 2021 он
13. “Шударга ёсны хэмжүүр”. УБ. 2021 он

Цахим хаяг:

1. <https://legaldata.mn/>
2. <https://www.forum.mn/>
<https://jargaldefacto.com/article/khunii-erkhiig-batalgaajuulankhamgaalakh-uureg>



Abstract

PROCEEDINGS IN COURT: SOME ISSUES TO BE CONSIDERED IN ARREST AND POLICE DETENTION

D. AZJARGAL

*Chief Judge of the Criminal and Civil Appeal
Court of Bulgan province*

No one has the right to violate or deny a person's right to inviolability and freedom, and the state restricts it in certain cases according to the grounds and procedures established by law. Arbitrary arrest and detention is a serious violation of human rights and many treaties and conventions. However, in practice, during the detection and investigation of crimes, there are cases of violation of human rights caused by law enforcement.

In this report, the research report and the practical situation of some issues to be considered in court proceedings: arrest and detention, conducted a questionnaire survey among the employees and researchers working in legal institutions, and based on the research, the researcher put forward suggestions and recommendations.

Keywords

Criminal court, criminal proceedings, rights and freedoms, custodial, detective, attorney, arrest



**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛЬ ДАХЬ АРБИТРЫН АЖИЛЛАГААТАЙ
ХОЛБООТОЙ АНХААРАХ АСУУДАЛ**

**ISSUES CONCERNING ARBITRARY ACTIVITIES IN
THE CIVIL PROCEDURE CODE**

Б.МАНДАЛБАЯР¹

- I. Оршил
- II. Арбитрын ажиллагаанд дахь шүүхийн оролцооны зарчим
- III. Арбитрын хэлэлцээртэй холбоотой практикт гарч буй асуудал
- IV. Нотлох баримт бүрдүүлэх ажиллагаатай холбоотой асуудал
- V. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах (түр арга хэмжээ)
- VI. Дүгнэлт
- VII. Ном зүй

¹ Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч



ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ДАХЬ АРБИТРЫН АЖИЛЛАГААТАЙ ХОЛБООТОЙ АНХААРАХ АСУУДАЛ

Б.МАНДАЛБАЯР. Баянзүрх дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч

Хураангуй

Энэ нийтлэлээр арбитрын ажиллагаанд дахь шүүхийн оролцооны зарчмын талаарх ойлголтыг өгөхийг зорьж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Арбитрын тухай хуулийн зарим зохицуулалтыг практикт хэрхэн хэрэглэх, хэрэглэж байгаатай холбоотой зарим нэг асуудлын талаар танилцуулахыг хичээв.

Оршил

Олон улсын харилцаа өргөжихийн хирээр түүнийг зохицуулах эрх зүйн хэм хэмжээ илүү боловсронгуй болж, худалдаа, эдийн засгийн асуудал дотоодын хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээнээс давж улс хоорондын буюу олон улсын түвшинд яригдах болсон. Үүнийг дагаад аливаа гэрээ, хэлэлцээр байгуулах, тэдгээрийг хэрэгжүүлэхээс үүдэлтэй маргаан, үл ойлголцлыг аль нэг улсын шүүхээр бус бизнесийн харилцааны соёл, “lex mercatoria” буюу худалдааны зан заншлыг олон улсын арилжааны гэрээний хувьд өндөр ач холбогдол өгдөг, хурдан шуурхай, ажил хэргийн нэр хүндэд нөлөөлөхгүй нууцлал сайтай, хараат бус, хөндлөнгийн бие даасан, уян хатан шинж чанартай гэх зэргийг харгалзан арбитраар шийдвэрлүүлэх хандлага улам их болж байна.

Гэвч талууд дотоодын болон олон улсын хувийн эрх зүйн шинжтэй гэрээ, хэлэлцээрээс үүссэн маргааныг тийнхүү арбитраар шийдвэрлүүлэхээр тохирсон нь арбитрын ажиллагаа явагдаж буй газрын, түүнчлэн арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх гүйцэтгэх хуудас олгох харьяа шүүхэд огт хамааралгүй гэсэн үг биш, харин ч шүүх нь Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, Арбитрын тухай хууль, Гадаадын арбитрын шийдвэрийг хүлээн зөвшөөрөх, биелүүлэх тухай 1958 оны Нью Йоркийн конвенцид тус тус заасан арбитрын ажиллагаанд дахь шүүхийн оролцооны чиг үүргийг зөв ойлгож, тэнцвэр болон хяналтыг зохих ёсоор хэрэгжүүлэх үүрэгтэй билээ.

Нэг. Арбитрын ажиллагаанд дахь шүүхийн оролцооны зарчим

Түүхэн байдлаас авч үзвэл шүүх нь арбитраар маргаан шийдвэрлүүлэх аргыг дэмждэггүй байсан учир арбитрын ажиллагаанд их оролцдог байсан. Тухайлбал, Англи улсад урьд өмнө арбитрадыг маргаан хянан шийдвэрлэх чадваргүй гэж үздэг байсан тул Арбитрын тухай хуучин хуулиараа арбитрын ажиллагаанд шууд хяналт тавих байдлаар шийдвэрийг нь процесс болон агуулгын хувьд хянаж хүчингүй



болгох, арбитрын ажиллагааг зогсоох эрх хэмжээтэй байснаас гадна арбитр нь зөвхөн хэргийн үйл баримтыг тогтоож, шүүх эцсийн шийдвэрийг гаргадаг байжээ.

Энэ мэтээр арбитрын ажиллагаанд дахь шүүхийн оролцоо их байсан нь гэрээний талуудын түүнд хандах хандлагыг багасгахад нөлөөлснөөс улбаалан улс орнууд шүүхийн оролцоог зохистой түвшинд байлгахыг зорих болж, "UNCITRAL"-аас олон улсын арилжааны арбитрын загвар хуулийг боловсруулахад ихээхэн түлхэц өгчээ¹.

Гэвч дэлхий улсуудын улс төр, эдийн засгийн болоод эрх зүйн соёл өөр, шүүхийн хэрэг маргааныг хянан шийдвэрлэх онцлог зэрэгт үндэслэн арбитрын ажиллагаанд дахь шүүхийн оролцоог жишиг байдлаар зохистой түвшинд (стандарт) хүргэсэн улсын талаар нарийн судалгаа байхгүй хэдий ч улс бүр уг асуудалд анхаарал хандуулсаар ирсэн. Өөрөөр хэлбэл, хэрэг маргааныг арбитраар шийдвэрлүүлэх аргыг хүлээн зөвшөөрөх хүртэлх хугацаанд тодорхой шалгуурыг даван туулсан боловч шүүхийн оролцоог бүрэн хязгаарласан улс байхгүй, харин зайлшгүй оролцвол зохих учир шалтгааныг олж тогтоож, арбитрын ажиллагаанд саад учруулахгүй байх зарчмыг баримталж байна.

Арбитрын ажиллагаанд дахь шүүхийн оролцоо нь олон улсад болон Монгол Улсын Арбитрын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд тус тус зааснаар талуудын хүсэлт, мөн хуулиар тогтоосон эрх хэмжээний хүрээнд арбитра болон хэргийн оролцогч нарт туслалцаа үзүүлэх, арбитрын үйл ажиллагааг хуулийн дагуу явагдаж

байгаа эсэхэд хяналт тавих чиг үүрэгтэй байхаар тодорхойлсон ба шүүхэд дараах зарчмыг баримтлахыг зөвлөдөг байна². Үүнд:

1. Арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны түргэн шуурхай байх зарчмыг хүндэтгэх,
2. Шударга, хараат бус, бие даасан байх зарчмыг баримтлах,
3. Арбитрын ажиллагаанд хүндрэл, бэрхшээл учруулахгүй байх,
4. Арбитрын ажиллагаанд сайн дураар оролцохгүй байх³.

Шүүх ба арбитрын ажиллагааг зарчмын хувьд авч үзвэл юуны түрүүнд хуулиар тогтоосон заавал байх оролцоо ба жинхэнэ түншлэл хоёрын хоорондын ялгаа мэдэгдэхүйцээр илрэн гардаг. Энэ тухай Английн шүүгч Lord Mustill-ийн хэлснээр: "Энд илэрхий хүндрэл ажиглагддаг. Нэг талаас арбитрын үзэл баримтлал нь зөвшилцлийн үйл ажиллагааны адилаар орон нутгийн шүүхийн арга хэрэгслээр дамжуулан төрийн механизмын оролцооны эсрэг чиглэсэн байдаг ч нөгөө талаас шүүх л зөвхөн арбитра тусалж болох эрх хэмжээтэй байна" гэжээ⁴.

Гэвч шүүх болон арбитрын хоорондын харилцаа холбоо нь түншлэл буюу хамтын ажиллагаанд дээр тогтох ёстой байдаг ч тэгш эрхтэй талуудын нөхөрлөл биш юм. Хэдийгээр сүүлийн үеийн судлаачдын үзэж байгаагаар шүүх, арбитрын эрх зүйн байдлыг "par in parem non habet

² Үндэсний арбитра сэтгүүл, №02 (05), УБ 2004, 10 дахь тал

³ Арбитрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Шүүх энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд арбитрын ажиллагаанд оролцож үл болно" гэж заасан нь "UNCITRAL"-ын загвар хуулийн 5 дугаар зүйлд заасантай нийцдэг.

⁴ A.Redfern, M.Hunter, N.Blackaby and C.Partasides., "Law and practice of international commercial arbitration" fourth edition.,London, 2004. page-388

¹ Д.Маралгоо: Арбитрын ажиллагаа дахь шүүхийн оролцоо, Арбитрын сэдэвт эрдэм шинжилгээний нийтлэл 2020 он, эмхэтгэл, 134,



imperium-тэгш этгээд тэгш этгээдийнхээ дээр эрх мэдэлгүй” гэсэн зарчмын үүднээс эрх тэгш гэж байгаа ч энэ нь зөвхөн арбитрын шийдвэрийн агуулгыг хянахгүй байхтай холбогддог бөгөөд, харин төрийн албадлагын механизмаар хамгаалагдсан, олон жилийн нөр их туршлагатай шүүх байгууллагын туслалцааг арбитр авахгүй байх, арбитрын ажиллагааны явцад талуудын эрх зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, дур зоргын шинжтэй үйлдлийг хязгаарлах чиг үүргийг шүүх нь хэрэгжүүлэхгүй гэсэн үг биш юм.

Иймээс арбитрын ажиллагаанд дахь шүүхийн оролцоог хаанаас эхэлж, хаана дуусч байгааг нарийн тогтоох шаардлагатай бөгөөд гол цөм болсон хууль зүйн үндэслэлийг зөв ойлгож хэрэглэх нь нэн чухал. Онолын хувьд шүүх, арбитрын үйл ажиллагааны эхний үе, явцын болон төгсгөлийн үе шатанд тус тус оролцдог ба эдгээрийг дэлгэрүүлэн ангилвал:

Эхний үе шат дахь оролцоо

1. Арбитрын хэлэлцээртэй холбоотой маргаан,
2. Арбитрыг байгуулах журамтай холбоотой маргаан,
3. Шүүхийн харьяаллын талаарх маргаан,

Явц дунд дахь оролцоо

1. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах,
2. Нотлох баримт бүрдүүлэхэд туслас,
3. Талууд тохиролцсон ч арбитрчийг томилж чадахгүй байх үед,
4. Арбитрчийг татгалзан гаргах асуудлыг шийдвэрлэх.

Төгсгөлийн үе шат дахь оролцоо

1. Арбитрын шийдвэрийг

баталгаажуулж гүйцэтгэх хуудас бичих,

2. Арбитрын шийдвэрийг хүчингүй болгох.

Хоёр. Арбитрын хэлэлцээртэй холбоотой практикт гарч буй асуудал

А. Тухайн маргааныг арбитрын харьяаллын маргаан гэдгийг тодорхойлох нэг үндэслэл нь арбитрын хэлэлцээр байдаг тул талууд уг маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр харилцан тохиролцсон бол арбитрын харьяалалд хамаарна⁵. Өөрөөр хэлбэл, арбитрын процессын үйл ажиллагаа эхлэх үед арбитрын хэлэлцээрийн хүчин төгөлдөр эсэхээс шалтгаалан арбитраар шийдвэрлүүлэхээс татгалзах тохиолдол байж болно.

Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Арбитрын хэлэлцээр гэж гэрээний үндсэн дээр үүссэн эсэхээс үл хамааран бий болсон эрх зүйн харилцаатай холбоотойгоор талуудын хооронд үүссэн, эсхүл үүсч болох аливаа маргаан, эсхүл түүний тодорхой хэсгийг арбитрын журмаар шийдвэрлүүлэх тухай талуудын тохиролцоог хэлнэ” гэж, мөн 8.2-т “Арбитрын хэлэлцээр нь гэрээний нэг хэсэг, эсхүл бие даасан гэрээ байж болно” гэж, түүнчлэн 8.3-т “Арбитрын хэлэлцээрийг бичгээр хийнэ” гэж тус тус заасан⁶.

Гэтэл практикт арбитрын хэлэлцээртэй маргаан гэдгийг зөвхөн гэрээний тусгай төрлийн харилцаанаас үүссэн маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг ойлгон гэж андуурах тохиолдол их гардаг байна. Зүй нь, хуульд тухайлан шүүхэд харьяалуулснаас бусад бүх төрөл (гэрээ болон хуульд зааснаар үүсэх үүрэг)-ийн хэрэг маргааныг талууд арбитраар шийдвэрлүүлэхээр

⁵ Үндэсний арбитр сэтгүүл: №03(08), УБ 2005, 7 дахь тал

⁶ Арбитрын тухай хууль (2017), 8.1, 8.2, 8.3



тохиролцож болно.

В. Мөн талууд арбитрын хэлэлцээртэй ч Иргэний хуулийн 56-61 дүгээр зүйлд заасан үндэслэлээр гэрээг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох, гэрээг хүчин төгөлдөр бусд тооцуулах тухай нэхэмжлэлийг гагцхүү шүүх л харьяалан шийдвэрлэх ёстой гэж ойлгодог хүмүүс байна⁷.

Гэтэл Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10-т “Талуудын хооронд байгуулсан үндсэн гэрээ хүчин төгөлдөр эсэх, аль нэг тал нь гэрээнээс татгалзсан, эсхүл үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон эсэхээс үл хамааран түүний хэсэг болох арбитрын хэлэлцээр хүчинтэй байна” гэж, 18.2-т “Тухайн гэрээн дэх арбитрын тухай заалтыг үндсэн гэрээний бусад заалтаас тусдаа, бие даасан гэрээ гэж үзнэ. Арбитрын бүрэлдэхүүн үндсэн гэрээг хүчин төгөлдөр бус гэж шийдвэр гаргасан нь тэрхүү гэрээний арбитрын тухай заалтыг хүчин төгөлдөр бус гэж тооцох үндэслэл болохгүй” гэж тус тус зааснаас үзэхэд арбитр нь иргэн, хуулийн этгээдийн зөрчигдсөн эрхийг шүүхийн нэгэн адил сэргээдгийн хувьд гэрээг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох, гэрээг хүчин төгөлдөр бусд тооцуулах тухай нэхэмжлэлийг шийдвэрлэж болно⁸.

Өөрөөр хэлбэл, Иргэний хуулийн 57 дугаар зүйлийн 57.1-д “Шүүх хуульд заасан үндэслэл, журмын дагуу сонирхогч этгээдийн нэхэмжлэлээр хэлцлийг хүчин төгөлдөр бус гэж тооцож болно” гэж заасныг шүүхэд тухайлан харьяалуулсан гэж ойлгодог ч тус хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-т “Иргэний эрх зүйн хамгаалалтыг шүүх, арбитр хуулиар тогтоосон журам, аргаар хэрэгжүүлнэ” гэж заасныг үндэслэвэл гэрээг хүчин төгөлдөр бус болохыг тогтоолгох,

⁷ Иргэний хууль (2002), 56-61

⁸ Арбитрын тухай хууль (2017), 8.10, 18.2

гэрээг хүчин төгөлдөр бусд тооцуулах тухай нэхэмжлэлийг зөвхөн шүүх хянан шийдвэрлэн гэж дүгнэж болохгүй⁹.

С. 2003 оны 05 дугаар сарын 09-ний өдөр батлагдаж, 2017 оны 01 дүгээр сарын 26-ны өдөр хүчингүй болсон Арбитрын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т зааснаар стандарт нөхцөл бүхий гэрээний тухайд арбитрын хэлэлцээрийг тодорхой маргаан үүссэний дараа байгуулахаар зохицуулсан байсан бол одоо мөрдөж байгаа Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11-д хэрэглэгчийн эрхтэй холбоотой маргааны хувьд арбитрын хэлэлцээрийг мөн маргаан үүссэний дараа байгуулахаар зохицуулжээ.

Жишээ дурдвал, Монгол Улсад үйл ажиллагаа явуулдаг гадаадын хөрөнгө оруулалттай автомашин худалдаалдаг дистрибьютор компанийн хэрэглэгчтэй байгуулдаг худалдах, худалдан авах гэрээнд “талуудын хооронд маргаан гарсан тохиолдолд Хонконгийн Олон улсын арбитраар шийдвэрлүүлнэ” гэсэн стандарт нөхцөл тусгагдсан нь тус компанид холбогдох автомашины доголдолтой холбоотой хэргийг Монгол Улсын шүүх харьяалан шийдвэрлэж болох уу гэсэн асуулт гарна.

Олон улсын худалдааны гэрээний Юнидройдын зарчмын 2.1.20 дугаар зүйлийн 1-д “Стандарт нөхцөлд оруулан гэж нөгөө тал нь тооцоолох боломжгүй заалт стандарт нөхцөлд тусгагдсан бөгөөд уг заалт түүнийг зөвшөөрч байгаагаа шууд илэрхийлээгүй бол дээрх заалтыг хүчинтэй гэж үзэхгүй” гэж “surprising terms” буюу гайхшируулсан заалт гэж томьёолжээ¹⁰.

⁹ Арбитрын сэдэвт эрдэм шинжилгээний нийтлэл 2020 он, эмхэтгэлд нийтлэгдсэн Д.Янжинхорлоо: Арбитр шүүх мөн үү нийтлэлээс дэлгэрүүлж үзнэ үү.

¹⁰ Олон улсын арилжааны арбитр ба олон улсын худалдааны эрх зүйн актын эмхтгэл, 2006 он, 141



Үндсэндээ стандарт нөхцөл гэрээний салшгүй хэсэг болж уг гэрээ байгуулагдсан тохиолдолд талууд гэрээгээ заавал дагаж мөрдөх үүрэг хүлээнэ. Гэхдээ талуудын итгэлийг хамгаалах, шударга бус нөхцөлийг нөгөө талд хүлээлгэснээр илт хохирол учрахаар бол (иргэн хүн тэр бүр Хонконгийн Олон улсын арбитраар маргаанаа шийдвэрлүүлэх санхүүгийн боломжгүй) стандарт нөхцөлд тусган гэж огт бодоогүй буюу гэрээний аль нэг тал уг нөхцөлийг гэрээ байгуулж байхдаа мэдсэн бол шууд татгалзах байсныг ийнхүү хожим мэдсэн тохиолдолд үүнийг гайхшируулсан заалт хэмээн үзэж, хүчингүйд тооцдог байна.

Иймд, гадаад улсын арбитраар маргаанаа хянан шийдвэрлүүлэхээр тохиролцсон хэрэглэгчийн гэрээтэй холбоотой нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.1.1-д заасан үндэслэлээр хүлээн авахаас татгалзах нь учир дутагдалтай бөгөөд стандарт нөхцөл бүхий гайхшируулсан заалт тусгагдсан эсэхийг тогтоож, шүүх харьяалан шийдвэрлэх боломжтойг тогтоох нь илүү зохимжтой юм¹¹.

D. Мөн сүүлийн үед зарим нэг банк, банк бус санхүүгийн байгууллагын хэрэглэгчийн зээлийн гэрээнд маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцсоныг Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д зааснаар арбитрын хэлэлцээртэй гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах уу гэсэн асуулт гарч байна. Учир нь, дээр дурдсанаар арилжааны шинжтэй бус хэрэглэгчийн эрхтэй холбоотой маргааныг талууд арбитраар шийдвэрлүүлэхээр урьдчилан тохиролцож болохгүй тул хэдий тийм хэлэлцээртэй байсан ч шүүх

¹¹ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002), 13.1, 65.1.1.

тухайн нэхэмжлэлийг хүлээн авч, иргэний хэрэг үүсгэсний дараагаар хэрэв зохигчид арбитрын хэлэлцээрээ дэмжиж, бичгээр зөвшөөрлөө илэрхийлсэн тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 117 дугаар зүйлийн 117.1-д зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгож болно¹².

Энэ талаар Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д “Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан бөгөөд аль нэг тал тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэх хүсэлт гаргасан бол шүүх аль нэг талын хүсэлтээр арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус, эсхүл биелүүлэх боломжгүй гэж үзсэнээс бусад тохиолдолд шүүхэд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно” гэж зааснаар хэрэглэгчийн эрхтэй холбоотой маргааны талаарх арбитрын тохиролцоо нь хуульд нийцэхгүй байгаа, аль эсхүл шүүхэд тухайлан харьяалуулсан, мөн зохигчид шүүхээр шийдвэрлүүлэх хүсэлтэй байгаа тохиолдолд иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэхээр байна.

Харин өөр төрлийн хэрэг маргааны хувьд талууд арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан бол шүүх гагцхүү аль нэг талын хүсэлтээр арбитрын хэлэлцээрийг хүчин төгөлдөр бус, эсхүл биелүүлэх боломжгүй гэж үзсэн, эсхүл талуудын хэн аль нь шүүхээр шийдвэрлүүлэхээр зөвшөөрсөн бол гэрээний эрх чөлөөт зарчмын үүднээс арбитраас татгалзсан гэж үзэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлэх бөгөөд үүнээс бусад тохиолдолд хэргийг

¹² Арилжааны шинжтэй гэдэг талаарх ойлголтыг Токиогийн их сургуулийн хүндэт профессор Очи Ай Сэйчи-ийн 2017 онд монгол хэл дээр орчуулагдсан Компанийн эрх зүйн үндсэн ойлголт номоос дэлгэрүүлж үзнэ үү.



хэрэгсэхгүй болгохоор байна.

Е. Өнөөдөр Монгол Улсад Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын арбитр, Улаанбаатар хотын Худалдааны Танхимын дэргэдэх арбитр, Монголын Барилгачдын холбооны дэргэдэх арбитр, Уул, уурхайн холбооны дэргэдэх арбитр, Монголын Олон улсын ба үндэсний Спортын арбитр гэсэн 5 байнгын арбитрын байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа тул гэрээний талууд арбитрын хэлэлцээртээ маргааныг чухам аль арбитраар шийдвэрлүүлэх талаар нэрийг нь тодорхой дурдах шаардлагатай болж байна.

Гэтэл зарим гэрээнд “маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх ба тийнхүү шийдвэрлэж чадахгүй бол арбитраар шийдвэрлүүлнэ” гэж заасныг арбитрын хэлэлцээртэй гэж үзэх үү, хэрэв тийм бол байнгын, аль эсхүл түр арбитр, эсхүл орон нутаг дахь салбар уу гэсэн асуулт тавигдаж, улмаар тэрхүү нэхэмжлэлийг хүлээн авах, эсхүл татгалзах эсэхийг шийдвэрлэхэд хүндрэл гарч байна.

Тодруулбал, энэ тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3-т “Талууд байгуулсан гэрээндээ маргаан гарвал арбитраар шийдвэрлүүлэхээр заагаагүй буюу энэ талаар хэлэлцэн тохиролцоогүй, эсхүл Засгийн газар хоорондын хэлэлцээрээр маргааныг арбитраар шийдвэрлүүлэхээр заагаагүй бол нэхэмжлэлийг шүүх шийдвэрлэнэ” гэж хуульчилсныг анхаарах учиртай¹³.

Зүй нь, үүнийг зохигчид анхнаасаа арбитраар маргаанаа хянан шийдвэрлүүлэхээр хүсэл зоригоо илэрхийлсэн хэмээн үзэж Арбитрын

¹³ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль (2002), 13

тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Арбитрын бүрэлдэхүүн тухайн маргаан нь арбитрын харьяаллын маргаан мөн эсэх, талууд арбитрын хэлэлцээртэй эсэх, уг хэлэлцээр нь хүчин төгөлдөр эсэхийг өөрөө тогтооно” гэж заасныг нягталбал талуудыг арбитрын хэлэлцээртэй гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах нь зөв байна¹⁴.

Учир нь, тус хэргийг аль арбитрын байгууллага харьяалан шийдвэрлэх бэ гэдгийг нэхэмжлэлийг хүлээн авсан арбитрын бүрэлдэхүүн өөрөө шийдвэрлэх бөгөөд уг шийдвэрийг үндэслэлтэй эсэхийг Арбитрын тухай хуулийн 18.7-т “Талууд арбитрын харьяаллын талаар гаргасан арбитрын бүрэлдэхүүний шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болох ба тухайн шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр байна” гэж зааснаар давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэх тул анхан шатны шүүх нэхэмжлэлийг хүлээн авах нь үндэслэлгүй ажээ¹⁵.

Үүнээс дүгнэвэл Арбитрын тухай хуулийн 18 дугаар зүйлд заасан арбитрын харьяаллын маргаан гэдэгт Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлд заасан хэргийн харьяаллын маргаанаас гадна тухайн маргааныг аль арбитрын байгууллага харьяалан шийдвэрлэх бэ гэсэн асуудал мөн адил хамаарч байна.

Шүүх, гэрээний талуудыг арбитрын хэлэлцээртэй ч энэ мэт ойлгомжгүй нөхцөлийг тодруулж, маргааныг харьяалах арбитр руу шилжүүлэх, нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзах, хэргийг хэрэгсэхгүй болгож, иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгох нь арбитрын хэлэлцээрийг

¹⁴ Арбитрын тухай хууль (2017), 18.1

¹⁵ Мөн тэнд 18.7



биелүүлэхэд дэмжлэг үзүүлж байгаа явдал гэж үздэг¹⁶.

Гурав. Нотлох баримт бүрдүүлэх ажиллагаатай холбоотой асуудал

Арбитрын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д “Арбитрын бүрэлдэхүүн, эсхүл түүний зөвшөөрснөөр талууд нотлох баримт гаргуулахад туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг шүүхэд гаргаж болох бөгөөд шүүх уг хүсэлтийг эрх хэмжээнийхээ хүрээнд хуульд заасан нотлох баримт гаргуулах журмын дагуу шийдвэрлэнэ” гэж заажээ.

Тодруулбал, тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.2-т зааснаар арбитрт нотлох баримт бүрдүүлэхэд нь туслалцаа үзүүлэхийг арбитрын ажиллагаа явагдаж байгаа газрын Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх, харин олон улсын арбитрын ажиллагааны хувьд Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хэрэгжүүлэх боловч хуульд “уг хүсэлтийг эрх хэмжээнийхээ хүрээнд хуульд заасан нотлох баримт гаргуулах журмын дагуу шийдвэрлэнэ” гэж заасныг чухам юу гэж ойлгох бэ гэсэн асуултад хариулах шаардлагатай.

Энэ тохиолдолд нотлох баримт бүрдүүлэх хүсэлтийг хүлээн авсан давж заалдах шатны шүүх нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.6-д зааснаар тухайн нотлох баримтыг хэрэгт ач холбогдолтой эсэхийг тогтоохоор хэргийг агуулгын хувьд хянах эрх хэмжээтэй юу гэсэн асуулт сонирхол татаж байна.

Юуны өмнө олон улсад шүүхээс арбитрын хэрэг маргааныг шийдвэрлэхтэй холбоотой ажиллагаанд оролцохдоо агуулгыг нь хянахыг огт дэмждэггүй “*par in parem non habet imperium*”-тэгш этгээд

¹⁶ Alan Redfern and Martin Hunter., “Law and practice of international commercial arbitration” student edition, London 2003. page-344

тэгш этгээдийнхээ дээр эрх мэдэлгүй” гэсэн зарчмыг чухалчилдаг. Нөгөө талаар арбитр нь талууд арбитрын үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох (equal treatment), мэдүүлэх эрх (right to be heard), талуудын гэрээний эрх чөлөөний зарчим (party autonomy), арбитрын ажиллагааны журмыг өөрөө тогтоох (competence-competence), татгалзах эрхээсээ татгалзах, хуулийн хэм хэмжээ хэрэглэхгүйгээр худалдааны зан заншил, сайн санааны зарчим буюу шударга гэж үзсэн ёс зүйн хэм хэмжээг тус тус баримталдаг тул давж заалдах шатны шүүхүүд үүнд маш болгоомжтой хандах учиртай¹⁷.

Тухайлбал, Арбитрын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-т “Талууд тусгайлан тохиролцож эрх олгосон бол арбитрын бүрэлдэхүүн аливаа хуулийг хэрэглэхгүйгээр шударга гэж үзсэн ёс зүйн хэм хэмжээг баримтлан, эсхүл эвлэрүүлэн зуучлах журмаар маргааныг шийдвэрлэнэ” гэж заасныг анхаарууштай.

Арбитр нь талуудын өгсөн зөвшөөрөл дээр тулгуурлан хэрэг шийдвэрлэх журмаа тухайлан тогтоодог тул нотлох баримт бүрдүүлэх хүсэлтийн хувьд шүүх нь тэрхүү журам болон эдгээр зарчим, мөн шүүхээс арбитрын ажиллагаанд хүндрэл, бэрхшээл учруулахгүй байх зарчмын хүрээнд үндэслэлгүйгээр татгалзах эрхгүй.

Харин нотлох баримтыг хамгаалах ажиллагаатай холбоотойгоор шүүхийн оролцоог тус хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.4, 20 дугаар зүйлийн 20.3-т тус тус зааснаар арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах буюу түр арга хэмжээний төрөлд хамааруулж, улмаар арбитрын бүрэлдэхүүн өөрөө нотлох

¹⁷ Эдгээр зарчмын талаар Б.Улаанбаатар, Орчин үеийн арбитрын хөгжлийн чиг хандлага Монголын төр, эрх зүй сэтгүүлийн 2008 оны №4 (56) дугаараас дэлгэрүүлж үзнэ үү.



баримтыг хамгаалахаар зохицуулсан бөгөөд хэрэв талууд энэ талаарх шийдвэрийг нь биелүүлэхгүй бол зөвхөн арбитрчаас харьяа давж заалдах шатны шүүхэд хандахыг 11 дүгээр зүйлийн 11.1-д зааснаар зөвшөөрсөн байна.

Практикт нотлох баримтын хамгаалалт нь үүнээс зохих хуулбар хийж автал устгагдчихгүй байхад чухал ач холбогдолтой байдаг. Жишээлбэл, хэрэв зам, гүүр, далангийн хатуу сууринд хэрэглэгдэх бэхлэлтийн гуалингийн чанар эсвэл бусад гүйцэтгэлтэй холбоотой маргаан гарахад суурь нь хучигдахаас өмнө хөндлөнгийн шинжээчид зарим тэмдэглэлийг хадгалуулсан байхыг зөвлөжээ¹⁸.

Дөрөв. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах (түр арга хэмжээ)

Шүүх, арбитрын хүсэлтээр арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авдаг үндэслэлийг нь арбитр эрх мэдэлгүй байх, арбитрын бүрэлдэхүүн бүрдээгүй байхад аливаа ажиллагааг явуулах боломжгүй, тогтоосон журам нь зөвхөн талуудад үйлчилдэг, хэрэгжүүлэх явцад үр нөлөөгүй байх, “No ex parte” өргөдөл буюу арга хэмжээ авах хүсэлтээ нөгөө талдаа мэдэгдэхгүй байх шаардлага байдаг зэрэгтэй тус тус холбож тайлбарладаг¹⁹.

¹⁸ Sigvard Jarvin, Annette Magnusson, International arbitration court decisions, New York 2006. page-855

¹⁹ UNCITRAL-ийн Загвар хуульд “хамгаалалтын арбитраас гарах шийдвэрийн биелэлтийн баталгаажуулах арга хэмжээ” гэж нэрлэгдсэн байдаг бол Олон Улсын Худалдааны Танхим (ICC)-ын дүрмийн Англи хувилбарт “арбитраас гарах шийдвэрийн биелэлтийн баталгаажуулах эсвэл шилэн хүлэмжийн (хамгаалалтын) арга хэмжээнүүд” Франц хувилбарт “measures ou conservatoires”, олон улсын арбитрын тухай зохицуулсан Швейцарын хуулинд “урьдчилсан эсвэл хамгаалалтын арга хэмжээ” гэж тодорхойлж нэрлэсэн байдаг

Арбитрын тухай хуулийн 19 дүгээр зүйлд зааснаар шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах түр арга хэмжээ гэдэгт маргааныг эцэслэн шийдвэрлэх хүртэл одоогийн байгаа нөхцөл байдлаа хэвээр хадгалах, эсхүл сэргээх, одоогийн, эсхүл учирч болох хохирлыг нэмэгдүүлэх, эсхүл арбитрын ажиллагаанд бэрхшээл учруулах үйлдэл хийхгүй байх, тэдгээрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, арбитрын үндсэн шийдвэрийн биелэлтийг хангахад шаардлагатай байж болох хөрөнгийг хамгаалах арга хэмжээ авах, маргааныг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой, уг маргаантай холбоотой байж болох нотлох баримтыг хамгаалах зэргийг тус тус хамааруулжээ.

Тодруулбал, энэ хуульд зааснаар түр арга хэмжээг арбитр өөрөө авах эрх хэмжээтэй боловч үр дүнгүй буюу шийдвэрийг нь талууд биелүүлэхгүй байгаа тохиолдолд Арбитрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 11 дүгээр зүйлийн 11.1-д тус тус зааснаар харьяа давж заалдах шатны шүүхэд холбогдох хүсэлтийг гаргаж болно.

Үүнээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас ялгаатай дараах онцлог сайн зохицуулалтууд сонирхол татдаг. Үүнд:

Нэгдүгээрт, “status cova” буюу талууд маргалдсан ч тэдгээрийн бусад харилцаа хэвийн байх зарчим юм. Ялангуяа бизнесийн харилцаанд бараа бүтээгдэхүүн бэлтгэн нийлүүлэх, үйлдвэрлэлд хэрэгтэй түүхий эдээр тасралтгүй хангах, хэрэглэгчийн эрх ашгийн үүднээс стратегийн ач холбогдолтой бараа, ажил үйлчилгээний нийлүүлэлтийг зогсоохгүй байх, улс орныг батлан хамгаалах, дэд бүтцийн салбар дахь тогтвортой байдлыг хангах, татварын орлогыг тасалдуулахгүй



байх гэх мэт шалтгаанаар арбитрчаас, аль эсхүл давж заалдах шатны шүүхээс талуудад өмнөх харилцаагаа муутгахгүй байх, сэргээх үүргийг ногдуулж болно.

Хоёрдугаарт, түр арга хэмжээг авахдаа хүсэлт гаргасан байх нь шууд хангах үндэслэл болохгүй юм. Учир нь, дээр дурдсанаар “status cova” зарчмын хүрээнд учирч болох хохирлыг нэмэгдүүлэх, нөгөө талд үндэслэлгүй хохирол учруулахгүй байх, маргаан шийдвэрлэх ажиллагааны явцад дахин маргаан гаргахгүй байх гэх зэрэг үүднээс Арбитрын тухай хуулийн 20 дугаар зүйлд түр арга хэмжээ авахад тодорхой үндэслэл бүрдсэн байхыг шаарддаг.

Гуравдугаарт, арбитр эсхүл түр арга хэмжээг авсан давж заалдах шатны шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг хүлээн авсан анхан шатны шүүх нь түр арга хэмжээ авах хүсэлт гаргасан талаас санхүүгийн баталгаа гаргахыг шаардах боломжтой. Өөрөөр хэлбэл, үүнийг түр арга хэмжээ авагдсан талд учирсан хохирлыг хожим шууд нөхөн төлөх баталгааг хангахтай холбоотой гэж үзэж байна²⁰.

Дөрөвдүгээрт, хэрэв шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ болон урьдчилсан тогтоол гаргасан нь хожим шаардлагагүй байсан нь тогтоогдвол нөгөө талд учирсан хохирлыг арбитрын бүрэлдэхүүн нөхөн төлүүлэхээр ажиллагааны аль ч үед шийдвэр гаргадаг нь талууд болон тэдгээрийн бизнесийн харилцааг хүндэтгэж буй давуу тал юм²¹.

Иймд, харьяа давж заалдах шатны шүүхүүд арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авах тохиолдолд татгалзах нөхцөл байгаа эсэхийг талуудын харилцаа, тэдгээрийн үйл ажиллагааны онцлог шинж, учирсан

²⁰ Арбитрын тухай хууль (2017), 27.

²¹ Мөн тэнд 24, 26.

хохирлыг арбитраас шууд нөхөн төлүүлдэг зэргийг харгалзах ёстой бол, харин арбитр болон давж заалдах шатны шүүхээс авсан түр арга хэмжээг албадан гүйцэтгүүлэх тухай хүсэлтийг шийдвэрлэх анхан шатны шүүх нь хүсэлт гаргасан талаас санхүүгийн баталгаа шаардахдаа ямар шалгуур үзүүлэлтийг урьдчилсан нөхцөл болгох бэ гэдгийг тодорхой болгох хэрэгтэй байна.

Улсын Дээд Шүүхээс Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг хэрхэн хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргаагүй боловч нэхэмжлэгчээс ийм хүсэлт гаргасан тохиолдолд шүүх хангах ёстой, хангахгүй бол тус хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д зааснаар гомдол гаргах эрхийг нь олгох учиртай гэсэн зарчим баримтлах ёстой гэсэн.

Гэтэл нэхэмжлэгч нь тухайн арга хэмжээг авхуулах эрхтэйг үндэслэн авсан боловч хожим нэхэмжлэл нь үндэслэлгүй байх тохиолдолд тэрээр хариуцагчид учирсан хохирлыг барагдуулах зохицуулалттай ч хэн нэгэн этгээд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцагчаар оролцож байгаа нь шууд шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авах үндэслэл биш юм, үүнд тодорхой үндэслэл, шалгуур байх ёстой.

Иргэн, хуулийн этгээдийн аж ахуйн үйл ажиллагаанд мөнгө, эдийн болон эдийн бус хөрөнгийг түргэн шуурхай нэг этгээдээс нөгөө этгээдэд шилжүүлэх нь бизнесийнхэн гол мөн чанар бөгөөд уг шилжилт хөдөлгөөнийг тодорхой үндэслэлгүйгээр хязгаарлах нь маргаанаас маргаан бий болгох хор уршигтай. Тиймээс Иргэний хэрэг шүүхэд хянан



шийдвэрлэх тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасан шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг авахад Арбитрын тухай хуульд заасантай ижил сайн зохицуулалтуудыг тусгах хэрэгтэй байна.

Дүгнэлт

Судалгааны ажлын хүрээнд Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон Улсын арбитрын шийдвэрийг хянасан шүүхийн шийдвэрийн сүүлийн 3 жилийн статистик мэдээнээс үзвэл хэргийн оролцогч нараас гаргасан гомдлын тоо болон арбитрын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдол жил ирэх тусам буурсан үзүүлэлттэй байна²².

Үүнээс дүгнэвэл хэдийгээр 2017 оны Арбитрын тухай хуулиар арбитрын ажиллагаа дахь шүүхийн оролцоог ихэсгэсэн гэж шүүмжилдэг боловч шүүхээс арбитрын хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гардаг байсан зарим нэг алдаа дутагдлыг засдаг болсноор арбитрын ажиллагаа нь зохих ёсоор явагдах эрх зүйн орчин боловсронгуй болсон бөгөөд шүүх нь арбитрын ажиллагаанд оролцохдоо арбитрын үйл ажиллагааны зарчим, мөн чанар, онолыг зөв тайлбарлан хэрэглэж, сайн туршлагыг харгалздаг болсон байна.

Гэвч Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд шүүхээс арбитрын ажиллагаанд оролцохтой холбоотой зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгах хэрэгтэй байна. Ингэснээр Арбитрын тухай хууль, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн холбогдох зохицуулалтыг тус тус тайлбарлан хэрэглэхэд баримтлах

суурь зарчим зөрчигдөхгүй, илүү ойлгомжтой болно.

Өнөө үед байнгын арбитрын байгууллагын төрөл нэмэгдэж байгаатай холбоотойгоор аль арбитр нь уг хэрэг маргааныг хянан шийдвэрлэх бэ гэдгийг өөрсдөө тогтоох нь зөв гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, талууд гэрээндээ үүссэн маргааныг арбитраар шийдвэрлүүлэн гэснийг тухайлан арбитрын нэрийг заагаагүй учир арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцоогүй гэж шууд дүгнэж болохгүй. Арбитрын тухай 18 дугаар зүйлийн 18.1 дэх заалтыг шүүх, аль эсхүл арбитр хянан шийдвэрлэхтэй холбоотой гэж тайлбарлах нь учир дутагдалтай байна.

Энэ тохиолдолд нэгэнт зохигчид маргаанаа шүүхээр бус арбитраар шийдвэрлүүлэхээр тохиролцсон байх тул диспозитив зарчмын хүрээнд маргааны төрлөөс хамаарч /барилгын, спортын, уул уурхай гэх мэт/ аль арбитр нь харьяалан шийдвэрлэвэл зохилтой бэ гэдгийг өөрсдөө тогтоох нь талуудын хүсэл зоригт нийцнэ.

Арбитрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.11-д заасан хэрэглэгчийн эрхтэй холбоотой маргаан гэдгийг чухам юу гэж ойлгохыг нэг мөр болгох хэрэгтэй байна. Мөн стандарт нөхцөл бүхий гэрээнд гайхшируулсан заалт тусгагдсан эсэхтэй холбоотой маргааны хувьд шүүх нь нэхэмжлэлийг арбитрын харьяалалтай гэсэн үндэслэлээр шууд татгалзах нь тийм ч зөв шийдвэр биш, харин нэхэмжлэлийг хүлээн авч, арбитрын хэлэлцээр нь хүчинтэйг тодруулах нь зохимжтой юм.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээг Арбитрын тухай хуульд заасантай ижил буюу

²² 2018 онд 18 гомдол гаргаснаас 8 шийдвэрийг, 2019 онд 9 гомдол гаргаснаас 6 шийдвэрийг, 2020 онд 10 гомдол гаргаснаас 1 шийдвэрийг тус тус хүчингүй болгосон байна.



сайжруулах хэрэгтэй байна. Тодруулбал, нэхэмжлэгчийн хүсэлтээр хариуцагчийн эд хөрөнгийг битүүмжлэх, данс дахь мөнгөн хөрөнгийн зарлагын хөдөлгөөнийг зогсоох, хариуцагчаас эд хөрөнгөтэй холбоотой ямар нэгэн тодорхой ажиллагаа явуулахыг нэхэмжлэлийн үнийн дүнгийн хэмжээгээр хориглох зэрэг арга хэмжээг авахдаа тодорхой шалгуур хэрэгтэй байна.

Ном зүй:

1. Арбитрын сэдэвт эрдэм шинжилгээний нийтлэл 2020 он, эмхэтгэл
2. Үндэсний арбитр сэтгүүл, №02 (05),
3. "UNCITRAL"-ын загвар хууль,
4. A.Redfern, M.Hunter, N.Blackaby and C.Partasides., "Law and practice of international commercial arbitration" fourth edition.,London, 2004,
5. Үндэсний арбитр сэтгүүл: №03(08), УБ 2005,
6. Арбитрын сэдэвт эрдэм шинжилгээний нийтлэл 2020 он,
7. Олон улсын арилжааны арбитр ба олон улсын худалдааны эрх зүйн актын эмхэтгэл, 2006 он,
8. Очи Ай Сэйчи, Компанийн эрх зүйн үндсэн ойлголт,
9. Alan Redfern and Martin Hunter., "Law and practice of international commercial arbitration" student edition, London 2003,
10. Монголын төр, эрх зүй сэтгүүлийн 2008 оны №4 (56),
11. Sigvard Jarvin, Annette Magnusson., International arbitration court decisions, New York 2006.

**Abstract****ISSUES CONCERNING ARBITRARY ACTIVITIES
IN THE CIVIL PROCEDURE CODE****B.MANDALBAYAR***Judge of First Instance civil court
at Bayanzurkh district*

This article aims to provide an understanding of courts involvement in arbitration proceedings, and to introduce the application and some issues related

to applying some regulations of the Civil Procedure Code and the Law on Arbitrary in practice.



**ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ
АРГА ХЭМЖЭЭ БА ХҮНИЙ ЭРХ**

CONFINEMENT UNDER GUARD AND HUMAN RIGHTS

Л.ГАЛБАДАР¹

¹ Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.Галбадар, Хууль зүйн магистр /LL.M./



ЦАГДАН ХОРИХ ТАСЛАН СЭРГИЙЛЭХ АРГА ХЭМЖЭЭ БА ХҮНИЙ ЭРХ

Л.ГАЛБАДАР. Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгч Л.Галбадар, хууль зүйн ухааны магистр /И.М./

Хураангуй

Эрүүгийн процесс ажиллагааны үед цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь хүний эрхийг хамгийн өндөр түвшинд зөрчих боломжийг бий болгодог албадлагын арга хэмжээ болохын хувьд түүнийг эрүүгийн процесс ажиллагааны үед гарцаагүй, зайлшгүй тохиолдолд хамгийн эцсийн арга хэмжээ болгож хэрэглэхийн зэрэгцээ түүнийг хэрэглэх үндэслэл, журмыг хууль тогтоогч тодорхой хуульчлах шаардлагатай. Мөн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг аль болох богино хугацаатай байхаар тогтоох нь эрүүдэн шүүх, залхаан цээрлүүлэх, хүний эрхийн аливаа зөрчлүүд бий болохоос урьдчилан сэргийлнэ.

Түлхүүр үг

Таслан сэргийлэх арга хэмжээ, хүний эрх, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ, түүнийг хэрэглэх үндэслэл, журам, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа,

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол Улсын иргэн халдашгүй, чөлөөтэй байх эрхтэй. Хуульд заасан үндэслэл, журмаас гадуур дур мэдэн хэнийг ч нэгжих, баривчлах, хорих, мөрдөн мөшгөх, эрх чөлөөг нь хязгаарлахыг хориглоно гэж заажээ. Хүний халдашгүй эрх гэдэг нь өөрийнх

нь жам ёсны шинж чанараас үүдэлтэй бөгөөд хуулиар баталгаажсан, хэн боловч хөндлөнгөөс дур мэдэн халдаж үл болох туйлын агаад салшгүй эрхийн цогцолбор мөн.¹

Монгол Улсын Үндсэн хуульд тусгалаа олж, хүний эрхийн олон улсын баримт бичгүүдэд баталгаажсан хүний халдашгүй байх эрхийг хязгаарлах үндэслэл нь гагцхүү хуульд заасан тохиолдолд түүнийг хууль зүйн үндэслэл бүхий шийдвэрээр хязгаарлах ажиллагаа байх учиртай.

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа нь императив хэм хэмжээг агуулсан буюу нэг талд нь төр, түүнийг төлөөлөн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхийг хэрэгжүүлж буй шүүх, прокурор, мөрдөх алба зэрэг болоод эрүүгийн процесст оролцож буй оролцогч нарын харилцааг зохицуулсан хууль, эрх зүйн цогц зохицуулалт болохын хувьд албадлага хэрэглэх боломж, зохицуулалтуудыг агуулсан байдаг. Сүүлийн жилүүдэд уг арга хэмжээний зорилго, зарчмыг хууль ёсны гэхээсээ илүү хүний эрхийн хэм хэмжээ, стандартыг хэрхэн хангаж байгаатай холбон авч үзэх болжээ. Америкийн профессор Дэвид Вейсборд "...Аливаа хүнийг гэмт хэргийн

¹ Ж.Болдбаатар, Ж.Бямбаа нар. Хамтын бүтээл. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. Уб., 2009. 90 дэх тал.



сэжигтнээр татахад тухайн хувь хүн эрх чөлөөгөө гэлтгүй бусад эрхээ алдах өндөр эрсдэлтэй байдаг” гэж мөн бичсэн байна.²

Үүний дотор таслан сэргийлэх арга хэмжээ нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх хуулиар тусгайлан тогтоосон албадлагын арга хэрэгслийн цогц бүрдэл³ юм. Үүнээс цагдан хорих нь бусад төрлийн таслан сэргийлэх арга хэмжээтэй харьцуулахад яллагдагч, шүүгдэгчийн эрх, эрх чөлөөг их хэмжээгээр хязгаарладаг хамгийн хатуу арга хэмжээ гэж тодорхойлжээ.⁴

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хуульд заасан тодорхой үндэслэл бий болсон бол хөнгөн, хүнд зэрэг гэмт хэргийн ангилал хамаарахгүйгээр хэрэглэх, эсхүл тухайн гэмт хэрэгт оногдуулах ялын төрөл, хэмжээнээс хамааруулан цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх гэсэн үндсэн хоёр төрлийн зохицуулалтыг агуулж байна.

2002 болон 2015 оны Эрүүгийн процессын хуулиуд дахь цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний талаарх зохицуулалтуудыг харьцуулж үзэхэд 2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд хэргийн бодит байдлыг тогтооход саад учруулах, гэмт хэрэг дахин үйлдэхээс сээрэмжлэх зорилгоор гэж таамаглалд тулгуурлан цагдан хорих арга хэмжээг хэрэглэх боломжийг бүрдүүлсэн, мөн хэдийгээр тухайн хуулийн 68 дугаар зүйлийн 68.2 дахь хэсэгт хөнгөн хэрэгт цагдан хорих арга хэмжээг хэрэглэх талаар зохицуулаагүй боловч 68.9 дэх

² Д.Баярсайхан. Эрүүгийн процессын албадлага ба хүний эрх. УБ., 2018. 8 дахь тал.

³ Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. УБ., 2018. 136 дахь тал.

⁴ Мөн тэнд. 142 дахь тал.

хэсэгт хэрэглэх боломжийг хуульчилсан зохицуулалтыг агуулж байжээ. Цагдан хорих үндсэн хугацааг сэжигтэн, яллагдагчийн хувьд ялгамжтай тогтоож хуульд заасан хугацааны дотор хүртэл гэсэн томъёоллоор хуульчилж өгсөн нь шүүх өөрийн эрх хэмжээний хүрээнд цагдан хорих арга хэмжээний үндсэн хугацааг сонгох боломжийг бүрдүүлсэн, цагдан хорих арга хэмжээг хүнд, онц хүнд хэрэгт хэрэглэх, эсхүл удаа дараа ял шийтгэгдэж байсан этгээд, онц аюултай гэмт хэрэгтэн дахин гэмт хэрэгт сэрдэгдсэн зэргээр тухайн сэжигтэн, яллагдагчийн хувийн байдалд хамааруулж цагдан хорих арга хэмжээг хэрэглэхээр хуульчилсан онцлогтой байжээ. Харин 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт тухайн гэмт хэрэгт оногдуулж болох хорих ялын хэмжээ, яллагдагчийн хувийн байдал, үйлдэгдсэн гэмт хэргийн шинжийг харгалзан эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн цагдан хорих арга хэмжээг авч болохоор хуульчилсан нь тухайн гэмт хэргийн шинж, яллагдагчийн хувийн байдал зэрэг шалгуур үзүүлэлтэд тулгуурлаж шүүгч эрх зүйн ухамсар, өөрийн дотоод итгэлд тулгуурлан хэрэглэх боломжтой зохицуулалтыг агуулжээ.

Мөн 2002 болон 2015 оны процессын хуулиудад цагдан хорих арга хэмжээний хугацааг сунгахдаа хэргийн ээдрээ төвөгтэй байдал гэх адил үндэслэл дэвшүүлж, харин 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд цагдан хорих нийт хугацааг 5 жилээс дээш хугацаагаар хорих ял оногдуулахаар заасан хэрэгт 18 сар байхаар заасан нь өмнөх процессын хуулиас харьцангуй бага хугацааг тогтоож өгсөн давуу талтай гэж дүгнэх үндэслэлтэй юм.



2002 оны Эрүүгийн байцаан шийтгэх хуульд цагдан хорих арга хэмжээг хэрэглэж буй практик, хуулийн зохицуулалтын талаар шүүгч Л.Оюунчимэг "...цагдан хорих үндэслэл шаардлагыг улам бүр нарийвчлах замаар өргөн хүрээнд хэрэглэх хандлагыг өөрчлөх, ...цагдан хорих нийт хугацааг зөв тооцоход анхаарах, сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчээр цагдан хоригдвол зохих нийт хугацаа нь тухайн төрлийн гэмт хэргийн цагдан хорих хугацааны дээд хэмжээнээс хэтрэх ёсгүй атал сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийн цагдан хоригдсон хугацааг тус тусдаа байх мэтээр ойлгон нийт цагдан хоригдсон хоногийг буруу тооцсоны улмаас цагдан хорих хугацааг хэтрүүлэх асуудал гарсаар байна⁵" гэсэн бол судлаач Л.Өлзийлхам нарын судалгааны тайланд "...Цагдан хорих арга хэмжээг хангалттай нотлох баримтад тулгуурлахгүйгээр "оргон зайлж болзошгүй" гэх мэт субъектив байдлаар авах бололцоог бүрдүүлж байгаа эрх зүйн үндэслэлийг хуульдаа нарийвчлан суулгаж өгөх, практикийг сайжруулах, Хүндэвтэр гэмт хэргийн сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчид цагдан хорих арга хэмжээг хэрэглэхгүй байх, Цагдан хорих арга хэмжээг олон улсын шүүхийн практикт хэрэглэж буй үндэслэл нь гэмт хэрэгт сэжиглэгдсэн этгээдийг шаардлагатай үед хууль, шүүхийн байгууллагын өмнө авчрах явдал байдаг бөгөөд хорьж буй хугацааны хувьд богино байдаг. Иймд цагдан хорих арга хэмжээн дэх хугацааг олон улсын стандартын дагуу багасгах"⁶ зэрэг

саналыг дэвшүүлсэн байна.

Эрүүгийн процесс ажиллагааны зорилт нь гэмт хэргийг шуурхай, бүрэн илрүүлэх, гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг олж тогтоон шударгаар ял оногдуулах, гэм буруугүй хэнийг ч гэмт хэрэг үйлдсэн гэм буруутайд тооцохгүй байх, хүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн эрхийг сэргээхэд оршдог. Нэг талаас гэмт хэрэг үйлдсэн этгээдийг олж илрүүлэхээс түүнд ял оногдуулах хүртэл өргөн хүрээг хамарсан ажиллагааны явцад гэмт хэрэгт сэрдэгдсэн, гэмт хэрэг үйлдсэн гэж үзэж прокурорын тогтоолоор яллагдагчаар татагдсан хүнд эрүүгийн процесс ажиллагааны зорилтыг хангах, саадгүй явуулах үүднээс тохирох таслан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай. Гэмт хэрэг үйлдсэн хүнд тохирох төрлийн таслан сэргийлэх арга хэмжээг зөв сонгон авч хэрэгжүүлэх нь тухайн хүнийг дахин гэмт хэрэг үйлдүүлэхгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулахгүй байх зорилгыг хангах бол мөн тухайн хүний эрхийг зөрчигдөхгүй байх урьдач нөхцөлийг хангах баталгаа болдог.

Цагдан хорих арга хэмжээ нь эрх зүйн мөн чанарын хувьд ял шийтгэл биш төдийгүй заавал авах ёстой арга хэмжээ ч биш юм. Гол нь ноцтой гэмт хэрэг үйлдсэн зарим этгээдийг мөрдөн байцаах ажиллагаанд саад хийхээс сэргийлэх онцгой тохиолдолд түр хугацаанд авдаг арга хэмжээ юм.⁷ Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ нь гэмт хэргийг

⁵ Л.Оюунчимэг. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ: Шүүхийн практик анхаарах зарим асуудал. Шүүх эрх мэдэл сэтгүүл. Уб., 2015. №1. 86-87 дахь тал.

⁶ Э.Өлзийлхам, Х.Билгүүнзаяа, А.Ариунболд. ЦАГДАН ХОРИХ АРГА ХЭМЖЭЭГ ШИЙДВЭРЛЭЖ БУЙ ШҮҮХИЙН ПРАКТИК БА ХҮНИЙ ЭРХИЙН ХЭРЭГЖИЛТ. Бодлогын судалгааны тайлан. Уб., 2014.Эх сурвалж:

<http://resource3.sodonvision.com/shuuh/file/2014/10/bb8abrahcjcjwn3u9xmnvzp7/Цагдан%20хорих%20арга%20хэмжээг%20хэрэгжүүлж%20байгаа%20шүүхийн%20практик%20ба%20хүний%20эрх.pdf>

⁷ Д.Баярсайхан. Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн процессын эрх зүйн шинэтгэлийн асуудлууд. Уб., 2019. 209 дахь тал.



шалгах ажиллагааны үед авагддаг буюу хэрэгт нотлох баримтууд бүрэн цуглаж гэм бурууг хэлэлцэх боломж хараахан бүрдээгүй, шүүхээр гэм буруу нь эцэслэн тогтоогдоогүй байхад хэрэглэгддэг. Энэхүү шинжээрээ хүний эрхийг шууд зөрчих боломжийг бүрдүүлдгийн хувьд хугацааг богино тогтоож өгөх нь хүний эрхийг зөрчих болзошгүй зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ болно. Энд болзошгүй гэж буйн учир нь мөрдөх ажиллагааны явцад цугларсан нотлох баримт нь тухайн хүнийг гэм буруутайг тогтоосон тохиолдолд Эрүүгийн хуулийн ерөнхий ангид зааснаар цагдан хоригдсон хугацаа нь эдлэх ялд орж тоологдоод явах бол гэм буруугүйд тооцогдсон тохиолдолд энэ төрлийн арга хэмжээг хэрэглэсэн нь өөрөө хүний эрхийг зөрчсөн зөрчилд тооцогдохын зэрэгцээ гэм буруугүй хүний эрх чөлөөг тодорхой хугацаагаар хязгаарласан, үндэслэлгүйгээр хорьсон асуудал үүсч буйг бас анхаарч үзэх нь зүйтэй. Мөн үүнээс гадна анх эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан зүйл анги хөнгөрч өөрчлөгдөх, хорих ял оногдуулахгүй эрүүгийн хэрэгт гэм буруутай нь тогтоогдох нөхцөлд ч мөн хүний эрхийн зөрчил болохыг анхаарах нь чухал байна. Иймээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг дэлхийн жишигт нийцүүлэн богино хугацаагаар тогтоож өгөх хэрэгцээ шаардлага үүсч байгаа юм.

Дэлхийн зарим улсын эрүүгийн процессын хууль дахь цагдан хорих арга хэмжээний зохицуулалт доторх цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ хэрэглэх хугацааг харьцуулан судалж үзэхэд Герман улсын хувьд эрүүгийн процессын хуулийн 121-р зүйлд зааснаар цагдан хорих арга хэмжээ нь хуульд заасан үндэслэлээр 6 сар хүртэл байх бөгөөд түүнээс цааш

сунгахыг зөвхөн онцгой тохиолдолд шүүхийн хэлэлцүүлгээр шийддэг байна. Германд жилд дунджаар 6 сараас дээш хугацаагаар цагдан хоригдсон тохиолдолд нийт цагдан хоригдсон байдлыг 23 хувийг эзэлж байгаагийн дээр 75 орчим хувь нь 1-6 сарын хугацаанд хоригдсон байх ажээ.⁸ ОХУ-ын хувьд цагдан хорих арга хэмжээний ерөнхий хугацаа нь 2 сар байх бөгөөд цаашид нэмж сунгах зайлшгүй шаардлага бий болсон үед мөрдөн байцаах албаны даргын болон прокурорын зөвшөөрлөөр дахин 6 сар хүртэл хугацаагаар сунгаж болно. Түүнчлэн онц хүнд гэмт хэргийн хувьд эрүүгийн процесс ажиллагааны хэвийн, шуурхай байдлыг хангахын тулд дахин 12 сар хүртэл хугацаагаар сунгаж болно.⁹ БНСУ-ын Эрүүгийн процессын хуулийн¹⁰ 92 дугаар зүйлд цагдан хорих хугацаа нь 2 сар байхаар тогтоож цаашид үргэлжлүүлэн хорих шаардлагатай гэж үзвэл цагдан хорих хугацааг шүүх хоёр удаа 2 сараар сунгах эрхтэй гэж заажээ. Нийт цагдан хорих хугацааг гурваас олон удаа сунгахыг хориглосон байна. Япон улсын хувьд эрүүгийн процессын хуульд¹¹ үндсэн хугацаа нь 2 сар хүртэл байхаар заажээ.

Манай улсын хувьд цагдан хорих нийт хугацааг 30 хүртэл сараар тогтоож байсныг 2015 оны Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд дээд тал нь 18 хүртэл сар, онцгой тохиолдолд нэмж 6 сарын хугацаагаар сунгахаар зохицуулсан нь цагдан хорих нийт хугацааг харьцангуй багасгасан гэж

⁸ Д.Баярсайхан. Эрүүгийн процессын албадлага ба хүний эрх. Уб., 2018. 58-59 дахь тал.

⁹ Д.Баярсайхан. Эрүүгийн процессын албадлага ба хүний эрх. Уб., 2018. 63-64 дахь тал.

¹⁰ https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=22535. Criminal procedure act.

¹¹ <http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=3364&vm=02&re=02> Code of criminal procedure.



үзэх үндэслэлтэй боловч энэ нь дэлхийн жишиг хандлагаас өндөр байна.

2017-2021 оны хооронд шүүхээс

цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авагдсан байдлыг хугацааны шалгуур үзүүлэлтээр харуулбал:

Он	Нийт цагдан хоригдсон хүмүүсийн тоо	2-с 3 сар дээш хугацаагаар цагдан хоригдсон хүмүүсийн тоо	3 сараас дээш хугацаагаар цагдан хоригдсон хүмүүсийн тоо
2017	875	115	121
2018	1279	264	168
2019	1342	216	252
2020	1169	236	360
2021	1024	167	268

Энэхүү хүснэгтээс харахад 3 сараас дээш хугацаагаар хоригдож буй хүмүүс нийт цагдан хоригдсон хүмүүсийн дотор эзлэх хувь их байгааг харж болно.

Харин шүүхээс цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг авч буй үндэслэлээр харуулбал:

Цагдан хорих арга хэмжээ авч буй үндэслэл	2017	2018	2019	2020
эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан	34.7	25.0	26.8	30.8
шүүгч, прокурор, мөрдөгч, хохирогч, гэрч, шинжээч, гэмт хэрэг хамтран үйлдсэн хүнийг дарамталсан, сүрдүүлсэн, эсхүл тэдгээрийн болон өөрийн амь нас, эрүүл мэндэд аюул учруулах үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа	2.5	5	3.93	4.8
гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт, мэдээлэл байгаа	5.7	30.5	32.8	17.8
урьд нь авсан таслан сэргийлэх арга хэмжээг зөрчсөн, шүүх, прокурорын мэдэгдэх хуудсаар дуудахад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ирээгүй	11.3	24.8	16.7	27.0
эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн	36.9	14.3	19.8	19.6

Дээрх судалгаанаас харахад цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч буй үндэслэлийн дийлэнхийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас оргон зайлахыг завдсан, оргон зайлсан, гэмт хэрэг үйлдэж болзошгүй талаар үндэслэл бүхий баримт мэдээлэл байгаа, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зорилгод нийцүүлэн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авсан шийдвэрүүд эзэлж байна.

Хүний эрхийг хязгаарлаж буй цагдан хорих арга хэмжээ авах үндэслэлийг тодорхойлж буй хуулийн зүйл, хэсэг, заалт нь туйлын ойлгомжтой, хийдэл зөрчилгүй, хэл зүйн хувьд тодорхой, тайлбарлах шаардлагагүй, салаа утгагүй, үгийн шууд утгаар нэг мөр хэрэглэх, маргах боломжгүйгээр томъёологдсон байх шаардлагатай. Гэтэл оргон зайлахыг завдсан, гэмт хэрэг үйлдэж болзошгүй эрэг томъёолол нь хийсвэрлэл, төсөөлөл,



таамаглал, сэжиглэлд тулгуурласан зохицуулалтыг агуулж байгааг дурдах нь зүйтэй. Тодруулбал оргон зайлсан буюу мөрдөн шалгах ажиллагаанд саад учруулах бодитой үйлдэл хийгдсэн, нэр, хаяг, хувийн мэдээллүүдээ өөрчилж зориуд санаатайгаар эрүүгийн хариуцлагаас зайлсхийсэн, гадаад улсад удаан хугацаагаар зорчсон, олон улсын хэмжээнд эрэн сурвалжлагдсан, яллагдагчийг эрэн сурвалжлах талаар ажиллагааг хийж гүйцэтгэх, олж илрүүлэх арга хэмжээг бодитойгоор явуулсан зэрэг нөхцөл байдлуудыг наад заах нь шаардах нь зүйтэй. Харин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэх нэр томъёоноос татгалзаж гэмт хэрэг дахин үйлдсэн, тэр дундаа санаатай гэмт хэрэг дахин үйлдсэн гэж томъёолох нь маргаангүй, илэрхий шууд ойлгогдох хуулийн томъёололд илүү нийцнэ гэж үзэж байна. Мөн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацааг сунгах үндэслэл болох хэргийн ээдрээ төвөгтэй байдал гэх ойлголт нь өргөжүүлж эсхүл явцууруулан тайлбарлаж хэрэглэдэг. Шүүхийн практикаас гадна хуульчдын дунд нэг мөр ойлгосон ойлголт тогтоогүй, хэл зүйн хувьд сонгож авсан нэр томъёо нь олон салаа утгаар тайлбарлагддаг. Мөн хэт ерөнхий нэр томъёо байх тул цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа сунгах үндэслэлийг тодорхойлохдоо үгийн шууд утгаар тайлбарлан хэрэглэх боломжтой, салаа утгагүй, илэрхий ойлгомжтой нэр томъёог хуульчлан хэрэглэх, эсхүл ээдрээ төвөгтэй гэх ойлголтод хамаарах нөхцөл байдлуудыг хуулийн албан ёсны тайлбар гаргах замаар тодорхойлох хэрэгцээ шаардлага бий болсон байна. Мөн цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээний үндсэн хугацааг 1 сар байна гэж зохицуулсан нь хэт хатуу, сонгох боломжгүй зохицуулалт болж

байгаа бөгөөд яллагдагчийн хувийн байдал, гэмт хэргийн шинж, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэж буй үндэслэл зэргээс хамаарч 1 сараас бага хугацаагаар хэрэглэх боломжийг бүрдүүлэх шаардлагатай. Мөн нийт цагдан хорих хугацаа нь дэлхийн улсуудын жишгээс өндөр байгаагийн зэрэгцээ илтгэлд авсан судалгаанаас харахад 3 сараас дээш хугацаагаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх явдал дийлэнхийг нь эзэлж байна. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэглэх нь удаан хугацаагаар хорьж залхаан цээрлүүлэх, эрүүдэн шүүх арга хэрэгсэл болох бус харин эрүүгийн хэрэг мөрдөх ажиллагааг хурдан шуурхай явуулах хэрэгсэл болох учиртай. Иймээс нийт цагдан хорих хугацааг онцгой цөөн төрлийн гэмт хэрэгт 12 сар хүртэл, нийтлэг байдлаар 3 сараас хэтрэхгүй 6 сар хүртэл хугацаагаар хэрэглэхээр зохицуулах нь хүний эрхийн зөрчил үүсэхээс урьдчилан сэргийлсэн алхам болно гэж дүгнэж байна.

Ном зүй

Д.Баярсайхан. Эрүүгийн процессын албадлага ба хүний эрх. Уб., 2018. 8 дахь тал.

Д.Баярсайхан. Эрүүгийн эрх зүй, Эрүүгийн процессын эрх зүйн шинэтгэлийн асуудлууд. Уб., 2019.

Ж.Бямбаа, Ж.Эрхэсхулан. Эрүүгийн процессын эрх зүйн үндсэн асуудал. Уб., 2018.

Ж.Болдбаатар, Ж.Бямбаа нар. Хамтын бүтээл. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. Уб., 2009.

Л.Оюунчимэг. Цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ: Шүүхийн практик анхаарах зарим асуудал. Шүүх эрх мэдэл сэтгүүл. Уб., 2015. №1.



Э.Өлзийлхам, Х.Билгүүнзаяа,
А.Ариунболд. ЦАГДАН ХОРИХ АРГА
ХЭМЖЭЭГ ШИЙДВЭРЛЭЖ БУЙ
ШҮҮХИЙН ПРАКТИК БА ХҮНИЙ ЭРХИЙН
ХЭРЭГЖИЛТ. Бодлогын судалгааны
тайлан. УБ., 2014.

Ашигласан вэб сайт:

[https://elaw.klri.re.kr/eng_service/
lawView.do?lang=ENG&hseq=22535](https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=22535)
Criminal procedure act.

[http://www.
japaneselawtranslation.go.jp/law/
detail/?id=3364&vm=02&re=02](http://www.japaneselawtranslation.go.jp/law/detail/?id=3364&vm=02&re=02) Code of
criminal procedure.



**ШҮҮХЭД ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД
ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ**

Бадарчийн МАРИНА¹

¹ Хэнтий аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн Ерөнхий шүүгч, Хууль зүйн магистр /LL.M./



ШҮҮХЭД ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ

Б.МАРИНА. Хэнтий аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн ерөнхий шүүгч, хууль зүйн ухааны магистр /И.М./

Монгол улсад сүүлийн жилүүдэд иргэд олон нийтийн эрх зүйн мэдлэг дээшилж, эрхийн мэдрэмж өндөрссөнтэй холбоотойгоор хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан гомдол, санал гаргах явдал нэмэгдэж байна. Нөгөө талаас энэ байдал нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны процессын хууль, тогтоомжууд практикт хэрхэн хэрэгжиж байгааг судлах нөхцөлийг бүрдүүлж өгч байна.

Манай улсын тулгуур, суурь хууль болох Үндсэн хуульд шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, бүрэн эрх, үйл ажиллагааны эрх зүйн үндэс, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх баталгааг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулдаг, харин Шүүхийн тухай хуульд шүүгч нь “хууль дээдэлж хуулийг хэрэглэх” үндсийг тодорхойлж өгсөн байдаг.

Ер нь шүүгч хууль хэрэглэнэ гэдэг нь хуулийг тайлбарлахын нэр юм. Энэ явцад мэдээж эрх зүйн үр дагавар үүсгэнэ. Үүнийг хэрэг маргааныг шийдвэрлэх гэж ойлгож болно. Товчхондоо тухайн үйл баримт хуулийн ямар зүйл заалтад нийцэж ямар үр дагавар үүсгэхийг тодорхойлно гэсэн үг юм. Амьдралд тохиолдож болох бүх тохиолдлыг хуулиар зохицуулах боломжгүй. Амьдралын нэг талыг бодоод хууль тогтооход нөгөө талд нь өөр зүйл

үүсч бий болж байдаг. Шүүгч хуулийг тайлбарлан хэрэглэхдээ тодорхой арга, дүрэм, зарчмын дагуу хууль тогтоогчийн санаа бодлыг алдагдуулахгүй байх, эрх зүйн суурь өөрчлөлт хийхгүй байх, хүний үндсэн болон салшгүй эрхийг дордуулахгүй байх, ухаалаг байх гэх мэт зарчмыг баримталдаг. Шүүгчийн ухаан чадал, чанар чансаа, өөр хэлж болох бүх аугаа зүйлийн охь, оргил нь хууль тайлбарлах чадвартай холбоотой. Энэ нь шүүгч аливаа хэрэг маргааныг дур зоргоороо биш, зөвхөн хуулийг хэрэглэж, хууль зүйн үндэслэлээр, хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэйг тодорхойлсон гэж үзэж болно.

Миний бие иргэний хэрэг дагнан хянан шийдвэрлэдэг шүүгчийн хувьд хууль хэрэглээний явцад хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд байнга биш ч практикт гардаг нэгэн асуудлыг хөндөхийг хүссэн. Энэ нь орон нутагт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчийн орон тоотой холбоотой, шүүгч татгалзан гарснаас үүсэх үр дагаврын асуудал юм.

Шүүгч бүр хэрэг, маргааныг хувийн эсхүл аливаа бусад ашиг сонирхлын үүднээс бус, хууль болон нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэх үүрэгтэй гэдгээ ухамсарладаг, энэхүү үүргээ биелүүлэхдээ хараат бус,



зарчимч, шударга байж, төвийг сахидаг. Түүнчлэн шүүгч ямар нэг хувийн ашиг сонирхол эсхүл ялгаварлан гадуурхах хандлагагүйгээр хуулиар хүлээсэн шүүн таслах, хэрэг хянан шийдвэрлэх үүргээ биелүүлэх бөгөөд хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх талаарх ямар нэгэн урьдчилсан хандлагаас чөлөөлөгдөж, түүнээс ямагт ангид байж шийдвэрээ гаргадаг байх үүрэг хүлээдэг. Учир иймд шүүгчийн биелүүлэх ёстой хараат бус, зарчимч, шударга байх, төвийг сахих зарчимтай зөрчилдөх эсхүл тийнхүү ойлгогдох нөхцөл байдал бий болсон тохиолдол бүрт шүүгч тухайн хэрэг, маргааныг шийдвэрлэхэд оролцож болохгүй тул шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гардаг.

Тухайлбал гол эх сурвалж болж буй хуулийн зохицуулалтыг жагсаавал: Үндсэн хуулийн дөчин ес дүгээр зүйл, Шүүхийн тухай хуулийн 51 дүгээрийн 51.1, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 84 дүгээр зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 10.1 дүгээр зүйл, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлд заасан татгалзан гарах үндэслэл байвал шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанаас татгалзан гарч, хуульд заасан үүргээ биелүүлэх ёстой. Энэ нь тухайн татгалзан гарч буй шүүгчийн ёс зүйтэй шууд холбоотой. Харин эдгээр үндэслэлээс бусад үндэслэлээр шүүгчийг татгалзаж үл болно гэж хуульд тодорхой зааж өгсөн байгаа.

Өөрөөр хэлбэл шүүгч хуулиар хүлээсэн шүүгчийн албаны чиг үүргээ бодитой, шударга, төвийг сахиж, хараат бусаар гүйцэтгэхэд нь саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал тухайн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана. Үүнээс гадна

Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах татгалзлын талаар процессын хуулиудад зааснаас илүү нарийвчлан дэлгэрүүлж зохицуулсан байдаг ба үүнийг бид бас зайлшгүй мөрдөх ёстой юм. Өөрөөр хэлбэл шүүгч нь тухайн тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад жишээ нь ашиг сонирхлын зөрчилтэй байдал илэрвэл хэрхэх, татгалзах эсэх талаар процессын хуулиудад ерөнхий байдлаар хуульчлан зохицуулсан байдаг бол Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэмд илүү нарийвчлан зохицуулсан байдаг.

Ийм учраас шүүгч хуулиар хүлээсэн шүүгчийн үүргээ бодитой, шударга, төвийг сахиж гүйцэтгэхэд нь саад учруулах үндэслэл бүхий эргэлзээ байвал тухайн хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзана.

Одоо үйлчилж буй Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.8-д “Ерөнхий шүүгч дангаар хэрэг хянан шийдвэрлэх явцад түүнийг татгалзсан буюу тухайн шүүхийн бүх шүүгчдийг татгалзсан бол шүүгчдийн зөвлөгөөн олонхын саналаар шийдвэрлэн тогтоол гаргана” гэж, мөн хуулийн 93 дугаар зүйлийн 93.1-д “Шүүх бүрэлдэхүүн буюу шүүгчийг татгалзан гаргах хүсэлтийг хангасан бол хэргийг өөр шүүх бүрэлдэхүүн, шүүгч шийдвэрлэнэ”, 93.2-д “Тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан, эсхүл бүх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьд оролцож дахин оролцох боломжгүй болсон тохиолдолд хэргийг адил шатны өөр шүүхээр шийдвэрлүүлэхээр тухайн шатны Ерөнхий шүүгч захирамж гаргаж шилжүүлнэ” гэж тус тус заасан байдаг. Энэ нь “тухайн шүүхийн бүх шүүгчийг



татгалзан гаргасан”, “бүх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьд оролцож дахин оролцох боломжгүй”, “шүүх бүрэлдэхүүнд оролцох шүүгч хүрэлцэхгүй” гэсэн шаардлагууд нь дангаар болон давхацсан байдлаараа ч гэсэн шүүхийн бүх шүүгчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох боломжгүй болох үндэслэл болно.

Үүнтэй уялдан дурдагдаж буй хуулийн 170 дугаар зүйлийн 170.1-д “Зохигч, гуравдагч этгээд, тэдгээрийн төлөөлөгч буюу өмгөөлөгч энэ хуулийн 20.1, 38.9, 65.1.1-65.1.8, 65.1.10, 69.1, 92.4, 97.1, 100.2 дахь хэсэг, 80, 117, 124 дүгээр зүйлд заасан шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт гарсан өдрөөс нь хойш 10 хоногийн дотор тухайн шатны шүүхэд гомдол гаргаж болно”, 171 дүгээр зүйлийн 171.1-д “Шүүхийн тогтоол, шүүгчийн захирамж, шийтгэвэрт энэ хуулийн 170.1-д заасны дагуу гаргасан гомдлыг 14 хоногийн дотор тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэж тогтоол гаргана” гэж заасан байдаг.

Энэхүү хуулийн заалтуудаар зохицуулагдсан харилцаа дээр ажиллагаа явуулахад орон нутгийн шүүхүүдэд ажиллаж буй шүүгчийн орон тоо цөөн тул бэрхшээлтэй байдаг. Учир нь одоогийн байдлаар орон нутагт байрлах эрүү, иргэний хэргийн анхан шатны шүүхүүд, давж заалдах шатны шүүхүүд бүгд нэг ерөнхий, хоёр шүүгчтэй, нийт 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллаж байгаа. Энэ тохиолдолд Иргэний хэргийн анхан шатны шүүхийн хувьд жишээ авахад:

1. Гурван шүүгчийн нэг шүүгч нь урт хугацаагаар өвчтэй, чөлөөтэй, эсхүл ээлжийн амралттай үед хоёр шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр ажиллана. Энэ

тохиолдолд нэг шүүгчид хуваарилагдсан хэрэгт тус шүүгч нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 91 дүгээр зүйлийн 91.1.4-д зааснаар “ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон” гэх үндэслэлээр өөрөө татгалзан гарах хүсэлт гаргасныг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 98 дугаар зүйлийн 98.2-д зааснаар тухайн шүүгчдийн зөвлөгөөний тогтоолоор хангаж шийдвэрлэжээ. Иймд хэрэг хуваарилах журмын дагуу тус хэрэг нөгөө шүүгчид шилжихэд түүний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гаргасан шүүгчийн захирамжид зохигчдоос гомдол гаргасан тохиолдол гарна.

Энэ тохиолдолд зарим шүүхүүдийн практикт “...Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2-д зааснаар тухайн шүүх нь 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг бөгөөд 1 шүүгч нь ээлжийн амралттай, нэг шүүгч нь тус хэрэгт татгалзан гарах хүсэлт гаргасныг шүүгчдийн зөвлөгөөнөөр хангаж шийдвэрлэсэн. Иймд шүүгчийн захирамжид гаргасан гомдлыг 171.1-д зааснаар тухайн хэргийг хянан шийдвэрлэж байгаа шүүгчийг оролцуулахгүйгээр 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэйгээр хянан шийдвэрлэх шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй байна...” гээд тухайн шүүхийн ерөнхий шүүгч адил шатны шүүх рүү гомдлыг хянан шийдвэрлүүлэхээр шилжүүлдэг.

Гэтэл энэхүү тохиолдолд татгалзан гарсан шүүгч нь тус шүүхийн Ерөнхий шүүгч байсан бол “тухайн хэрэгт ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдал бий болсон” гэх үндэслэлээр татгалзан гарах хүсэлт гаргаад шүүгчдийн зөвлөгөөнөөр хүсэлтийг хангаж шийдвэрлэгдсэн ерөнхий шүүгч нь захирамж гаргаад адил



шатны шүүх рүү явуулж буй нь иргэдэд хардах сэтгэл төрүүлж байна. Энэ нь нэг ёсондоо энгийнээр тайлбарлахад тухайн ерөнхий шүүгч нь уг маргаан бүхий хэрэгт сонирхлын зөрчил үүсэж болзошгүй шүү гэж өөрөө татгалзсанаар уг хэргийн ямар ч ажиллагаанд оролцохгүй гэдгийг шийдээд өгсөн байхад Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 93 дугаар зүйлийн 93.2-д заасан “Тухайн шүүхийн бүх шүүгчийг татгалзан гаргасан, эсхүл бүх шүүгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд урьд оролцож дахин оролцох боломжгүй болсон тохиолдолд хэргийг адил шатны өөр шүүхээр шийдвэрлүүлэхээр тухайн шатны Ерөнхий шүүгч захирамж гаргаж шилжүүлнэ” гэх заалтын дагуу хэргээс татгалзан гарсан ерөнхий шүүгч хэргийг шилжүүлэх захирамж гаргахаар зохицуулагдсан байна.

Үндсэндээ тухайн маргаан бүхий хэргийг адил шатны аль шүүх рүү шилжүүлэх вэ гэдэг шийдвэрийг тухайн татгалзан гарсан ерөнхий шүүгч гаргаж байна гэдэг нь харин ч иргэдийн хардах сэтгэлийг илүү их төрүүлж байна.

2. Мөн шүүх бүрэлдэхүүнтэй холбогдуулан орон нутагт тулгамдаж буй бас нэг асуудал бол Шүүхийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2-д заасан шүүгчдийн зөвлөгөөнөөр хэлэлцэх асуудлуудыг шийдэх боломжгүй нөхцөл үүсдэг. Жишээ нь нэн шаардлагатай хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацааг сунгах боломжгүй болдог. Учир нь тухайн шүүхийн 3 шүүгчийн нэг нь жирэмсний болон амаржсаны гэх мэт урт хугацаагаар чөлөөтэй тохиолдолд үлдэх 2 шүүгчийн нэг нь ээлжийн амралтаа эдлэх, өвчтэй, чөлөөтэй тохиолдолд үлдсэн 1 шүүгч нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотойгоор шүүгчдийн зөвлөгөөн хийх боломжгүй, өөрийг нь татгалзан гаргах

хүсэлт ирсэн тохиолдолд уг хүсэлтийг хянан шийдвэрлэх боломжгүй нөхцөл байдал үүсдэг. Учир нь Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 92 дугаар зүйлд заасан агуулгаар шүүх хуралдаанаас бусад тохиолдолд шүүгчийг татгалзвал ерөнхий шүүгч, эсхүл тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөнөөр хянан шийдвэрлэхээр тусгагдсан тул ганцаараа ажиллаж байсан шүүгчийн хувьд өөрийг нь татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлүүлэхээр адил шатны өөр шүүх рүү шилжүүлнэ гэсэн ойлголт байхгүй. Өөрөөр хэлбэл адил шатны шүүхүүд тухайн шүүхийн шүүгчдийн зөвлөгөөний эрхийг эдлэх боломжгүй юм.

Иймд орон нутагт ажилладаг шүүгчид шүүх бүрэлдэхүүний хүрэлцээ шаардлагаас болж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нэлээдгүй бэрхшээл тулгарсаар байна. Энэхүү асуудлыг нөгөө талаар шүүгчийн орон тоо нэмэх бус процессын хуульд холбогдох зохицуулалт оруулж шийдвэрлэж болох юм.

Гадаадын оронд тухайлбал АНУ-ийн Виржиниа мужид Хуульчдад ёс зүйн зөвлөгөө өгдөг хороо гэж ажилладаг юм байна. Энэ хороо нь шүүгчид өөрт нь тухайн тодорхой хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцохоос татгалзах ёстой эсэх, шүүгчийн ашиг сонирхлын зөрчил үнэхээр үүссэн эсэх, шүүгчийн ёс зүйн зөрчил болох эсэх талаар эргэлзээ төрж, өөрөө түүнийгээ шийдвэрлэж тодорхойлж чадахгүй байгаа тохиолдолд энэ асуудлыг шийдвэрлэдэг дээрх хороонд хандах боломж байдаг ажээ. Комисс нь эрдэмтэн, судлаачид, онолчид, хуульчийн ёс зүйгээр мэргэшсэн хуульчид, практикийн нарийн мэргэшсэн хуульчид буюу ёс зүйгээр мэргэшсэн шүүгч, өмгөөлөгч, профессор зэргээс бүрддэг байна.



Монголд ч ийм байдлаар “комисс” ажиллаад, түүн дотроо шүүгчийн хараат бус байдалд халдахгүйгээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зөвхөн процессын ажиллагаатай холбогдуулан “зөвлөмж” өгөх байдлаар ажиллахад хуульд харшлаад байх зүйл биш болов уу гэж шүүгч хүний үүднээс хувийн бодол төрдөг.

Ашигласан эх сурвалж:

1. Үндсэн хууль
2. Шүүхийн тухай хуулт

3. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль
4. Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаанд баримтлах дүрэм
5. The asia foundation сургалтын гарын авлага, 2018 он
6. Монгол Улсын шүүхийн шүүгчийн сахилгын хэргийг хянан шийдвэрлэсэн ёс зүйн хороо болон шүүхийн шийдвэрийн эмхэтгэл (2013-2016). УБ 2017 он



ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ЗАН СУРТАЛ

Т.АРИУНБОЛД¹

¹ Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн, өмгөөлөгч, Хууль зүйн магистр /LL.M./,
Хууль зүйн докторант.



ШҮҮГЧИЙН ЁС ЗҮЙ БА ЗАН СУРТАЛ

Т.АРИУНБОЛД. Монголын өмгөөлөгчдийн холбооны гишүүн,
өмгөөлөгч, Хууль зүйн докторант.

Монголчууд бид 13 дугаар зуунд азийн цээжинд их гүрэн байгуулж, дэлхийн гүрэн улс гэдгээ тунхаглан зарлаж, Евро-Азийг холбосон их гүрний хувьд хууль, дүрмийг баталж ёс зүйн хэм хэмжээг даган мөрдүүлж байсан. Тэгвэл тухайн цаг үед торгоны замаар онгон бүсгүй, толгой дээрээ алтан аяга тавиад явахад ямар нэгэн эрсдэлгүйгээр хүрэх газартаа хүрдэг байсан талаар түүхэнд тэмдэглэн үлдсэн байдаг. Энэ нь өөрөө Монголчууд бид орчин үеийн соёлт хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ёс зүйт төр, ардчилсан нийгмээс илүүтэйгээр ёс зүйн хэм хэмжээг тогтоож, түүнийг дагаж мөрдөж байсны илрэл юм. Мөн 13 дугаар зууны эхэн үед Англи улсад ард иргэд нь хэмжээгүй эрхт хааныхаа ёс зүйгүй дарангуйлалын эсрэг тэмцэж “Магна харт”-ыг батлуулж чадсанаар Европ тивд хүний эрх, эрх чөлөөний үнэ цэнийг хүлээн зөвшөөрөх үндэслэл бий болгосон. Хүний эрх, эрх чөлөө ёс зүйн хэм хэмжээтэй салшгүй холбоотой зүйл юм. Учир нь хүн өөрийн эрхийг хамгаалах, эрх чөлөөгөө эдлэхдээ ёс зүйн хэмжүүрийг баримтлах зайлшгүй шаардлагатай болдог. Хуулиар хүний эрх, үүргийг тодорхойлж юу хийж болох, юу хийж болохгүйг тодорхойлдог бөгөөд харин хуулийг дагаж мөрдөх нь ёс зүйн хэмжүүртэй холбоотой. Хуулийг зөв ойлгож эрх, үүргээ хэрэгжүүлэхдээ

нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээнд нийцсэн ёс зүйг сахин хамгаалж явах нь зүйтэй юм. Тэгвэл манай эриний өмнөх зуунд эртний Грек, Римд ёс зүйн асуудлыг хөндөж эхэлсэн байдаг. Тэгвэл ёс зүй нь гүн ухааны нэгэн салбар бөгөөд ёс зүйг сайн эсвэл муу, зөв эсвэл буруу, сайн үйл эсвэл муу үйл, хууль дүрэм эсвэл гэмт хэрэг гэх мэт олон олон асуултуудыг судалдаг.

Ёс зүй хэмээх ойлголт нь эртний грекийн Ethos буюу хамтран амьдрах, оршин амьдрах газар гэдэг утгатайгаар илэрхийлэгддэг байжээ. Хожим нь хөгжлийн явцад “ёс заншил, зан төлөв, зан араншин, сэтгэлгээний хэв маяг” гэсэн агуулгатай болж, тэдгээрийн шинж чанарыг илэрхийлэх болсон байна. Аристотель хүний зан төлөвийн өвөрмөц шинжийг илэрхийлэхийн тулд “Этос” гэх ойлголтыг анх хэрэглэсэн. Үүгээрээ тэрээр сайн үйл болох эр зориг, шударга байдал зэрэг хүний сайн чанарыг тэмдэглэж, түүнийгээ дианоэтик болон оюун ухааны сайн үйлээс ялгаатай авч үзсэн. Үүнээс үүдээд ёс зүй гэдэг нь хүний сайн сайхан үйлийг хэлнэ гэж ойлгож болно. Этика буюу ёс зүй хэмээх ойлголтын түүх нь эртний Римээс үндэслэлтэй гэж бас үздэг. Римчүүд Этос гэсэн үгнээс Мораль гэх ойлголтыг гаргаж авсан. Өөрөөр хэлбэл 2 өөр үг боловч нэг ижил утга санааг



илэрхийлдэг байж. Харин яваандаа Этика нь Ёс зүй, Мораль нь Ёс суртахуун гэх ойлголтуудыг тус тусдаа илэрхийлэх болсон. Ийнхүү харахад Этика буюу ёс зүй нь тусдаа бие даасан салбар шинжлэх ухаан болон хөгжиж, харин Мораль буюу ёс суртахуун нь түүний нэгэн судлагдахуун болсон гэж ойлгоно. Эндээс ёс зүй бол ёс суртахууны тухай шинжлэх ухаан юм гэсэн дүгнэлтийг гаргаж болно. Ёс зүй нь хувь хүний ёс суртахуунлаг шинж чанарын буюу сайн чанаруудын нийлбэр цогцыг нөгөө талаас хүмүүсийн хоорондын харилцааны хэм хэмжээний нийлбэр цогцыг хамран судалдаг шинжлэх ухаан болжээ. Ёс зүйг сайн сайхны илэрхийлэл гэх ойлголт нь дундад зууны үед шашины сургааль номлолд хүчтэй тусгагдаж, мөн эртний өрнө, дорнын гүн ухаан, философийн шинжлэх ухаанд судлагдахуун болон хөгжиж ирсэн билээ. Платоноос эхлээд Карл Маркс хүртэлх олон философичид сайн сайхан амьдралын үзэл баримтлалын үндэс болгож хувь хүний эрүүл хөгжлийн онолыг боловсруулж байсан. Эдгээр философичдын гол үзэл санаа бол “жинхэнэ сайн сайхан амьдралд хүрэх зам нь хүний дотоодод сайн зохион байгуулагдсан, эрүүл саруул сэтгэцийг бүрдүүлэх явдал юм” гэж томъёолж байжээ. Энэ үзэл санаануудыг өнөөдөр ч гэсэн философич, сэтгэл зүйчид судалсаар байна. “Эдүгээ хүн төрөлхтөн тэнгэрт шувуу мэт нисэж, далайд загас мэт сэлж сурчээ. Гагцхүү газар дээр хүн ёсоор амьдарч хараахан сураагүй байна” гэж Бернард Шоу нэгэнтээ хэлсэн байдаг. Бид хүн болж төлөвшиж чадах нь чухал бол түүнээс чухал нь эзэмшсэн мэргэжлийн ёс зүйгээ нарийн сайн ойлгож, суралцаж, чанд сахин хамгаалж, хөгжүүлэх явдал юм. Тэгвэл шүүгчийн ёс зүйн хаана харагдана вэ, хүний нүдэнд

үл харагдам тийм нарийвчилсан хэм хэмжээ бөгөөд түүнийг гагцхүү ойлгож мэдэрнэ гэдэг нь шүүгчээс хүнлэг, торгон мэдрэмжийг шаардсан хэм хэмжээний нийлбэр цогц гэлтэй юм.

Монгол хэлний их тайлбар тольд Ёс зүйг “Ёс, хүмүүжил-байвал зохих шаардлага, дэг” гэж тайлбарладаг бол Ёс суртахууныг “Дагавал зохих, хүнд байвал зохих зан суртал” гэж тайлбарлажээ.

Тэгвэл бид бүхэн шүүгчийн ёс зүй ба зан суртал гэсэн асуудлыг хөндөн авч үзэхэд шүүгч хүн өөрөө хамгийн сайн сайхны илэрхийлэл, шударга ёсны баталгаа нь байхаар дээрх томъёололд тусгагдсанаар ойлгогдож байна. Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн ёс суртахуун буюу тэр мораль нь шүүгч хүнд төгс зохицсон байх уу гэсэн асуудал гарч ирнэ. Мэдээж шүүгч хүн гэдэг нийгэмд үлгэр дуурайлал болох хэмжээний моральтай байх ёстой тиймийн тулд өөрөө нийгмийн олонх хүлээн зөвшөөрдөг тэр моральтай, бие авч яваа байдал нь бусдад үлгэр дуурайлал, итгэл үнэмшлийг төрүүлдэг байх шаардлагатай. Бид бүхний ардын үгэнд байдаг “бие засаад гэр зас, гэрээ засаад төрөө зас” гэдэгчлэн шүүгч биеэ бэлтгэсэн төгс зохицлыг бий болгохын тулд маш их оюуны болон бие махбодын хичээл зүтгэл гаргах нь чухал юм. Энэ нь public man буюу олон нийтийн хүн болоход бэлтгэх процесс гэж ойлгож болно. Шүүгч бол яах ч аргагүй олон нийтийн хүн, ард иргэд түүний шийдвэрийг хүлээн зөвшөөрч дагах нь түүний мораль, ёс зүйтэй салшгүй холбоотой юм. Мэдээж мораль, ёс зүйтэй байхын тулд маш сайн харилцааны урлагт суралцах шаардлага гарна. Өөрийнхөө гаргасан шийдвэр болон ёс зүйгээ хүнд ойлгуулах харилцааны урлагийг эзэмшсэн байвал зохилтой юм. Шүүгч болсноор олон эрхээс татгалзаж, эрхээ



хязгаарлуулж ёс зүйн ариун гинжинд хүлэгдэнэ. Энэ бол та ард иргэдийнхээ өмнө өөрийгөө нийгмийн амьдралын зарим бодит зүйлсээс татгалзаж, зөвхөн ярьдаг хуульчийнхаа үүргийг гүйцэтгэнэ гэж тангараг өргөх явдал юм. Ингэснээр та өөрийнхөө төлөө амьдрах биш ард иргэд, эх орныхоо төлөө амьдрах зорилгыг өөртөө бий болгоно. Шүүгч нь олон ёс зүйн шалгуурыг даван туулж, шүүгчийн ёс зүйн шалгуурт очих процессыг туулна. Энэ нь эхлээд хувь хүний ёс зүйг, дараа нь төрийн албан хаагчийн ёс зүй, хуульчийн ёс зүй зэргийг эзэмшиж бусдад ёс зүйн хэм хэмжээгээрээ хүлээн зөвшөөрөгдөсөн тохиолдолд шүүгчийн ёс зүйн хэм хэмжээнд хүрэх явдал юм. Үүнээс үзэхэд шүүгчийн ёс зүй нь ёс зүйнүүдийн ёс зүй гэж харагдаж байна. Нийтлэлч миний бодомжоор бол дээд ёс зүй бол шүүгчийн ёс зүйн гэж томъёолох нь зохимжтой байна. Дээд ёс зүй гэх энэ өндөр түвшний ёс зүйг эзэмшинэ гэдэг чамгүй хэцүү сорилтод орох нь тодорхой юм. Мэдээж хуульчид моралын доголдолгүй ажиллаж, ёс зүйн хэм хэмжээгээ сахиж чадаж гэмээнэ шилэгдмэл, сонгомол хуульч хүн шүүгч болох нь зүй ёсны асуудал юм. Тэгвэл шүүгчийг сонгон шалгаруулах процесс ажиллагаанд дан ганц Хуульчдын холбоо, хамт ажиллаж байсан хүмүүс санал авах биш тухайн нэр дэвшигчээс өөрөөс нь ёс зүйн хэм хэмжээний тухай ерөнхий ойлголтыг /ёс зүй, мораль гэж юу вэ гм/ эхний шатанд, дараагийн шатанд нарийвчилсан /шүүгчийн ёс зүйн гэж юу вэ гм/ ярилцлага байдлаар авах нь зүйтэй юм. Хүн өөрийнхөө ёс зүйг тодорхойлж илэрхийлнэ гэдэг бол хамгийн хэцүү үе шатуудын нэг. Ёс зүйн шаардлагыг хүн өөрөөсөө эхэлж хардагтай адил ёс зүйн хэмжүүрийг нь тогтоохын тулд өөрөөр нь өөрийг

нь тодорхойлуулж түүнтэй харилцан ярилцах нь илүү үр дүнтэй юм. Хэн нэгэн хүнээс шүүгчийн ёс зүйн хэмжүүрийг тодорхойлуулж авна гэдэг бол анхан шатны дүгнэлт төдий зүйл харин өөрөөр нь тодорхойлуулна гэдэг бол сонгодог шалгуур юм. Мэдээж тухайн шүүгчид нэр дэвшигчийн талаарх сайн, муу гэсэн мэдээллийг тодорхой хэмжээгээр цуглуулсан байх үед тухайн нэр дэвшигч өөрийгөө хэрхэн тодорхойлж үнэний талд байж чадах нь сонирхол татам үйл явц болох нь ойлгомжтой. Ийнхүү шүүгчийг томилогдохоос өмнө нь түүнийг сайтар судалж ёс зүйн хэмжүүрийг нарийвчлан тогтоож чадах л юм бол сайн сайхны илэрхийлэл болж чадах хуульч шүүгчээр томилогдоно.

Хуульчийн ёс зүйг Орос холбооны улсын хууль цаазын нэрт онолч доктор профессор С.С.Алексеев бичихдээ: “Хуульчийн ёс зүй нь хуульчийн үйл ажиллагааны зан суртахууны нийтлэг зарчмуудыг төдийгүй, мөрдөн байцаах, шүүх, өмгөөлөх, зэрэг хууль зүйн ажлын төрлүүдтэй холбоотойгоор түүнд тавигдах ёс суртахууны онцлог шаардлагуудыг нэгэн адил хамаардаг” гэж тэмдэглэжээ. Тэгвэл хуульчийн ёс зүй бол мэргэжлийн ёс зүйг гэж бодоход түүнээс салаалсан шүүгч, прокурор, өмгөөлөгч, цагдаа гэх мэт албан хаагчийн ёс зүй бол мэргэшлийн ёс зүй рүү чиглэсэн нарийвчилсан зохицуулалт юм. Энгийнээр хэлэхэд бид нар бүдүүн зүйлийг яриад байх биш илүү нарийвчилсан зүйлийг ярих, түүн рүү чиглэсэн үйл ажиллагааг явуулах шаардлагатай юм. Хуульч нар тэр дундаа шүүгч ёс зүйтэй байснаар ямар үр дагавар гарах вэ гэсэн асуулт. Тэгвэл нийгмийн ёс суртахууныг цэвэр ариун байлгах шаардлагатай юм. Нийгэмд муу зүйл газар авах, хүмүүсийн итгэл алдрах, муу зүйлд дасан зохицох, үнэн алдагдаж



ялзалд ороход тухайн улс үндэстний үндэсний аюулгүй байдал алдагдахад хүрнэ. Үүнийг хэрхэн хэн хамгаалах вэ гэсэн асуулт?. Энэ үүрэг нь хуульч нарт тэр дундаа ихээхэн итгэл найдвар нь шүүгчид ноогдож байдаг. Шүүгч хүн өөрийнхөө ёс суртахуун, ёс зүй, мэдлэг боловсролоороо нийгмийн дархлаа болж байдаг. А.Токвилль хэлснээр “Хуульчид бол ардчилсан нийгэм дэх язгууртнууд юм” гэж тодорхойлсонтой дээрх бичсэнчлэн санал нэгдэх юм дүгнэж байна.

Оросын эрдэмтэн В.С.Нерсесянцын “Эрх зүйн тэгш байдал нь эрх чөлөөт хүмүүсийн тэгш байдал, бодгалиудын эрх чөлөөний нийтлэг цар хэмжээ буюу тэгш хэм юм. Энэ утгаараа эрх зүй бол эрх чөлөөний математик юм” гэж тодорхойлжээ. /В.С.Нерсесянц Эрх зүйн философи.М1997.С17/. Хуульчид шударга ёс, тэгш эрхийн үнэ цэнийг нийгэмд хамгаалагчид буюу эрх чөлөөний математикийг бодож нийгэмд нэгдмэл хариуг тогтоож өгөх үүрэг хүлээсэн ардчилсан нийгмийн язгууртнууд юм. Үүний тулд ёс зүй ба зан суртлыг хуульч, шүүгчийн үйл ажиллагаанд мөрдлөг болгож гэмээнэ олон нийт сонсож, хүлээн зөвшөөрч, дагана.

Шүүх хараат бус, хариуцлага хүлээдэг, мэдрэмжтэй, шударга, хүртээмжтэй, бүтээмжтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлэгч нь шүүгч бөгөөд шүүхийн байгууллага хүний эрх, шударга ёсны баталгаа байхын хувьд хуульд заасан чиг үүргээ хэрхэн хэрэгжүүлж байгааг харуулах толь мөн л шүүгч байдаг. Энэ үүргээ хэрэгжүүлэхдээ шүүгч нь албандаа чин санаанаасаа хүндэтгэлтэй хандах, харилцааны соёлыг эрхэмлэн шүүх хуралдаанд гол төв нь байж хурлыг чадварлагаар удирдан шударга шийдвэр гаргах итгэл үнэмшлийг төрүүлэгч нь

байх хэрэгтэй. Яагаад итгэл найдварыг төрүүлэгч байх ёстой вэ гэсэн асуулт?. Энэ бол маш чухал зүйл юм, учир нь хэн нэгэн хүнд итгэл найдвар төрж байж шударга ёс, хууль, журам хэрэгжих баталгаа болно. Тэрнээс биш үл итгэх хандлага байгаа цагт зөв шийдвэр гарсан ч нийгэмд байгаа шударга ёсны өрөөсгөл ойлголт хурдан өөрчлөгдөх боломжгүй юм.

Үүний тулд ёс зүй нь өндөр хэмжээнд үнэлэгдэж танигдаж чадсан шүүгчид хүн итгэнэ, түүний гаргасан шийдвэр нь тухайн хүний эсрэг гарсан ч шүүгч шударга шийдвэрлэсэн гэдэгтээ маргахгүй байх зарчмын ойлголт тухайн хүнд суусан байх юм. Эртний Хятадын эрдэмтдийн төлөөлөгч болох Күнзийн сургаалд “Хэрэв зөвхөн хуулиар чангалж, шүүж цээрлүүлэхийг чухалчилбаас ард түмэн болгоомжтой болох авч ичих зовохын сэтгэлгүй байх болно. Хэрэв сайн үйлийн үндсэн дээр захирч, заншил дагасан ёс журмын дагуу цэгцэлбээс түмэн олон ичиж зовдог болох төдийгүй дуулгавартайяа дагах ажгуу” бичигдсэн байна. Тэгвэл шүүгчийн сайн сайхны төлөө гаргасан тэр шийдвэр нь өөрөө ёс зүйн хэм хэмжээнд шийдвэрлэгдсэн байна гэсэн утгыг илэрхийлж байна. Күнзийн багш Конфузийн сургаалиас иш татвал “Хэрэв шударга бусчуудын дээр шударга үнэнч хүмүүсийг өргөмжлөн тавибал ард олон дуулгавартай байна. Хэрэв шударга бус хүмүүсийг шударга шулуун хүмүүсийн дээр өргөмжлөн тавибал түмэн олон үл сонсоно” гэж хэлсэн байна. Шүүгч хүн ёс зүйтэй байж, шударга байна гэдэг нь ямар чухал зүйл болох, нийгэмд хэрхэн нөлөөлөх нь дээрх эшлэлээс харагдаж байна. Монголын их хаад ард иргэдийнхээ сэтгэлийг засахад хэрхэн нөлөөлж байсан талаар Эзэн богд Чингис хааны алтан сургаалд



“Даян дэлхийг түвшитгэн зассугай гэхүл даяар олон иргэнийг хураан эедүүлэгтүн, дэлхийн хүмүүн олныг эедүүлье гэхүл далай их сэтгэл, итгэлийг ологтун” бичигдсэн байна. Үүнээс үзэхэд ард иргэдийн итгэл найдварыг тээж, түүнийг хадгалж чадах нь удирдагч хүний чин хүсэл нь байх ёстой юм. Өрнийн эртний философич Демокрит “Сайн сайхан зүйл маш их чармайлтын үр дүнд бий болдог. Харин муу зүйл зүгээр л өөрөө гараад ирдэг” гэж хэлсэн байдаг. Тиймээ бид сайн сайхан тэр ёс зүйг тогтооход олон хүчин зүйлийг даван туулж хүрэх шаардлагатай болдог. Түүнд хүрэхийн тулд оюун ухаанаа дайчилж суралцахыг байнга хичээх хэрэгтэй юм. Сурсан мэдсэн зүйл арвинтай, туршлага чадвар нь хэдийдсэн хүн Сенекагийн хэлсэнчлэн “Хүнийг үлгэрлэж хүмүүжүүлэх нь үглэж хүмүүжүүлэхээс амар” бусдад нөлөөлж ёс зүйн хэм хэмжээг ойлгуулах, түүнд хүрэх, түүнийг дагаж мөрдөх сэдлийг төрүүлнэ.

Тэгвэл одоо бид тийм өндөр хэмжээний дээд ёс зүй гэж үнэлэгдэх ёс зүйтэй шүүгч нар бидний дунд байна уу, эсвэл сургах ёстой юм уу, нөгөөтэйгөөр хэрхэн яаж ёс зүйтэй шүүгч нарыг бий болгох вэ гэсэн олон асуултууд ар араасаа урган гарч ирнэ. Шүүгчийг ёс зүйн хууль, дүрмийг зөрчсөн хойно биш зөрчихөөс нь өмнө түүнийг зөрчихгүй байх тогтолцоог бий болгох ёстой. Шүүгчийн цалингийн асуудлыг төрөөс анхаарч боломжийн түвшинд нэмэгдүүлсэн. Тэгвэл цалин нэмэгдсэнээр шударга шийдвэрийг шүүгч гаргаж чадах уу гэсэн асуулт? Үүнд шууд тийм гэж хариулт өгөх боломжгүй юм. Учир нь дан ганц цалингийн асуудлаар үүнийг шийдвэрлэх боломжгүй бөгөөд улс төр, нийгэм, эдийн засгийн баталгааг нь гаргаж өгөх, мөн шүүгчийн ёс зүйн болон сэтгэлгээний томоохон өөрчлөлтөд оруулахын тулд олон удаагийн

давтамжтай сургалтад хамруулах нь зүйтэй бөгөөд үр дүн нь тодорхой хугацаанд, тодорхой түвшинд хүрнэ. Үүнийг Д.Баяндалайн “Таны аз жаргал цэвэр ариун, уураг тархи гэгээн тунгалаг, ухамсарлах сэтгэл үнэнч шударга, бие махбод эрүүл саруул болж төлөвшихөд номын өглөгч чанар оршино” гэдгээс иш татвал, шүүгч хүн мораль, ёс зүйтэй болох процесс нь суралцах, хөгжих явдал гэдэг нь харагдаж байна. Иймийн тулд хуульч нар байнга суралцах шаардлагатай юм. Ноён хутагт Д.Данзанравжаа “Насны багад эрдэм сурахад, Залхуугүй бол даанч сайн” гэж, В.Инжинаш “Хүн хэдий цэцэн төрөвч сургаалгүй үл болох” гэсэн сургаал үгнээс үзэхэд хуульчид тогтмол суралцах нь ёс зүйн төлөвшлийг төгөлдөржүүлэх байнгын үйл ажиллагаа ба шүүгчийн шүүн таслах механизмыг хөдөлгөгч хүч болох онцлогтой юм.

Шүүгчийн ёс зүй буюу дээд ёс зүй төлөвшиж, нийгэмд ердийн дундаж иргэдийн шүүхэд итгэх итгэл сэргэсэн тохиолдолд шударга ёс тогтоох, баялгийн хуваарилалт нийгэмд тэгш хүртээх, иргэдийн итгэл найдвар сэргэх нь эх орондоо сайн сайхан, итгэл төгс амьдрах боломж бүрдэн бий болох нийгмийн ахиц дэвшил юм. Хууль зүйн шинжлэх ухааны доктор, академич С.Нарангэрэл “Ёс суртахуун бол хүний уураг тархинд байгаа эерэг энергийн өгөгдлийн цогц” гэж тодорхойлсон бөгөөд тэрээр “Хүн энэ хорвоод ирсэн шигээ буцна. Махан бие байхгүй болох ч биднээс хэдэн арван жилээрээ дурсагдах юм үлдэнэ. Тэр нь нэр төр. Хэчнээн сайн үр удам төрөн гарсан ч эцэг эхийнхээ бузарласан нэрийг эргэж сэргээнэ гэдэг маш хэцүү шүү. Үе удмаар нь тамгалчихдаг. Тиймээс төрийн албан хаагчид төрийн албан хаагчийн нэр хүндийг өндөрт байлгах учиртай юм” гэж хэлсэнтэй санал нийлж байгаа ба төрийн



албан хаагч тэр дундаа Төрийн шүүгч хүн өөрийн нэр төр, өвөг дээдсийнхээ алдар хүнд, мөн шүүх эрх мэдлийн засаглалын нэр хүндийг давхар нуруу, зүрхэндээ тээж явах хүнд ачааг тэгнэх, ажил үүргээ ухамсартайгаар гүйцэтгэснээр Монгол төрийн нэгэн жарны төрт ёсны шүүн таслах, хууль цаазын үйл хэргийг гүйцэлдүүлэн, хойчийн залгамж үедээ нэр төртэйгээр хүлээлгэн өгөхөд хувь хүний, хуульчийн, шүүгчийн ёс зүйд ертөөлөн суралцсны үр дүнд шилжүүлэх

цогц хариуцлага юм. Монгол Төрийн шүүгчийн тэгш, хүмүүнлэг, ардчилсан үзэл санаа, олон ургалч бодрол, шударга, сүүн цагаан сэтгэлийг тээгч дээд ёс зүйн үндэс суурь нь бэхэжсэн зан суртлын мод ургасаар л.... байх болно.

*Ард иргэдийн итгэл найдвар
Шүүгчийн зүрхэнд хадгалагдаж байдаг
бол үүнд хуульчийн ёс зүй гүүр болох
нь дамжиггүй юм -Т.Ариунболд*



**ХЭРГИЙН ОРОЛЦОГЧДЫН ХҮСЭЛТ ГАРГАХ ЭРХ,
ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД НӨЛӨӨЛЖ
БАЙГАА БАЙДАЛ.**

**THE RIGHT OF THE PARTICIPANTS IN THE CASE TO
MAKE A REQUEST AND THE SITUATION AFFECTING
THE PROCEEDINGS.**

**Ж.БАЙГАЛМАА¹
Т.ЭНХТУЯА²**

¹ Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Хууль зүйн магистр /LL.M./

² Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Хууль зүйн магистр /LL.M./



**ХЭРГИЙН ОРОЛЦОГЧДЫН ХҮСЭЛТ
ГАРГАХ ЭРХ, ХЭРЭГ ХЯНАН
ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГААНД
НӨЛӨӨЛЖ БАЙГАА БАЙДАЛ**

Ж.БАЙГАЛМАА. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Хууль зүйн ухааны магистр /LL.M./

Т.ЭНХТУЯА. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгч, Хууль зүйн ухааны магистр /LL.M./

Түлхүүр үг

Хэргийн оролцогчид, субъектив эрх, хүсэлт гаргах эрх, хүсэлт шийдвэрлэх, урьдчилсан хэлэлцүүлэг, хугацаа, актив эрх, пассив эрх, негатив эрх, шүүхийн практик, судалгаа, шүүх хуралдаан хойшлох,

Participants in the case, subjective rights, the right to request, request processing, preliminary discussion, period, active rights, passive rights, negative rights, court practice, research, postponement of court proceedings.

Хураангуй.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /ИХШХША гэх/ нь хувийн эрхийг хэрэгжүүлэх төрөөс зохицуулсан ажиллагаа бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн эрх зүйн маргааныг хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэх үйл явц юм.

ИХШХША-ны субъектүүд нь хуульд зааснаар хэргийн оролцогч, шүүх хуралдааны оролцогч гэж ангилагдаж байна. Хэргийн оролцогчид нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, өөрчлөх, үргэлжлүүлэх, дуусгавар болгоход чиглэсэн субъектив эрхийнхээ хүрээнд гаргаж байгаа хүсэлтүүдээр дамжуулан идэвхитэй болон идэвхигүй

байр сууринаас ИХШХША-г дэмжин оролцдог бөгөөд энэхүү хүсэлт гаргах эрх нь зохигчдын эдлэх эрхүүдээс хамгийн чухал эрхэд тооцогдоно.

Хэргийн оролцогчдын эрх зүйн ухамсраас шалтгаалан, субъектив эрхийн хүрээнд гаргасан хүсэлт нь ойлгомжгүй, тодорхойгүй байх, хэргийн үйл баримтад хамааралтай эсхийг тодруулж чадахгүй байх, бичгийн хүсэлт нь албан бичиг хэргийн наад захын шаардлага хангахгүй байгаа зэргээс шалтгаалж шүүх хүсэлтийг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэдэг. Тийм учраас шүүх зохигчдын гаргасан хүсэлтийг шүүх хуралдаан дээр тодруулах, юу хүсээд байгааг нь ойлгох, хүсэлт нь хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой эсхийг асуух, нөгөө талын байр суурийг сонсох байдлаар эцэслэн шийдвэрлэж, үүний үр дүнд шүүх хуралдаан олон удаа хойшлох үр дагавар үүсдэг.

Өөрөөр хэлбэл, шүүх хуралдаан хойшилж байгаа нөхцөл, шалтгааны талаар судлахад хэргийн оролцогчдын гаргасан хүсэлтийг шийдвэрлэсэнтэй холбоотой шүүх хуралдаан удаа дараа хойшилж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сунжрах, удаашрах, хэргийн хугацаа хэтрэх, хугацаа хэтэрсэн хэргийн тоо өсөх, шүүхийн ачаалал нэмэгдэх, хэргийн оролцогчдыг чирэгдүүлэх, эдийн



засгийн үр ашиггүй байдлыг бий болгох зэргээр шүүх болон хэргийн оролцогчдын аль алинд нь сөрөг үр дагавруудыг үүсгэж байгаа зарим нөхцөл байдлууд гарч байна.

Иймд хэргийн оролцогчдын гаргасан хүсэлт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлж байгаа байдлыг цаашид хэрхэн шийдвэрлэж болох талаар зарим зохицуулалтыг санал болгохыг зорьсон болно.

1.Хэргийн оролцогчдын эрх зүйн байдлын талаар.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагаа /ИХШХША гэх/ нь хувийн эрхийг хэрэгжүүлэх төрөөс зохицуулсан ажиллагаа бөгөөд иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын хооронд үүссэн эрх зүйн маргааныг хуульд заасан журмын дагуу хянан шийдвэрлэх үйл явц юм.

Өөрөөр хэлбэл ИХШХША нь хувь этгээдийн хуулиар хамгаалагдсан субъектив эрхийг төрийн албадлагын журмаар хэрэгжүүлэх үндсэн зорилгыг агуулдаг ба, энэхүү үйл ажиллагаанд өөр өөр ашиг сонирхол бүхий субъектүүд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль /ИХШХШТХ/-д заасан эрх эдэлж, үүрэг хүлээн оролцдог.

Субъектүүд нь шүүхэд хандах, иргэний хэрэг үүсгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрчлөх, дуусгавар болгох, үргэлжлүүлэх эсэхээ өөрсдөө шийдвэрлэх боломжтой, төр буюу шүүх нь субъектүүдийн хоорондын маргаанд өөрийн дур зоргоор, санаачилгаар оролцох эрхгүй боловч хуульд заасан онцгой тохиолдолд өөрийн санаачилгаар оролцдог байна.

Субъектын эрх зүйн байдал нь ИХШХША-нд оролцогчдын хуулиар тодорхойлсон субъектив эрх, үүрэг,

тэдгээрийг ханган хэрэгжүүлэх баталгаа бөгөөд энэхүү харилцааны субъект байх эрх зүйн чадвар, чадамжийг багтаасан, хуулиар тогтоосон төлөв байдал юм. ИХШХША-ны субъектүүд нь хуульд зааснаар:

1.хэргийн оролцогч /зохигч, гуравдагч этгээд, төлөөлөгч, өмгөөлөгч, бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх нь хуулиар олгогдсон этгээд, онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлүүлэхээр хүсэлт гаргасан сонирхогч этгээд, Захиргааны ерөнхий хуульд зааснаас бусад байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаанд гомдол гаргагч/

2.шүүх хуралдааны оролцогч / хэргийн оролцогчоос гадна шинжээч, гэрч, орчуулагч, хэлмэрч, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, иргэдийн төлөөлөгч/ гэж ангилагдаж байна.

ОХУ-ын Иргэний процессын хуулийн 34, 46, 47 дугаар зүйлүүдэд зааснаар “эсрэг байр суурь бүхий талууд, гуравдагч этгээд, прокурор, эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахаар шүүхэд хандсан хүмүүс, бусад хүмүүс, төрийн удирдлагын байгууллага, нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, үйлдвэрчний эвлэл, улсын үйлдвэрийн газар, албан байгууллага, хоршоолол, олон нийтийн байгууллага, иргэдийг хэргийн оролцогчид” хэмээн тодорхойлсон байх бөгөөд энэ нь манай ИХШХШТХ-д заасан хэргийн оролцогчдын эрх зүйн зохицуулалтай ижил төстэй байна.

2.Хэргийн оролцогчдын субъектив эрхийн талаар.

Хэргийн оролцогчид болох нэхэмжлэгч, түүний төлөөлөгч / хамтран нэхэмжлэгч/, хариуцагч,



түүний төлөөлөгч /хамтран хариуцагч/, гуравдагч этгээд, түүний төлөөлөгч /бие даасан шаардлага гаргасан болон гаргаагүй гуравдагч этгээд/, өмгөөлөгч, прокурор, хүсэлт гаргагч, түүний төлөөлөгч, бусдын эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалж шүүхэд мэдүүлэх эрх хуулиар олгогдсон этгээдүүд нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлэх, өөрчлөх, үргэлжлүүлэх, дуусгавар болгоход чиглэсэн субъектив эрхийнхээ хүрээнд гаргаж байгаа хүсэлтүүдээр дамжуулан идэвхитэй болон идэвхигүй байр сууринаас ИХШХША-г дэмжин оролцдог бөгөөд энэхүү хүсэлт гаргах эрх нь зохигчдын эдлэх эрхүүдээс хамгийн чухал эрхэд тооцогдоно. Эндээс субъектив эрх гэдэгт юуг ойлгохыг тодруулах шаардлага урган гарна.

Субъектив эрх гэдэг нь нэг тал эрх эдэлж, нөгөө тал холбогдох үүрэг хүлээх явдал бөгөөд тодорхой ашиг сонирхлыг хамгаалах үүднээс холбогдох этгээдэд олгосон эрх зүйн боломж¹ бөгөөд энэхүү эрх нь аливаа маргааны хүрээнд объектив хэм хэмжээг хэрэглэснээр бий болдог.

Субъектив эрхийг дотор нь олон шалгуураар ангилж болох боловч туйлын эрх, харьцангуй эрх, эрх өөрчлөхөд чиглэсэн харьцангуй эрх хэмээн ангилдаг байна.

Туйлын эрхэд эд зүйлийг захиран зарцуулах буюу өмчлөх эрх, ерөнхий болон тусгай амины эрхүүд, эдийн бус баялагийн эрх буюу патент, зохиогчийн эрх хамаарна.

Харьцангуй эрхэд үүргийн эрх зүйн шаардах эрхүүд, өмчийн шаардах эрхүүд хамаарна.

Туйлын болон харьцангуй эрхээс гадна, эрх зүйн харилцааг өөрчлөхөд чиглэсэн процессын шинжтэй эрхүүд байна. Жишээ нь: хэлцлийг хүчин төгөлдөр бусд тооцуулах эрх, гэрээг цуцлах, татгалзах эрх гэх мэт. Эдгээр нь эрх зүйн харилцааг өөрчлөхөд чиглэсэн эрхүүд бөгөөд эрх бүхий этгээдийн хүсэл зоригийн илэрхийлэлд тулгуурлан эрх зүйн харилцааг өөрчлөх боломжтой болдог. Эндээс үзвэл ИХШХША дахь зохигчдын эдлэх субъектив эрхүүд нь эрх зүйн харилцааг өөрчлөхөд чиглэсэн эрхүүдэд хамаарахаар байна².

Тодруулбал, тухайн этгээд өөрийн эдийн болон эдийн бус баялагтай холбоотой ашиг сонирхлоо хамгаалах бөгөөд ИХШХША-ны явцад үүнийг процессын субъектив эрхийн журмаар хэрэгжүүлдэг. Энэ эрхийг туйлын болон харьцангуй эрхэд хамааруулах боломжгүй, харин эдгээр эрхүүдийг хэрэгжүүлэхэд туслах чанартай эрх гэж үздэг байна.

Дээрхээс үзвэл, ИХШХШТХ-д заасан зохигчдын эрх нь эрх зүйн харилцааг өөрчлөхөд чиглэсэн харьцангуй субъектив эрх байх ба, ийнхүү ангилах нь зохигчдын эрх зүйн байдлыг тодорхой болгох ач холбогдолтой бөгөөд зохигчид уг эрхийг нийтлэг болон тусгай эрхийн хэлбэрээр хэрэгжүүлнэ. Жишээлбэл, гэрчээс мэдүүлэг авахуулах, шинжээч томилуулах, нотлох баримт бүрдүүлэх гэх мэт нийтлэг эрхүүд, мөн субъектын эрх зүйн байдлаас хамаарч нэхэмжлэгчийн хувьд нэхэмжлэлийн шаардлагыг ихэсгэх, багасгах, татгалзах гэх мэт, хариуцагчийн хувьд нэхэмжлэлийн шаардлагыг зөвшөөрөх, биелүүлэх, татгалзах, сөрөг нэхэмжлэл гаргах гэх мэт тусгай эрхүүд байна.

¹ Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн удиртгал УБ., 2018 он, 111-113 дугаар тал.

² Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн удиртгал УБ., 2018 он, 111-113 дугаар тал.



Эрх зүйн онолын үүднээс эдгээр субъектив эрхүүдийг эдлэх хэлбэрээр:

1.Иргэний эрх зүйн харилцаанд оролцохын тулд идэвхтэй үйл ажиллагаа явуулах эрх /актив эрх/,

2.Иргэний эрх зүйн харилцаанд оролцохдоо зүй бус буюу эрх зүйн бус зан үйлээс татгалзах эрх /пассив эрх/,

3.Бусдын зүй бус зан үйл, хууль бус үйлдэл, үйл ажиллагааг зогсоох, хязгаарлахыг шаардах эрх /негатив эрх/³ гэж ангилдаг.

ИХШХША-ны хувьд, уг ажиллагаанд нөлөөлөх, шүүх хэрэг маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх шинжтэй, зохигчдын зүгээс үзүүлж байгаа идэвхитэй үйлдэлд хамаарах нотлох баримт бүрдүүлэх, цуглуулах, гарган өгөх зэргээр мэтгэлцэх эрх хэрэгжүүлэхтэй холбоотой хуульд заасан хүсэлтүүдээр дамжин актив эрх хэрэгждэг.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх, шүүх хэрэг маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх үүргээ биелүүлэхгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах зэргээр зүй бус, зохисгүй байдлаар пассив эрх хэрэгжиж болохоор байна.

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд нөлөөлөх, шүүх хэрэг маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх үүргээ биелүүлэхгүй, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах зорилгоор шүүхэд ирэхгүй байгаа этгээдийг албадан ирүүлэх, шүүх хуралдааны дэг, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам зөрчсөн тохиолдолд арга хэмжээ авхуулах гэх мэт хууль бус үйлдэл, үйл ажиллагааг зогсоох, хязгаарлахыг шаардах байдлаар негатив эрх хэрэгжихээр байна.

³ Д.Баярсайхан. Эрх зүйн онол, УБ., он, 147 дугаар тал.

3.Хэргийн оролцогчдын хүсэлт гаргах эрхийн талаар.

ИХШХША дахь зохигчдын эдлэх субъектив эрх нь эрх зүйн онолын үүднээс пассив, негатив эрхээс илүүтэйгээр **актив эрхэд** хамаарч байна. Зохигчид энэхүү эрхээ хэрэгжүүлэхдээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, хэрэг маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэх эсэхэд нөлөөлөх зорилгоор, мэдүүлэх эрхийнхээ хүрээнд, хэрэг маргааны бодит үйл явц болон эрх зүйн үндэслэлтэй холбоотойгоор өөрсдийн байр суурь, үзэл баримтлалаа хүсэлтийн хэлбэрээр шүүхэд илэрхийлнэ.

“Хүсэлт” гэдэг нь хүсэх үйлийн нэр, хүссэн зүйл, санал хүсэлтээ илэрхийлэх, эрэлт хүсэлт гэсэн хоршоо үг⁴ гэсэн ойлголтыг илэрхийлдэг ба, хэргийн оролцогчид дээр дурдсан субъектив эрхээ хүсэлтийн хэлбэрээр, шүүхэд мэдүүлэх эрхийн хүрээнд хэрэгжүүлдэг боловч хүсэлт нь ямар хэлбэр, агуулгатай байхыг хуульд тухайлан зохицуулаагүй.

Харин шүүхийн практикт зохигчид хүсэлтийг аман болон бичгийн аль нэг хэлбэрээр гарган шийдвэрлүүлдэг бөгөөд шүүх аман хүсэлтийг шүүх хуралдааны тэмдэглэлд тусгах хэлбэрээр баримтжуулж, энэхүү аман хүсэлтээ бичгээр гаргах шаардлагыг тавьдаг. Зохигчдоос гаргасан хүсэлтийг шүүх шийдвэрлэхийн тулд нөгөө талд танилцуулах нь шүүхэд “сонсгох” зарчмыг хэрэгжүүлж байгаа хэлбэр юм. Энэ зарчмын агуулга нь хэргийн оролцогчдын гаргасан хүсэлтийн талаар тэдэнд мэдэгдэлгүйгээр ямар нэгэн шийдвэр гаргах, тэднийг гэнэтийн шийдвэрээр цочирдуулахаас урьдчилан сэргийлж, гаргасан хүсэлтийн талаар танилцуулах, холбогдох тайлбар, саналаа илэрхийлэх

⁴ <https://toli.query.mn/>. Я.Цэвэл, Монгол хэлний тайлбар толь.



боломжийг олгон, шүүхээс хүсэлтийг хүлээн авах, сонсох, сонсгох ажиллагаа явуулах байдлаар хэрэгжинэ.

Зохигчдын гаргасан хүсэлтийг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105, 123 дугаар зүйлүүдэд заасан журмаар шийдвэрлэх ба, энэ зохицуулалт нь зохигчдод хүсэлтийг цаг хугацааны хувьд:

1. шүүх хуралдаанаас өмнө гаргах,
2. эсхүл шүүх хуралдаан дээр гаргах гэсэн хоёр боломжийг олгосон байна.

4.Хүсэлт шийдвэрлэхтэй холбоотой ИХШХША-нд учирч буй зарим бэрхшээлийн талаар.

Шүүхийн практикт, хэргийг шүүх хуралдаанаар хэлэлцүүлэх тухай шүүгчийн захирамж гарахаас өмнө зохигчид хүсэлтийг шүүхэд гаргадаггүй, шүүхэд дуудахад ирдэггүй, эрх, үүрэг танилцдаггүй зэргээр идэвхгүй байр сууринаас оролцдог. Өөрөөр хэлбэл, зохигчдын эрх зүйн ухамсар⁵-аас шалтгаалан гаргасан хүсэлт нь ойлгомжгүй, тодорхойгүй байх, хэргийн үйл баримтад хамааралтай эсэхийг тодруулж чадахгүй байх, бичгийн хүсэлт нь албан бичиг хэргийн наад захын шаардлага хангахгүй байгаа зэргээс шалтгаалж шүүх хүсэлтийг шийдвэрлэхэд хүндрэлтэй байдлыг үүсгэдэг. Тийм учраас шүүх зохигчдын гаргасан хүсэлтийг шүүх хуралдаан дээр тодруулах, юу хүсээд байгааг нь ойлгох, хүсэлт нь хэрэг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой эсэхийг асуух, нөгөө талын байр суурийг сонсох байдлаар эцэслэн шийдвэрлэж, үүний

⁵ Эрх зүйн бодит байдлын субъектив тусгал. Өөрөөр хэлбэл эрх зүйн үзэл, онол, үзэл суртал зэрэг объектив ухамсраас эхлээд эрх зүйн сэтгэгдэл, санаа бодол, хүмүүжил, зан суртахуун зэрэг субъектив ухамсрын аль алиныг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм. Д.Баярсайхан., Эрх зүйн онол, УБ., 2018 он, 225 дахь тал.

үр дүнд шүүх хуралдаан заавал хойшлох явдал хавтгайрч байна.

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.1-д зааснаар шүүх хуралдааныг хэлэлцүүлэхтэй холбогдуулан хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд холбогдолтой нотлох баримт хангалттай бүрдсэн гэж үзсэн, эсхүл 71.1-д заасан хэрэг шийдвэрлэх хугацаа дууссан, шаардлагатай гэж үзсэн бусад үндэслэл байгаа үед шүүх хуралдааныг хэлэлцүүлэх тухай захирамж гарган, хуралдааныг товлохоор зохицуулсан байх боловч шүүх хэргийг 60 хоногийн хугацаанд хянан шийдвэрлэх, нотлох баримт хангалттай бүрдээгүй байхад хариуцагчийн хариу тайлбар ирүүлэх 14 хоногийн хугацаа дууссанаас хойш, хэргийн оролцогчдыг эрх, үүргээ хэрэгжүүлэх, идэвхтэй байр сууринаас оролцуулах зорилгоор шүүх хуралдааныг зарлах байдал ихсэж байна.

Зүй нь хуулийн дээр дурдсан заалт бодитоор хэрэгжих үндсэн нөхцөл нь зохигчид шүүх хуралдаанаас өмнө хүсэлтээ гарган, хүсэлтийг шүүх Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 123 дугаар зүйлд зааснаар шийдвэрлэж, хэрэгт нотлох баримтууд хангалттай бүрдсэн гэж үзэх үндэслэл бий болох төдийгүй зохигчид эрх, үүргийнхээ хүрээнд хэрэг маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлэхэд шүүхэд дэмжлэг үзүүлэн идэвхтэй байр сууринаас оролцох зорилгоор хүсэлтийг гаргах учиртай.

Харин шүүхийн практикт зохигчид шүүхэд хэрэг маргааныг удаан хугацаанд шийдвэрлүүлэхгүй байлгах, хугацаа хожих, нэхэмжлэл шүүхэд байгаа гэдэг агуулгаар зохигчид бие биедээ дарамт үзүүлэх, энэ зорилгоо шүүх дэх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар дамжуулж



хэрэгжүүлэхийг оролдох зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулах байдал ихсэж байгаа.

Түүнчлэн шүүгч нэг талын гаргасан хүсэлтийг 7 хоногийн дотор, нөгөө талын гаргасан хүсэлтийг 1 сарын дотор шийдвэрлэсэн гэж зохигчид ёс зүйн хороонд шүүгчид холбогдуулан гомдол гаргасныг шүүх талуудад “тэгш хандах” зарчмыг зөрчсөн ёс зүйн зөрчил гэж үзэн сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болгосон тохиолдол байна⁶.

Хүсэлт гаргах эрхийг хэрэгжүүлэх нь зохигчдын хувьд иргэний эрх зүйн хамгаалалтын хүрээнд зөрчигдсөн эрхээ шүүхээр хамгаалуулах, сэргээн тогтоолгох, хохирлоо арилгуулах зэрэг зорилгыг агуулгах боловч үндэслэлгүйгээр хүсэлтийг давтаж гаргах, хэрэгжих боломжгүй, ойлгомжгүй, тодорхойгүй хүсэлт гаргаж, хугацаа авах, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг удаашруулах арга хэрэгсэл болгох үүднээс, идэвхгүй байр сууринаас хүсэлтийг гаргадаг нь шүүхийн практикт хэвийн үзэгдэл болж байна.

Жишээлбэл, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаанд гаргасан гомдолтой хэргийн хувьд, нэхэмжлэгч талаас шүүх хуралдаанд өмгөөлөгч авах, төлөөлөгч томилох, өмгөөлөгч, төлөөлөгч нь хэргийн материалтай танилцах, өмгөөлөгч, төлөөлөгчөө олон дахин солих гэх мэтээр хэрэг маргаанаа шийдвэрлүүлэх, зөрчигдсөн эрхээ хамгаалуулах хүсэл зоригоос илүүтэйгээр шүүхийн шийдвэрийг биелүүлэхгүй байх, шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг удаашруулах зорилготой байдаг. Өөрөөр хэлбэл, шүүх зохигчдын мэтгэлцэх эрхийг хангах зорилгоор гаргаж байгаа

хүсэлт бүрийг шийдвэрлэсний үр дүнд шүүх хуралдаан ихээр хойшилж байгааг дараах судалгаагаар харж болох бөгөөд шүүхийн ажлын ачаалал нэмэгдэж, эдийн засгийн зардал нэмэгдэх хандлагатай байна.

Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхэд 2017.12.25-ны өдрөөс 2020.06.01-ний өдрийг хүртэлх хугацааг хамруулан шүүх хуралдаан хойшлогдсон байдлыг судалж үзвэл, давхардсан тоогоор нийт 13,440 шүүх хуралдаан товлогдож, 6379 шүүх хуралдаан хойшилсон байна. Үүний үндэслэл, шалтгааныг тодруулбал:

1. нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлснээр хариуцагч гардаж авах, хариу тайлбар, нотлох баримт гаргах эрхийн дагуу 450 удаа,
2. хэргийн материалтай танилцах эрхийн дагуу 796 удаа,
3. гэрч, гуравдагч этгээд оролцуулах эрхийн дагуу 510 удаа,
4. өмгөөлүүлэх эрхийг хангаж 918 удаа,
5. хэргийн оролцогч, өмгөөлөгчөөс хамааралтай хүндэтгэн үзэх шалтгаан /өвчтэй, чөлөөтэй байх, хуралдаан давхцах, ар гэрт нь гачигдал гарах гэх мэт/-аар 981 удаа,
6. шинжээч томилуулах хүсэлтийн дагуу 253 удаа,
7. нотлох баримт бүрдүүлж өгөх, цуглуулах, гаргуулах хүсэлтийн дагуу 1038 удаа,
8. Шүүгч, шүүх бүрэлдэхүүнээс татгалзах эрхийн дагуу 125 удаа,
9. Шүүхийн санаачилгаар /ИХШХШТХ-ийн 38.9, 111.3, 131.2/ 213 удаа,
10. бусад үндэслэл /шүүгчийн захирамж, тогтоолд тухайн шүүхэд гомдол гаргах, ИХШХШТХ-ийн 90.5, зохигчид эвлэрэн хэлэлцэх, шүүх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болох, шүүгч өвчтэй, чөлөөтэй болох, нийтийг

⁶ Шүүхийн ёс зүйн хорооны Ажлын алба, Шүүхийн ёс зүйн хороонд ирүүлсэн гомдлын статистик мэдээлэл /2014-2019/, 2020.06.02.



хамарсан онцгой нөхцөл байдал бий болсон, шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах арга хэмжээ авхуулах, шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолын заалт биелэгдээгүй, хэргийн оролцогч согтуурсан ундаа хэрэглэсэн буюу хэвийн бус байдалтай хуралд ирэх, төлөөлөгчийн итгэмжлэлийг тодруулах, шүүх хуралдааны тов өөрчлөх, иргэдийн төлөөлөгч оролцуулах гэх мэт/-ийн дагуу 1095 удаа буюу нийт товлогдсон хурлын 47,5 хувь нь хойшилжээ⁷.

Хэргийн оролцогчид хэргийн материалтай танилцах, өмгөөлөгч авах, өөрсдийн хувийн шинжтэй шалтгаануудыг үндэслэл болгон шүүх хуралдааныг 2695 удаа хойшлуулсан байдал нь нэлээдгүй хувийг эзэлж байх бөгөөд энэ нь хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа сунжруулах, хэргийн нэг талыг залхаах, шүүхэд хүндрэл учруулах зэргээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлэхгүй, идэвхгүй байр сууринаас оролцож байгааг харуулжээ.

Нөгөө талаар, хэргийн оролцогчид нь нотлох баримт бүрдүүлж өгөх, цуглуулах, гаргуулах, гэрч асуулгах, шинжээч томилуулах хүсэлтийн дагуу 1701 удаа шүүх хуралдааныг хойшлуулсан байгаа нь мэтгэлцэх зарчмын хүрээнд хэрэг маргааныг хуулийн хугацаанд шийдвэрлүүлэх, хэргийн бодит үйл баримтыг тогтоолгох хүсэл зоригийн үүднээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дэмжлэг үзүүлж, идэвхитэй байр сууринаас оролцсон гэж үзэхээр байна.

Дээрх судалгаанаас үзвэл, шүүх хэргийн оролцогчдын гаргасан хүсэлтийг хүлээн авч, шүүх хуралдааныг хойшлуулж

⁷ Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх. ИРГЭН-1 программ.

шийдвэрлэсэн байгаа нь тэдний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь субъектив эрхийг хангасантай холбоотой байна. Өөрөөр хэлбэл, зохигчид хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд дахь субъектив эрх /актив эрх/-ээ хүсэлтээр дамжуулан хэрэгжүүлэхдээ идэвхгүй байр сууринаас оролцож, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сунжруулах, хэргийн хугацаа хэтрэх, хугацаа хэтэрсэн хэргийн тоо өсөх, шүүхийн ачаалал нэмэгдэх, хэргийн оролцогчдыг чирэгдүүлэх, эдийн засгийн үр ашиггүй байдлыг бий болгох зэргээр шүүх болон хэргийн оролцогчдод сөрөг үр дагавруудыг үүсгэж байна.

Иймд зохигчдын эрх, үүргийг тайлбарлах, тодорхой болгох, зохигчдын хүсэлт гаргах эрхийг хангах, сонсох, шийдвэрлэх, хэргийн нөхцөл байдлыг тодруулах, хэргийг хуулийн хугацаанд үндэслэл бүхий шийдвэрлэхэд ИХШХША-нд урьдчилсан хэлэлцүүлгийн шүүх хуралдааныг явуулах шаардлага үүсч байна. Үүнтэй холбоотой зохицуулалтыг судлахад Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйлд шүүгч нотлох баримт хасуулах, захиргааны актын биелэлтийг түдгэлзүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүгчээс урьдчилсан хуралдаанаар хэлэлцүүлэн шийдвэрлэх шаардлагатай гэж үзсэн бусад асуудлыг хэлэлцэх зорилгоор, талуудын хүсэлтийг үндэслэн урьдчилсан хэлэлцүүлгийн шүүх хуралдааныг явуулахаар зохицуулжээ⁸.

Энэ талаарх зарим улс орны зохицуулалтаас үзэхэд, ХБНГУ-д иргэний хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа аман болон бичгийн гэсэн хоёр хэлбэрээр

⁸ Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль УБ., 2016 он.



явагддаг байх ба, Иргэний хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль-ийн⁹ 1 дүгээр номын 3 дугаар бүлгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа гэсэн 1 дүгээр дэд хэсгийн 128-165 дугаар зүйлд “аман хэлэлцүүлгийн шүүх хуралдаан”-ы талаар буюу аман хэлэлцүүлэг явуулах үндэслэл, зарчим, шүүх хуралдааныг явуулах хэлбэр, шийдвэрийн талаар цогц байдлаар хуульчилсан байна.

ОХУ-ын Иргэний процессын хуулийн 152, 153 дугаар зүйлүүдэд шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шүүх хуралдааны талаар зохицуулсан байх бөгөөд уг шүүх хуралдааныг шүүгч дангаар удирдан явуулж, талуудын эрх, үүргийг тайлбарлан өгч, зохигчдыг шүүх хуралдаанд бэлтгэх зорилгоор хэргийн үйл баримт, нөхцөл байдалтай холбоотой нотлох баримтууд хангалттай цугларсан эсэх, шаардлага, татгалзалтай холбоотой шинээр нотлох баримт цуглуулах шаардлага байгаа эсэх талуудын үйлдлийг тодруулах, баталгаажуулах зорилготой байна¹⁰.

Энэхүү аман хэлэлцүүлэг буюу урьдчилсан хэлэлцүүлгийн шүүх хуралдаанаар хэргийн ямар үйл баримт маргаантай байгаа, энэхүү маргаантай үйл баримтад хамааралтай ямар нотлох баримтыг зохигчдын хэн нь хэрхэн, яаж бүрдүүлж болох талаар тэдний хүсэлт, тайлбарыг сонсож, нотлох баримт бүрдүүлэхтэй холбоотой эрхээ хэрэгжүүлэх, мэтгэлцэх боломжоор хангахаас гадна, энэхүү шүүх хуралдаанаар зохигчид эрх, үүргээ тодорхой нарийвчлан мэдсэнээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд идэвхтэй байр сууринаас оролцох нөхцөл бүрдэх юм.

⁹ https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html

¹⁰ https://www.wto.org/english/thewto_e/acc_e/rus_e/wtacrus58_leg_62.pdf

Нөгөө талаар зохигчдыг үүргээ биелүүлэх, шүүх хуралдаанд өөрийн зүгээс зохих бэлтгэл ханган /өмгөөлөгч сонгох, хэргийн материал танилцах гэх мэт/ оролцох, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд хариуцлагатай байх механизм болох, зохигчид хүсэлтээ цаг хугацааны хувьд хязгааргүйгээр гаргах нөхцөлийг зохицуулах ач холбогдолтой.

5.Дүгнэлт, санал.

Энэхүү илтгэлийн хүрээнд ИХШХША-ны оролцогчдын эрх зүйн байдал, субъектив эрх, үүрэг, зохигчдын гаргасан хүсэлт, түүнийг шийдвэрлэхтэй холбогдсон хүндрэл, бэрхшээлийн талаар хөндсөн бөгөөд дараах байдлаар ИХШХШТХ-ийг боловсронгуй болгох дүгнэлт, саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 105 дугаар зүйлийн 105.2-т хүндэтгэн үзэх шалтгаантай бол хүсэлтийг шүүх хуралдаанд гаргах зохицуулалт байгаа хэдий ч ИХШХША-ны оролцогчид субъектив эрхээ хэрэгжүүлэх хүрээнд хүсэлт гаргахдаа шүүх хуралдаанаас өмнө гаргаснаар хуулийн 76 дугаар зүйлийг хэрэгжүүлэх, шүүх хуулийн хугацаанд хэрэг маргааныг хянан шийдвэрлэх нөхцөл бүрдэнэ.

Өөрөөр хэлбэл, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 70 дугаар зүйл, ХБНГУ Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль, ОХУ-ын иргэний процессын хуулиудад заасны дагуу шүүх хуралдааны аман хэлэлцүүлэг буюу урьдчилсан хэлэлцүүлэг явуулах зохицуулалтыг хуульд нарийвчлан, шинээр зохицуулах зайлшгүй шаардлагатай.

2.Зохигчдын гаргасан хүсэлтийг шүүхээс ямар хугацаанд шийдвэрлэх хугацаа хуульд тодорхойгүй байна.



Шүүх зохигчдын гаргасан хүсэлтийг хэрэг маргааны онцлог, хүсэлтийн агуулга, нотолгооноос хамаарч шинжлэн судлах шаардлагатай болдог. Иймд хүсэлтийг хянан шийдвэрлэх боломжит хугацааг тодорхой зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа шуурхай явагдах, нөгөө талаар хэргийн оролцогчдыг чирэгдүүлэхгүй байх нөхцөл бүрдэх бөгөөд ИХШХША-г тодорхой, эмх цэгцтэй дараалалтай байлгахад ач холбогдолтой, шаардлагатай гэж үзэж байна. Иймд хуульд хугацааны талаар тодорхой зохицуулалтыг оруулах нь зүйтэй.

3.Зохигчдын “хүсэлт гаргах субъектив эрх” нь иргэний хэрэг үүсгэх, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг өөрчлөх, дуусгавар болгох, үргэлжлүүлэх эсэхээ өөрсдийн хүсэл зоригийн үндсэн дээр шийдвэрлэдэг хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны чухал эрх болно. Гэвч зохигчдын хязгааргүйгээр эдэлж байгаа хүсэлт гаргах эрхийг шүүхийн урьдчилсан хэлэлцүүлгийн шатанд шийдвэрлэж байх, хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар шүүх хуралдаан дээр хүсэлтийг хэрэг хянан шийдвэрлэх 60 хоногийн хугацаан дотроо гаргах, түүнээс дээш хугацаанд зохигчид ямар нэгэн байдлаар хүсэлт гаргасан бол зохигчдын хариуцлага болгож шүүх хуралдаан хойшлох бүрт хүсэлт гаргасан талаас нэмэлт зардал буюу нэхэмжлэлийн үнийн дүнгээс тодорхой хувиар тооцон шүүхийн зардал гаргуулдаг боломжийг судлах, энэ талаарх зохицуулалтыг хуульд тусгах шаардлага байгааг цаашид анхаарах нь зүйтэй байна.

Ашигласан материал

1. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль УБ., 2002 он.

2. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль УБ., 2016 он.
3. Д.Баярсайхан. Эрх зүйн онол УБ., 2018 он.
4. Ж.Наранцацрал. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй /тайлбар, схем/. УБ., 2003 он.
5. З.Мөнхжаргал. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй, тусгай анги. УБ., 2010 он.
6. Хамтын бүтээл. Процессын эрх зүй, онол, туршлага. УБ., 2013, 2014 он.
7. Йоахим Кают. Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй. УБ., 2015 он.
8. Б.Буянхишиг. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх эрх зүй УБ., 2021 он.
9. Б.Буянхишиг. Иргэний эрх зүйн удиртгал УБ., 2018 он.
10. Улсын дээд шүүх. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дэлгэрэнгүй тайлбар. УБ., 2014 он.
11. Юпп Ёоахимски. Монгол улсын Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн тайлбар. УБ., 2004 он.
12. Чингэлтэй дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2017-2020 оны хойшлуулсан хэргийн талаарх судалгаа.
13. <https://www.legalinfo.mn/>
14. https://www.gesetze-im-internet.de/englisch_zpo/englisch_zpo.html
15. <https://toli.query.mn/>



АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ
/ОРЧУУЛГА/

А.НЭМҮҮЛЭН¹

¹ УДШ-ийн дэргэдэх ШССМХ-ийн Иргэний эрх зүйн секторын судлаач



АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ

А.НЭМУҮЛЭН. УДШ-ийн дэргэдэх ШССМХ-ийн Иргэний эрх зүйн секторын судлаач

Жексон эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байгууллагын нэхэмжлэлтэй Миссисипи мужийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Томас Доббс-д холбогдох Үндсэн хуулийн эрх зүйн маргаан

Санамж: Шүүхийн шийдвэр гарах үед тухайн хэрэгтэй холбогдуулан шийдвэрийн хураангуйг (товч удиртгал) бэлтгэдэг. Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг бүрэн орлохгүй боловч иргэд олон нийтэд мэдээлэл хүргэх зорилгоор хэвлэл, мэдээллийн ажилтан бэлтгэдэг болно.

Дугаар. 19-1392. 2021 оны 11 сарын 01-нээс 2022 оны 6 сарын 24-ны өдөр

ХЭРГИЙН ТОВЧ

Талууд: Миссисипи мужийн эрүүл мэндийн газрын мэргэжилтэн Томас Доббс нь дээд шүүхэд давж заалдах гомдол гаргаж, улмаар Жексон эмэгтэйчүүдийн байгууллага нь хариуцагчаар татагдсан.

Асуудал: Үр хөндөлт хийлгэх эрхийг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн эсэх асуудлыг авч хэлэлцсэн.

Үндэслэл: Үндсэн хуульд үр хөндөлт хийлгэх эрхийг шууд хуульчлаагүй. Үүнд, аливаа эрхийг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрсөн эсэхийг тогтооходоо үндэсний түүх, уламжлалыг шалгуур болгон авч үзэх шаардлагагүй хэмээсэн, учир нь үр

хөндөлт хийлгэх эрхийг үндэсний түүх, уламжлалын хүрээнд хүлээн зөвшөөрч байгаагүй гэж дүгнэсэн.

Дүгнэлт: Дээд шүүх үр хөндөлт хийлгэх эрхийг Үндсэн хуулиар хүлээн зөвшөөрөөгүй болохыг дурдаж, улмаар муж тус бүр шүүхийн жишгээ цаашид дагахгүй болсон бөгөөд өөр өөрийн орны хуулиар зохицуулах эрх нь нээлттэй үлдсэн.

Миссисипи мужийн Үр хөврөлийн хөгжлийн тухай хуульд “Хэрэв жирэмсний хугацаа нь 15-н долоо хоногос дээш хугацаа өнгөрсөн болох нь тогтоогдсон, мөн эмнэлгийн яаралтай тусламж болон ургийн хүнд хэлбэрийн гажиг тохиолдсоноос бусад тохиолдолд тухайн хүн санаатайгаар эсхүл зориудаар үр хөндөлт хийлгэх... эсхүл жирэмсэн эмэгтэй үр хөндүүлэхийг хориглоно” гэж үр хөндөлт хийлгэх эрхтэй болохыг хуульчилсан. Хариуцагч Жексон эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байгууллагын үр хөндөлтийн эмнэлгийн эмч нарын нэг нь Миссисипи мужийн хуулийг Үндсэн хуульд нийцсэн тул үр хөндөлт хийлгэх эрхтэй болохыг буюу тэр тусмаа *Poy (Roe v. Wade)*-ийн үр хөндөлт хийлгэх эрхийг зөрчсөн гэх үндэслэлээр Холбооны дүүргийн шүүхэд гомдол гаргасан. Үр хөндөлтийг 15-н долоо хоногос хязгаарлаж, үр хөндөлтийг уг



хугацаанаас өмнө хийлгэснээр ургийн амьдрах чадварыг хориглож байгаа тул энэ шүүхийн жишгийг зөрчиж байна гэж үзэн Холбооны дүүргийн шүүх нь хариуцагчийн талд хялбаршуулсан журмаар хэргийг шийдвэрлэж, Үр хөврөлийн хөгжлийн тухай хуулийн хэрэгжилтийг бүр мөсөн зогсоохыг үүрэг болгосон. Улмаар давж заалдах шатны 5 дугаар тойргийн шүүх тус шийдвэрийг хэвээр үлдээн шийдвэрлэсэн байна.

Дээд шүүхийн өмнөх шатны шүүх болох давж заалдах шатны шүүхэд гомдол гаргагч Жексон эмэгтэйчүүдийн эрүүл мэндийн байгууллагын үр хөндөлтийн эмнэлгийн эмч нарын нэг нь "Роу, Кейси" нарын хэргийг буруу шийдвэрлэсэн гэж үзсэн бөгөөд Үр хөврөлийн хөгжлийн тухай хууль нь эрх зүйн зохистой байх шаардлага (rational-basis/шүүхийн хяналтад байгаа)-ыг хангаж буй учир Үндсэн хуулийн зарчимд тус хууль нь нийцсэн гэх үндэслэлээр өөрийн байр сууриа хамгаалсан байна.

Шийдвэрлэгдсэн байдал: АНУ-ын Үндсэн хууль нь үр хөндөлт хийлгэх эрхийг зохицуулаагүй учир Роу, Кейси нарын шүүхийн жишгийг хүчингүй болгосноор мужийн төрийн төлөөлөгчдөд үр хөндөлтийн тухай хуульчлах эрх мэдлийг буцаан олгохоор шийдвэрлэсэн. Үүнд:

а) Үндсэн асуудлын хүрээнд АНУ-ын Үндсэн хууль нь үр хөндөлт хийлгэх эрхийг хүлээн зөвшөөрсөн (зүй зохистой тайлбарын хүрээнд, properly understood) эсэх асуудлыг авч хэлэлцэх бөгөөд Кейсигийн¹ хэргийн хувьд энэ асуудлыг Үндсэн хуулийн хүрээнд авч үзэлгүйгээр зөвхөн жишиг шийдвэрүүдийг

баримтлах зарчим (Stare decisis зарчим)-ыг үндэслэсэн байгаа нь Роу-ийн² байр суурийг зөвтгөх оролдлого болсон гэж үзсэн. Гэхдээ шүүхийн жишгийг баримтлах зарчим (Stare decisis)-ыг зөв хэрэглэхийн тулд, Роу-ийн баримталсан үндэслэлүүдийг дахин нягталж үзэх шаардлага бий болсон ба улмаар энэхүү шийдвэрээр Кейсид орхигдсон асуудлуудыг авч үзнэ.

1) Нэгдүгээрт, Үндсэн хуулийн "Арван дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт"-д тусгагдсан "эрх чөлөө" (liberty) нь тодорхой субъектив эрхийг хамгаалдаг эсэхийг тогтоодог шүүхийн тогтсон стандартыг хянаж үзсэн байна. Үүний үр дүнд, Үндсэн хууль үр хөндөлт хийлгэх эрхийг шууд хуульчлаагүй хэдий ч зөвтгөх боломжтой хэд хэдэн зохицуулалтуудад тусгалаа олсон гэж ойлгож иржээ. Роу үр хөндөлт хийлгэх эрхийг Үндсэн хуулийн нэгдэх, дөрөв дэх, тав дахь, ес дэх болон арван дөрөв дэх нэмэлт өөрчлөлтөөс урган гарах хувь хүний нууцыг хамгаалах эрх (right to privacy)-ийн нэг хэсэг гэж үзсэн. Харин Кейси үр хөндөлт хийлгэх эрхийг Арван дөрөв дэх нэмэлт өөрчлөлтийн зохих журмын заалт (Due Process Clause)-аар хамгаалагдсан эрх чөлөө (liberty)-ний нэг хэсэг гэж үзэх онолыг л зөвхөн өөрийн шийдвэрийн үндэслэлээ болгосон байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийг үр хөндөлт хийлгэх эрхтэй гэж үзсэн бусад шүүхүүд ч мөн Арван дөрөв дэх нэмэлт өөрчлөлтийн Тэгш эрхийг хамгаалах заалтыг (Equal Protection Clause) эш татан үндэслэж хэргийг шийдвэрлэсэн байна. Гэвч уг үзэл баримтлал болох дээд шүүхийн жишгүүдээр үр хөндөлт хийлгэх эрхийг

¹ 1992 онд Кейси нь үр хөндөлт хийлгэх эрхтэй гэх байр суурийг илэрхийлсэн бөгөөд уг хэргийг шийдвэрлэсэн дээд шүүхийн жишгээр үр хөндөлт хийлгэх эрхтэй болохыг баталгаажуулсан.

² 1973 онд Роу нь АНУ-ын Үндсэн хуулийн дагуу эмэгтэйчүүд үр хөндөлт хийлгэх эрхтэй гэж АНУ-ын дээд шүүхэд гомдол гаргаснаар төрийн ямар нэг хязгаарлалтгүйгээр энэхүү эрхээ хэрэгжүүлэх бүрэн эрхийг нь олгосон.



хуульчилсан зохицуулалтад үүнийг хүйсийн ялгаатай sex-based classification байдалд тулгуурласан зохицуулалт биш гэж үзсэн тул тухайн хуулиудад өндөр хяналт тавих шаардлагагүй (Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулиар) гэх дүгнэлтийг гаргажээ. Харин Үндсэн хуульд зохицуулахаас илүүтэй үр хөндөлтийг зохицуулах журмууд болон хоригуудыг эрүүл мэнд, аюулгүй байдлын бусад арга хэмжээний нэгэн адил хяналтын ижил шалгуураар зохицуулах нь зүйтэй гэж үзжээ.

2) Хоёрдугаарт, Үр хөндөлт хийлгэх эрх нь ¹үндэсний түүх, уламжлал, зан заншилтай нарийн холбогддог эсэх болон ²Журамласан эрх чөлөө (Ordered Liberty)-ний үндсэн бүрэлдэхүүн хэсэг мөн эсэх талаар авч үзсэн. Үүний үр дүнд үр хөндөлт хийлгэх эрхийг үндэсний түүх, уламжлал, зан заншилтай нарийн холбоогүй гэж үзэн Кейсигийн үндэслэлээ болгосон Арван дөрөв дэх нэмэлт өөрчлөлтийн зохих журмын заалтын дагуу (Due Process Clause) баталгаажсан “эрх чөлөө” (liberty)-г материаллаг болон процессын журмаар хамгаалдаг эсэхийг авч хэлэлцэх талаарх асуудлыг чухалчилж байгаа хэдий ч уг асуудал нь удаан хугацааны турш маргаан дагуулсаар ирсэн байдаг. Тухайлбал, шүүхийн жишгээс үзвэл зохих журмын заалт (Due process clause) нь хоёр төрлийн материаллаг эрхийг хамгаалдаг ба эдгээр нь эхний найман нэмэлт өөрчлөлтөөр баталгаажсан эрхүүд юм. Эдгээр эрхүүд нь Үндсэн хуульд шууд тусгагдаагүй хэдий ч хүний суурь эрхүүд (заншлын эрх зүйд хамаарах ойлголт буюу нийгмийн тогтсон хандлагаар үүссэн эрхүүдийг ойлгоно) гэж ойлгогддог эрхүүд юм. Аливаа эрхийг дээрх хоёр төрлийн журмын аль нэгэнд нь хамаарах эсэхийг тогтоохдоо тухайн үндэсний түүх, уламжлалтай нарийн

холбоотой эсэхийг авч үзэх шаардлагатай болдог. Өөрөөр хэлбэл энэ хэргийг шийдвэрлэхэд “эрх чөлөө” (liberty) гэсэн ганцхан уг нэр томъёог үндэслэлээ болгож болохгүй. Тийм учраас, Арван дөрөв дэх нэмэлт өөрчлөлтийн зохих журмын заалт (Due process clause)-аар хамгаалагдсан “эрх чөлөө” (liberty)-ний шинэ бүрэлдэхүүнийг (new component of the liberty) хүлээн зөвшөөрөх эсэх явдлыг тогтоохын тулд уг эрхийг түүхийн хувьд хүлээн зөвшөөрч буй эсэх талаас нь зайлшгүй авч үзэх шаардлагатай. “Эрх чөлөө” (liberty) хэмээх үгийн агуулгыг тайлбарлахдаа Арван дөрөв дэх нэмэлт өөрчлөлт яг юуг хамгаалдаг болохыг, мөн Америкчууд ямар эрх чөлөө эдлэх ёстойг шүүх өөрийн дур зоргоор шийдэх шүүхийн эрх чөлөөний тухай үзэлтэй хольж хутгах явдлаас ангид байх нь зүйтэй. Тийм ч учраас шүүхүүд Үндсэн хуульд тусгагдаагүй эрхийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзаж ирсэн.

Журамласан эрх чөлөө (Ordered Liberty)-ний тухай ойлголтын гол бүрэлдэхүүн хэсгийг тогтоодог гэх үндэсний түүх болон уламжлалыг удирдлагаа (guided by) болгосноор Үндсэн хуулийн Арван дөрөв дэх нэмэлт өөрчлөлт нь үр хөндөлт хийлгэх эрхийг хамгаалдаггүй гэж шүүх дүгнэсэн байна. 20 дугаар зууны хоёр дугаар хагас хүртэл Америкийн эрх зүйд үр хөндөлт хийлгэх эрхийг хүлээн зөвшөөрсөн ямарваа нэгэн зохицуулалт байгаагүй. Аль ч мужийн Үндсэн хуульд үр хөндөлт хийлгэх эрхийг хүлээн зөвшөөрсөн заалт тусгагдаагүй. Өөрөөр хэлбэл, *Роу* -ийн хэрэг шийдвэрлэгдэх хүртэл холбооны эсхүл мужийн ямар ч шүүх үр хөндөлт хийлгэх эрхийг хүлээн зөвшөөрөөгүй. Мөн онолын ямар ч ном зохиолд энэ талаар дурдаагүй. Чухамдаа жишгийн эрх зүйд үр хөндөлт нь дор хаяж л



жирэмслэлтийн аль нэг шатандаа (үр хөндөлтийг 3 шатанд хуваасан) хууль бус гэж тооцогддог байсан. 1800-аад он буюу үр хөндөлтийн эрүүгийн хариуцлагыг өргөжүүлэх хүртэл америкийн эрх зүй жишгийн эрх зүйг дагасаар ирсэн. Харин “Арван дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт” батлагдах үед, мужуудын дөрөвний гурав нь жирэмсний аль ч үе шатны үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцдог болсон. Энэ нөхцөл байдал *Роу*-ийн хэргийг шийдвэрлэсэн дээд шүүхийн шийдвэр гарах хүртэл үргэлжилсэн. *Роу*-г энэхүү түүхийг үл тоож, мөн буруу тайлбарласан гэж үзсэн бөгөөд үүнтэй хамааралтайгаар *Кейси Роу*-ийн буруу дүгнэсэн түүхэн судалгааг дахин авч үзэхээс татгалзсан.

Иймд дээр дурдсанчлан Үндсэн хуулийн “Арван дөрөв дэх нэмэлт, өөрчлөлт”-өөр хамгаалагддаг уг асуудлыг үндэслэлтэй эсэхийг тогтоохын тулд шүүхийн нотолгооны стандартад түүх хамааралгүй гэж хариуцагч маргасан. Хууль зүйн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгч *Роу*-ийн үндэслэл буюу “жишгийн эрх зүйд үр хөндөлт нь гэмт хэрэгт тооцогддог байсан эсэх нь эргэлзээтэй” гэх үндэслэлийг давтан өөрийн дүгнэлтээ гаргасан байна. Гэхдээ, жишгийн эрх зүйн нэрт хуульчид болох Бракстон, Кокс, Хэйл, Блэкстоун (Bracton, Coke, Hale, Blackstone) бүгд хожуу үеийн үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцно гэж үзсэн. Түүнчлэн энэхүү үйл явдлаас үүдэн жирэмсэн эмэгтэйн амь нас эрсдэхэд хүрвэл тухайн үр хөндөлт хийж буй эмч гэмт хэрэг үйлдсэнд тооцно хэмээн тэмдэглэн үлдээжээ.

Хууль зүйн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгч жишгийн эрх зүйд ураг хөдөлж эхлэхээс өмнөх үеийн үр хөндөлтөд эрүүгийн хариуцлага ногдуулаагүй байгааг онцолсон бөгөөд түүхэн уламжлал үр хөндөлт хийлгэх эрхийг

хүлээн зөвшөөрдөг гэсэн тайлбарыг гаргасан байна. 18-р зууны сүүлч, 19-р зууны эхэн үед мужууд эрт үеийн үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцдоггүй байсан нь мужууд үүнийг гэмт хэрэгт тооцох бүрэн эрхгүй байсан гэж ойлгож болохгүй юм. Өөрөөр хэлбэл, мужуудад үр хөндөлтийг гэмт хэрэгт тооцох эрх нь бүрэн нээлтэй байсан гэж ойлгоно.

Роу болон *Кейси*-г дэмжигчид үр хөндөлт хийлгэх эрхийг түүхэн уламжлалтай нарийн холбоотой гэх үндэслэлээс гадна илүү өргөн хүрээний тогтсон эрхийн бүрдэл хэсэг мөн болох талаар авч үзсэн. *Роу* уг эрхийг хувь хүний нууцыг хамгаалах эрх гэж нэрлэсэн, харин *Кейси* хэргийн шийдвэрт үүнийг “хувь хүний эрхэмсэг оршихуй болон бие даасан хараат бус байдлын үндсэн хэсэг болох”, мөн “дотно харилцаа болон хувийн сонголт хийх” эрх чөлөө гэж тодорхойлсон. Үүгээр журамласан эрх чөлөө (Ordered liberty) нь хоорондоо холбогдох эрх ашгуудын зөрчилдөөнийг тодорхойлсон заагийг тавьж өгсөн. *Роу*, *Кейси* нар үр хөндөлт хийлгэхийг хүссэн ¹эмэгтэйн эрх ашиг болон ²тургийн “боломжит амьдрал” хоёрын хооронд тодорхой тэнцвэрт байдлыг бий болгосон. Гэвч мужуудын иргэд эдгээр эрх ашгуудыг ялгаатай гэж үзэцгээсэн байна. Журамласан эрх чөлөөний талаарх үндэсний түүхэн ойлголт болон уламжлалын хувьд төрийн төлөөлөгчид үр хөндөлтийг зохицуулах бүрэн эрхтэй буюу тэдний энэхүү зохицуулах бүрэн эрхэд саад болох зүйл байхгүй хэмээсэн.

3) Эцэст нь, Шүүх үр хөндөлт хийлгэх эрхийг бусад жишиг шийдвэрээр дэмжигдэх илүү өргөн хүрээний тогтсон эрхийн бүрдэл хэсэг болохыг хүлээн зөвшөөрсөн эсэхийг авч үзсэн. Шүүх үр хөндөлт хийлгэх эрхийг илүү өргөн хүрээний эрхээр зөвтгөх боломжгүй



бөгөөд үр хөндөлт хийлгэх эрхийг илүү өргөн хүрээний бие даасан байдал болон хувь хүний оршихуйн үзэл баримтлалаар зөвтгөх гэсэн оролдлогуудыг хүлээн авах ямар ч боломжгүй гэж дүгнэсэн байна. Ийм өндөр түвшний хийсвэр эрхүүд нь хууль бус хар тамхины хэрэглээ, биеэ үнэлэх явдлыг суурь эрхэд тооцон хүлээн зөвшөөрөх боломжийг нээж өгнө гэжээ. *Роу*, *Кейси* нарын үндэслэлээ болгож буй эрхүүд болон үр хөндөлт хийлгэх эрхийн ялгах гол ялгааг авч үзвэл *Роу* үр хөндөлтийг ургийн “боломжит амьдрал” гэж нэрлэсэн бөгөөд харин энэхүү маргааны тухайд авч үзвэл “төрөөгүй хүний амь” гэж хуульд тусгасан байдаг. Өөрөөр хэлбэл энэ нь ургийг устгаж буйгаараа буюу ургийн хүн болох, амьдрах чадварыг үгүй хийж, мөн түүний эрхийг зөрчиж буйгаараа үр хөндөлт нь өөр хэмээсэн байна.

Роу болон *Кейси*-д эшлэгдсэн шийдвэрүүдийн алинд ч үр хөндөлттэй холбоотой ёс суртахууны асуудлыг чухалд тооцож маргаагүй. Улмаар эдгээр шүүхийн жишгүүд нь үр хөндөлт хийлгэх эрхийг дэмжих боломжгүй гэсэн үг. Энэ шүүхийн дүгнэлтээр бусад шүүхийн жишгүүдийг ямар нэгэн байдлаар үгүйсгэхгүй гэсэн бөгөөд харин Үндсэн хууль үр хөндөлт хийлгэх эрхийг олгоогүй гэдгийг дурдах нь зүйтэй гэжээ.

б) Жишиг шүүхийн шийдвэрийг баримтлах зарчим (*Stare decisis* зарчим)-ын хүрээнд *Роу* болон *Кейси*-гийн байр суурийг зайлшгүй үргэлжлүүлэн дагах шаардлагатай гэж үзэхгүй. Харин шүүхийн жишгийг баримтлах зарчим (*stare decisis* зарчим) нь шүүхийн шийдвэрийн хүрээнд арга хэмжээ авсан хүмүүсийн эрх ашгийг хамгаалахад чухал үүргийг гүйцэтгэдэг хэмээн ойлгох нь зүйтэй. Мөн үүнтэй холбоотойгоор “шүүхийн тогтоосон жишгээс эсрэг байр

суурьтай байснаар хэргийн оролцогч талууд болон шүүх байгууллагын хянан шийдвэрлэх ажиллагааны эцэс төгсгөлгүй урсах зардлыг хэмнэх боломжтой болдог”. Үүний дүнд “Шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг явуулахад бодитой, хүлээн зөвшөөрөгдсөн шударга байдалд эерэг нөлөө үзүүлдэг” гэсэн байна. Түүнчлэн өнгөрсөн хугацаанд өөрийн байр сууриа хамгаалж шүүхэд хандан хэргээ шийдвэрлүүлсэн хүмүүсийн хувьд тэдний шийдвэрийг хүндэтгэх замаар шүүхийн өөрийгөө хэт дөвийлгөх үзэлд хязгаар тавьж өгдөг боловч шүүхийн жишгийг баримтлах зарчим (*stare decisis*) нь “өөрчлөгдөшгүй хатуу хориг” гэсэн үг биш юм. Ялангуяа Үндсэн хуулийг тайлбарлах явцад шүүхийн жишгийг баримтлах зарчим (*stare decisis*) нь байж болох хамгийн багаар илрэн гардаг.

Шүүх шүүхийн жишгийг хүчингүй болгосон шийдвэр гаргах үедээ авч үзэх шаардлагатай хэд хэдэн хүчин зүйлийг тодорхойлсон. Иймд *Роу* болон *Кейси* нарын хэргийн шийдвэрт холбогдох хэсгийг үгүйсгэхэд дор дурдсан таван хүчин зүйл ихээхэн нөлөө үзүүлсэн.

1) Шүүхийн алдаа /The nature of the Court's error/.

Фергюсоний эсрэг *Плесси* (*Plessy v. Ferguson*)-ийн хэргийн адилаар, *Роу*-ийн шийдвэр туйлын буруу байсан бөгөөд уг шийдвэр гарсан өдрөөсөө эхлэн Үндсэн хуультай маш хурцаар зөрчилдсөн. Харин *Кейсид* үндэсний хэмжээнд үүссэн санал зөрөлдөөнөө залруулах боломжийг олгосон боловч *Кейси Роу*-ийн уг алдааг улам даамжруулж, өөрийнхөө ялалтыг тунхагласан. Хохирогч тал буюу ургийн амьдрах эрхэд төрийн хамгаалалтыг нэмэгдүүлэхийг эрмэлзэж байсан хүмүүс, төрийн эрх баригчид өөрсдийн үзэл санаанд нийцүүлсэн



бодлого хэрэгжүүлэхийг ятгах ямар нэг боломжгүй болж, шүүх Роу-ийн шийдвэрийг эс зөвшөөрсөн олон тооны америкчуудад хандан энэхүү хэргийг хааснаараа ардчилсан үзлийг хумьсан үйл явц болсон нь гол асуудал болсон.

2) Үндэслэлтэй байдал /The quality of the reasoning/

Үндсэн хуулийн эх бичвэр, түүх, болон шүүхийн жишгийг эш таталгүйгээр яг л хууль тогтоож буй мэт жирэмслэлтийн нарийвчилсан дүрмүүд (Жирэмслэлтийн гурван үе шат)-ийг Роу улс үндэстэнд тулгасан. 1968 онд хүчин төгөлдөр мөрдөгдөж байсан мужийн хууль тогтоомжийн дийлэнх хэсгийг Роу анзаарч хараагүй нь гайхмаар ба жишгийн эрх зүйд тулгуурлан дурдсан зүйлс нь ерөнхийдөө үндэслэлгүй байсан ба түүнээс гадна үүнд түүхэн судалгаа хийсний дараа уг үзэл санааг хууль тогтоох байгууллагаас гаргах боломжтой гэсэн нотлох баримтыг олж тогтоохдоо холбогдох олон цогцолборыг нуршиж дурдсан. Гэсэн хэдий ч үндэслэлээ болгосон эх сурвалж нь ямар учраас Үндсэн хуулийн үзэл баримтлалыг тодорхойлж байна вэ гэдэгт тайлбар хийгээгүй. Шүүхийн жишгүүдийн хувьд шүүх олон төрлийн баримтыг эш татсанаар Үндсэн хуульд тусгагдсан “хувь хүний нууцад халдашгүй байх эрх”-ийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Харин Роу-гийн хэргийн шийдвэрт уг мэдээллийг олон нийтэд тархахаас хамгаалах, төрийн оролцоогүйгээр хувийн чухал шийдвэрийг гаргах, мөн хэрэгжүүлэх эрхийг хамтатгаж авч үзсэн. Роу-гийн хэргийн шийдвэрт дурдсан “боломжит амьдрал” хэмээн томъёолсон ойлголтын нөлөөг тодорхойлоход бусад шийдвэрүүдийн аль нь ч үр хөндөлттэй холбоотой онцлог шинжид хамаарахгүй гэж үзэн, улмаар шүүх

хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны нэгдмэл ойлголтын хүрээнд дүгнэхдээ уг асуудлыг энэ цаг үе, нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцсэн асуудал болохыг тодорхойлсон. Энэ асуудлыг хууль тогтоох эрх мэдэлтнүүд ихэвчлэн аливаа ашиг сонирхлыг хязгаарлах тохиолдолд авч үздэг. Роу-ийн хэрэгт үндэслэсэн схем нь хууль тогтоомжтой адил харагдах боловч үүнд тулгуурлан шүүх үндэслэл бүхий тайлбар гаргасан бөгөөд үүний дутагдалтай тал нь Роу ургийн амьдрах эрхийн эрт болон хожуу үеийн үр хөндөлтийн хоорондын гол ялгааг тодорхойлж чадаагүй гэжээ. Кейси, Роу-гийн хэргийн шийдвэрт “үндсэн дүрэм” гэж нэрлэсэн “дур зоргоороо амьдрах эрх чөлөө” гэх томъёоллын үндсэн дээр үр хөндөлтийн эрхийг зөвтгөхийг оролдсон боловч философичид болон ёс зүйч нар төдийлөн дэмжээгүй. Иймэрхүү төрлийн маргаантай холбогдох гол асуудал нь ургийн амьдрах эрх буюу түүний хэлбэр цаг хугацаа өнгөрөх тусам өөрчлөгдөж томордог. Энэ нь анагаах ухааны дэвшил, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмж зэрэг хүчин зүйлүүдээс ихээхэн хамааралтай болдог.

Кейси болон Роу нарын хэргийн хооронд 20 жилийн зай байгаа хэдий ч, Кейси Роу-ийн хэрэгт баримталсан суурь үзэл санаатай адил санааг дэвшүүлсэн байдаг, харин Роу-ийн бусад холбогдох ихэнх үндэслэлийг дурдахаас эрс татгалзсан байдаг. 1992 оны энэ хэрэгтэй холбогдох үндэсний маргаан дэгдэхэд дээд шүүх хувь хүний эрхэд хамаарах бүх эрхээс татгалзаж, харин үр хөндөлтийн эрхийг “Арван дөрөвдүгээр нэмэлт, өөрчлөлт”-ийн зохих журмын талаарх заалтын дагуу үндэслэлтэй гэв. Хэргийн үндсэн шийдвэр нь Роу-ийн хэрэгт гаргасан жирэмсний гурван үе шат бүхий схемд шүүмжлэлтэйгээр хандаж



үгүйсгэсэн нь шинэ бөгөөд ойлгомжгүй байснаар “хүсээгүй жирэмслэлт”-ын асуудлыг шалгуур болгосон. Өөрөөр хэлбэл, эмэгтэйчүүдийн асуудлыг түрүүнд тавьсан шийдвэр гаргасан. Кейсигийн хэргийн шийдвэрээр Роу-ийн уг суурь үзэл санааг дахин нотлох болон үгүйсгэхээс татгалзсан. Роу-ийн хэргийн шийдвэр хангалттай үндэслэлгүй байсан учир үүний эсрэг байсан хүмүүс уг үзэл санаагаа нотлохыг шаардаж, мөн үр хөндөлт хийлгэх эрхийг Роу-ийн шийдвэрийн өмнө нь гарсан шүүхийн жишгүүдээс өөр бусад нэмэлт үндэслэл байгаагүй тул няцаасан. Үндсэн хуулийн хэм хэмжээ, түүхэн хандлага болон шүүхийн жишигт урьд өмнө тохиолдож байсан баттай ямар ч үндэслэлд тулгуурлалгүй уг асуудлыг хөндсөн гэж дүгнэжээ.

3) Хэрэгжүүлэх боломжтой байх /workability/

Нөгөөтээгүүр шүүхийн жишгийг хүчингүй болгох эсэхийг шийдэх асуудалд Роу-ийн боловсруулсан дүрэм нь урьдчилан таамаглаж болохуйц, харилцан уялдаатайгаар асуудлыг ойлгож, хэрэгжүүлэх боломжтой эсэхэд гол асуудал тавигдана. Кейсигийн хэргийн шийдвэр дэх “хүсээгүй жирэмслэлт”-ийн үр дагаврыг хэрэгжүүлэх боломж хангалтгүй байсан. Кейсигийн шийдвэрийг дэмжиж буй олонх нь “хүсээгүй жирэмслэлт”-д хамаарах нэмэлт гурван дүрмийг тогтоон тайлбарлахыг оролдсон боловч уг дүрмүүд нь тухайн асуудалд тус тусын асуудлыг үүсгэж эхэлсэн. Кейсигийн хэргийн шийдвэрт энэхүү шинэ дүрмийг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй байсан нь мөн энэ тохиолдолд гарч ирсэн. Давж заалдах шатны шүүхүүдийн жишиг шийдвэр нь Кейсигийн хэрэгт зөвшөөрөгдсөн үндэслэл буюу хууль бус

хязгаарлалт хоёрын “хоорондын зааг”-ыг “нарийвчлан харах боломжгүй”-г нотлон харуулсан. Кейсигийн хэргийн талаас зөрчилдөөн бүхий маш урт жагсаалтыг гаргасан бөгөөд “хүсээгүй жирэмслэлт”-ийн үр дагаврын асуудлыг авч үзсэн тохиолдолд хууль, эрх зүйн зарчмуудыг “нэг мөр, урьдчилан таамаглаж болохуйц, зогсолтгүй хөгжүүлэх”-д сөрөг нөлөө үзүүлнэ гэж үзжээ.

4) Хуулийн бусад салбарт үзүүлэх нөлөө /Effect on other areas of law/

Роу болон Кейси нарын хэрэгт олон чухал ач холбогдолтой үндэслэл гаргасан ч хоорондоо уялдаа холбоогүй эрх зүйн онолуудыг гажуудуулах нөхцөлд хүргэхүйц тайлбарууд тогтоогдсон тул эдгээр шийдвэрүүдийг хүчингүй болгоход гол нөлөөг үзүүлсэн.

5) Сөргөөр хөндөгдөх ашиг сонирхлууд /Reliance interests/

Роу болон Кейси нарын хэргийн шийдвэрийг хүчингүй болгох нь тодорхой ашиг сонирхлуудад сөрөг нөлөө үзүүлэхгүй. Кейси үр хөндөлт хийлгэх нь ихэнхдээ төлөвлөөгүй үйл явдал байдаг учир уламжлалт ашиг сонирхлууд үр хөндөлт хийлгэх эрхтэй холбоогүй гэж шийдвэрлэсэн. Үүний оронд Кейси илүү хийсвэр ашиг сонирхлыг чухалчилж үзсэн бөгөөд тухайн ашиг сонирхлыг “хүмүүс өөрсдийн дотно харилцаа болон өөрсдийн амьдралын үзэл баримтлал, байр суурийн талаарх сонголтуудыг хийдэг нь... жирэмслэлтээс хамгаалах хэрэгсэл нь амжилтгүй болсон тохиолдолд” ба “Эмэгтэйчүүд нөхөн үржихүйн амьдралаа зохицуулах чадвар нь улс орны эдийн засаг болон нийгмийн амьдралд эрх тэгш оролцох эрхийг бий болгодог” гэж тайлбарласан. Маргааны талууд үр хөндөлтийн эмэгтэйчүүдийн



эрхэд үзүүлэх нөлөө түүнчлэн ургийн байр суурийн талаар санал зөрөлдөөнтэй үзэл баримтлалуудыг дэвшүүлсэн. Кейси ургийн байр суурь болон эхийн ашиг сонирхлыг харьцуулах гэж оролдсон нь “шүүх өөрийн нийгэм болон эдийн засгийн талаар үзэх баримтлалаа хууль тогтоогчид тулгаж болохгүй” гэсэн Үндсэн хуулийн суурь зарчмаас хазайсан явдал болсон.

Харин Хууль зүйн яамны итгэмжлэгдсэн төлөөлөгч нь *Роу, Кейси* нарын шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд зохих журмын заалтаар (Due Process Clause) хамгаалагдах бусад эрхүүдэд сөрөг нөлөө үзүүлнэ гэх тайлбарыг хийсэн. Гэсэн хэдий ч энэ шүүхийн шийдвэр нь зөвхөн үр хөндөлт хийлгэх үндсэн эрхийн асуудлыг л авч үзэж буй бөгөөд өөр ямар ч эрхэд хамаарахгүй гэдгийг дурдах нь зүйтэй. Тиймээс үр хөндөлт хийлгэх эрхтэй холбоогүй бусад эрхүүдэд энэ шүүхийн шийдвэр нь ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно. Рр. 63–66.

с) Кейсигийн талаас өөр нэг чухал асуудлыг тодорхойлсон нь *Роу*-ийн хэрэгтэй адил зөрчилдөөн бүхий “үр хөндөлт хийлгэх эрхтэй гэх маргаан”-тай шийдвэрийг хүчингүй болгосон тухайд улс төрийн эсвэл олон нийтийн үзэл санаа нөлөөлсөн. Гэвч шүүх нийгэмд тулгарч буй чухал асуудлуудын талаарх энэ шийдвэрт хөндлөнгөөс нөлөө үзүүлэхийг хэрхэвч хүлээн зөвшөөрч болохгүй. Шүүхийн жишиг тохиолдлууд нь шүүхийн жишиг шийдвэрийг баримтлах зарчмын ердийн зарчмуудад захирагддаг бөгөөд энэ зарчмын дагуу шүүхийн жишиг шийдвэрийг баримтлах зарчим (*stare decisis*)-ыг шалгуур болгож байгаа боловч зайлшгүй дагах шийдвэр биш гэж ойлгоно хэмээв. Хэрэв тус дүрэм, журам нь байхгүй байсан бол,

Плесси (*Plessy*)-тэй холбогдох хэргийн адилаар алдаатай шүүхийн шийдвэрүүд нь хууль хэвээр үлдэх байсан. Шүүхийн үүрэг бол хуулийг тайлбарлах, олон жилийн турш баримтлалаа болгосон жишиг шийдвэрийг баримтлах зарчим (*stare decisis*)-уудыг хэрэгжүүлэх, мөн хэргийг үүний дагуу шийдвэрлэх явдал болно.

d) Шүүхийн жишгийн дагуу үр хөндөлтийг зохицуулах төрийн зохицуулалт нь Үндсэн хуультай холбогдох маргаантай байх тохиолдолд энэ асуудалд шүүхийн хяналтыг (*rational-basis review*) хэрэгжүүлэхэд тохиромжтой. Үр хөндөлт хийлгэх эрх нь Үндсэн хуулиар олгогдсон эрх биш хэдий ч үүнээс үүдэн мужууд үр хөндөлтийг үндэслэл бүхий шалтгаанаар (*legitimate reasons*) зохицуулж болох бөгөөд уг зохицуулалтыг Үндсэн хуулиар эсэргүүцэж байгаа тохиолдолд шүүх “тэдний нийгэм, эдийн засгийн итгэл үнэмшлийг хууль тогтоох байгууллагын шийдвэрээр орлуулах боломжгүй гэх дүгнэлт”-д хүрсэн. Тухайн хууль тогтоомж нь нийгмийн чухал ач холбогдолтой, ёс суртахууны агуулгатай байсан ч хүчин төгөлдөр хэрэгжинэ. Үр хөндөлтийг зохицуулах хууль нь бусад холбогдох эрүүл мэнд, халамжийн тухай хуулиудын нэгэн адил “хүчин төгөлдөр байна. Хууль тогтоох байгууллага нь төрийн хууль ёсны ашиг сонирхолд үйлчилнэ гэж үзэх үндэслэлтэй байх ёстой. Дугаар, 320.

Миссисипи мужийн Үр хөврөлийн хөгжлийн тухай хууль нь Миссисипи мужийн хууль тогтоох байгууллагын тусгай шийдвэрээр хүлээн зөвшөөрөгддөг бөгөөд үүгээр муж “ургийн амьдрах эрхийг хамгаалах”-ийг илүүд үздэг. §2(b) (i). Эдгээр хууль ёсны ашиг сонирхол нь “Үр хөврөлийн хөгжлийн тухай хууль”-ийн оновчтой үндэслэл болж байгаа



бөгөөд хариуцагчийн Үндсэн хуулийн маргаан үндэслэлгүй болж байна.

е) Үр хөндөлт нь ёс суртахууны гүн гүнзгий асуудлыг хөнддөг. Үндсэн хуулиар мужийн иргэд үр хөндөлтийн эрхийг хуульчлах болон хориглохыг эсэргүүцдэггүй. *Роу* болон *Кейси* нарын хэрэгт холбогдох шийдвэрийг төрийн эрүүл мэндийн салбарын эрх бүхий төлөөлөгчдөд энэхүү эрх мэдлийг буцаан олгож байна.

945 F.3d 265 дахин хэлэлцүүлэхээр буцаасан.